14. Хөвсгөл.С. “Монголын нууц товчоон” дахь эмэгтэйчүүдийн дүрийн тухай. f.18.-Х. 192-201. /Хэл зохиол судлал Т.ХХII, F.1-20. Ред П.Хорлоо, УБ,; ШУАХ. 1988. - 215х. - 13,5 хх./
15. “Монгол Хатад” I. түүхийн их шастир. Төрт ёс, Хаадын Сан. Улаанбаатар, 2023.
16. Сэржээ,Ж. “Монгол хүний нэрийн лавлах толь” Улаанбаатар 1991.
17. “Саган Сэцэн Эрдэнийн товч”, сонгомол эх бэлтгэж, хөрвүүлэг, тайлбар хийсэн. М.Баярсайхан, эрхлэн хэвлүүлсэн Ш.Чоймаа, “Соёмбо пресс” хэвлэлийн газар. УБ. 2015. тал-90.
18. Лувсанданзан. “Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршвой” Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хийсэн Ш.Чоймаа. УБ. 2015. тал-57.
19. “Үүлэн зардас” Монголчилж, Оршил бичсэн Б.Ринчен. Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо. Улаанбаатар. 1963 он. тал-5-23.



ХАВСРАЛТ

мөр тэтгэж, мөр дарж бичсэн бичлэг

(Хавсралт 1)	(Хавсралт 2)	(Хавсралт 3)
 1 Чингис хаган-ыг 2 Сартагул иргэн	 1 Мөнх тэнгэр-ийн хүчү-дүр ... 4 Ирэд Варанс-а /Францаа/	 1 Өлзийт султан үгэ ману 2 Иридиваранс султан-а /Францын султанд/

ПЕРФОРМАТИВ ҮЙЛ ҮГ ӨГҮҮЛЭМЖИЙН ИЛЛОКУТИВ ХҮЧИЙГ ИЛТГЭХ НЭГЭН ХЭРЭГСЭЛ БОЛОХ НЬ

Магистр Л.Алтантуяа

(ОУУБИС. ХНУС)

altantuya.l@ulaanbaatar.edu.mn

Түлхүүр үгс: хэлэх үйл, дискурсийн онол, локутив үйл, перлокутив үйл, прагматик хэл шинжлэл, пропозицын утга, интенционал шинж, конвенционал шинж, үнэний шалгуур, амжилтын нөхцөл

Хураангуй: Английн гүн ухаантан, логикч Ж.Остины үндэслэсэн хэлэх үйлийн анализын гурван түвшинт схемийн гол шинэлэг тал нь иллокутив үйлийн тухай ойлголт болон түүнтэй холбоотой иллокутив үүргийн (хүчний) тухай утга зүйн ойлголт юм. Учир нь эдгээр ойлголтууд нь уламжлалт хэл шинжлэл, сонгодог илтгэх урлагийн аль алинд нь нарийн тодорхойлж чадаагүй хэлэх үйл болон өгүүлэмжийн утгын талуудыг тусгасан ойлголтууд юм. Бид энэхүү өгүүлэлдээ өгүүлэмжийн иллокутив хүчийг илтгэдэг хэлний хэрэгслүүд дотроос перформатив үйл үгийг сонгон авч, түүний үгийн сан-утга зүйн онцлогийг тодорхойлох оролдлого хийлээ.

Abstract

The question addressed in this paper is illocutionary force indicating devices, namely performative verbs. In classic speech act theory, the illocutionary force is the speaker's intent in saying something (e.g. to make a bet or to apologize). There are certain linguistic devices in any language – illocutionary force indicating devices (IFIDs) – that indicate either that the utterance is made with a certain illocutionary force, or else that it constitutes the performance of a certain illocutionary act. IFIDs show how the proposition is to be taken, that is, what illocutionary act the speaker is performing while uttering the sentence. In English, IFIDs may include word order, stress, punctuation, the mood of the verb, and illocutionary verbs (e.g. bet, apologize).

Most often discussed in the speech act literature are illocutionary verbs, also referred to as performative verbs because they constitute the performance of the action they describe when uttered in a performative utterance using performative syntax. Austin observed that use of the first person and simple present tense of the verb are important



clues that an utterance is performative in nature. That is, when the first author of this chapter says, “I apologize,” it constitutes an act of apology, whereas “Susan apologizes” and “I apologized” lack performative force; these are simply descriptions of a habitual activity and of a past action, respectively.

УДИРТГАЛ

Хэлэх үйлийн онолын гол ойлголт болох иллокутив үйл нь (англ. illocutionary act) яригчийн коммуникатив зорилгыг (англ. communicative intention) тэмдэглэдэг ойлголт юм. Иллокутив үйлийн загварыг Ж.Сёрль, Ж.Остин нар *what one does in saying that p*, харин К.Бах, Р.Харниш нар *S does such-and-such in C* гэж томъёолсон байдаг. Иллокутив үйлийн мөн чанар хэлэх үйлд түүний иллокутив хүч буюу иллокутив үүргийн (англ. illocutionary force, function – IF) хувиар илэрдэг. Иллокутив хүч нь нарийн нийлмэл ойлголт юм. Ж.Сёрль, Д.Вандервекен нар иллокутив хүчийг “иллокутив зорилго, түүнд хүрэх арга зам, иллокутив хүчний эрчим, пропозицын утгын нөхцөлүүд, урьдчилсан нөхцөлүүд, чин сэтгэлийн илрэл, түүний эрчим гэсэн долоон элементийн эмх цэгцтэй дараалал” (Сёрль & Вандервекен, 1986, хуудсд. 261-262) гэж тодорхойлжээ. Өгүүлэмжийн пропозицыг хэрхэн хүлээн авч, ойлгох ёстойг буюу иллокутив хүч нь юу болохыг иллокутив хүчний хэрэгслүүд (англ. illocutionary force indicating devices) илтгэдэг. Тухайлбал, англи хэлэнд өргөлт, аялга, цэг цэглэл, үйл үгийн төлөв, үгсийн дараалал, перформатив үйл үг зэрэг нь ийм хэрэгслийн тоонд ордог.

Эдгээрийн дотор бидний судалгааны ажлын сэдэв болох перформатив үйл үг чухал байр суурь эзэлдэг. Прагматик хэл шинжлэлд перформатив гэдэг ойлголт нь англи хэлний үйлдэл, үйл хэрэг (action) гэсэн үгтэй гол төлөв хамт хэрэглэгддэг гүйцэтгэх, биелүүлэх гэсэн утга бүхий *perform* гэдэг үйл үгнээс гаралтай бөгөөд ямар нэг зүйлийг хэлж байхдаа үйлдлийг нь давхар гүйцэтгэж байгааг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл хэлж байгаа зүйл, үйлдэл хоёр давхцаж байхыг хэлнэ.

ҮНДСЭН ХЭСЭГ

Хэлэх үйл ажиллагааны хамгийн бага нэгж болох хэлэх үйлийг прагматик хэл шинжлэлийн хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг болох хэлэх үйлийн онолд судалдаг. Хэлэх үйл нь ярих болон түүнтэй нэгэн зэрэг явагддаг сонсож ойлгох үйл явцыг хамарсан бичвэр бүтээх хоёр талт үйл явц юм.

Иллокутив зорилготой байдаг нь хэлэх үйлийн үндсэн шинж юм. Нэг өгүүлбэр хэлэгдэж байгаа хам сэдвээсээ хамаарч яригчийн өөр өөр иллокутив зорилгыг илэрхийлэх чадвартай. Бид бусадтай харилцахдаа өгүүлбэр хэлэнгээ өгүүлэх эрхтнээ ажиллуулах, хүн, юм, газар орныг дурдах, харилцагчдаа мэдээлэл өгөх, түүнийг хөгжөөх юм уу цухалдуулах, гуйх, амлах, тушаах, уучлал гуйх, зэмлэх гэх мэт үйлдлийг хийдэг бөгөөд эдгээр үйлдэл нь яригчийн санаа зорилгоос үүдэлтэй байдаг гэж хэлэх үйлийн онолд үздэг (Searle J. R., What is a speech act?, 1965, p. 221).

Хэлэх үйл бол нэлээд нарийн үзэгдэл юм. Хэлэх үйлийн онолд ямар ч хэлэх үйлийг гурван түвшинтэй гэж үздэг. Энэ талаар Э.Равдан “Хэлэх цогц үйлийг уг юм, үзэгдлийн шинж чанарыг хэлний бүрэлдэхүүн талаас нь авч үзсэнийг нь илэрхийлэх (locutive), өгүүлэх зорилго, хэл ярианы нөхцөлийн талаас нь авч үзсэнийг нь үл илрэх (illocutive), хэлэх үйлийн үр дүн, сонсогч хүнд нөлөөлөл талаас нь үзсэнийг нөлөөлөн илэрхийлэх (perlocutive) хэв шинж хэмээн ангилан нэрлэв” гэж тэмдэглэсэн байдаг (Равдан, 2009, хууд. 181).

Хэлэх үйлийг юм ярих үйл гэж үзвэл локутив үйл болдог. Авиа дуудах, үг ашиглах, тэдгээрийг хэл зүйн дүрмийн дагуу холбох, үгээр юмс, үзэгдлийг ялган тэмдэглэж, тэдгээрийн шинж чанар болон харьцааг нэрлэх үйлийг нийтэд нь локутив үйл гэнэ. Хэл шинжлэл хэлэх үйлийн чухамхүү энэ локутив талыг л удаан хугацааны турш судалж ирсэн юм. Ингэхдээ өгүүлэмжийг хэрэглээний бодит нөхцөлөөс нь ангид авч үзэн, авиа зүйд дуу авианы талыг, үгийн сангийн судлалд үгсийн бүрэлдэхүүнийг, өгүүлбэр зүйд үг өгүүлбэрт холбогдох дүрмийг судалж, утга зүйд өгүүлбэрийн утгыг түүгээр илэрч байгаа бодомжийн объектив утга буюу пропозицын утгаар тайлбарлаж иржээ.

Гэхдээ хүн дуу хоолойныхоо өнгөнөөс таашаал авах, үгээс өгүүлбэр бүтээх, тэр ч байтугай өгүүлбэрт зүгээр нэг хүн, юм, газар орныг дурдаж, тэдгээрийн шинж чанарыг нэрлэх гэж ярьдаггүй. Хүн ярих явцдаа асуух, хариулах, мэдээлэх, батлан хэлэх, анхааруулах, албан тушаалд томилох, шүүмжлэх гэх мэт хэлний бус зорилго бүхий өөр нэг үйлдэл хийдэг. Хэлэх үйлийг хэлний бус зорилго нь үүднээс авч үзвэл иллокутив үйл болдог. Хэлэх үйлийн онолд хэлэх үйлийн чухамхүү энэ талыг нь онцлон судалдаг. Зарим иллокутив зорилгыг дохио зангаа, нүүрний хувирлаар илэрхийлж болдог бол тангараглах, амлах зэрэг үйлийг хэлэхийн оролцоогүйгээр хийх боломжгүй. “Тангараглах”, “амлах” зэрэг нь перформатив үйл үг бол, зарим иллокутив үйл үг (жишээлбэл, “биеэ магтах”, “сүрдүүлэх”, “доромжлох”) перформатив байдлаар хэрэглэгддэггүй.

Вербал юм уу вербал бус хэлбэрээр илэрч байгаа иллокутив хүчийг нь



сонсогч ойлгож чадаж гэмээнэ тухайн хэлэх үйлийг амжилттай болсон гэж үздэг. Үүний зэрэгцээ иллокутив хүч нь шууд бус, далд тойруу замаар илэрсэн, сонсогч харилцааны ур чадварынхаа тусламжтай ойлгох боломжтой дам хэлэх үйл цөөнгүй тааралддаг. Үүнийг жишээн дээр авч үзье. Хэлний харилцаанд мөрдөгддөг эелдгийн зарчим захирах хүсэх үйлийг зөөлрүүлж, дам шинжтэй болгох нь олонтоо. Жишээ нь, “Чи надад цай хийгээд өгч чадахгүй биз?” гэх мэтийн сонсогчоос тийм хэцүү биш зүйлийг хийж чадах эсэх тухай баймж утгатай асуултын цаад санаа нь хүсэлт юм. “Би ганцаараа баймаар байна” гэдэг хүсэл илэрхийлсэн өгүүлбэр ч дээрхийн адил “Намайг ганцааранг минь орхи” гэсэн хүсэлт байж болох талтай. Дам хэлэх үйл хэлэнд нэгэнт хэвшин тогтсон журамд захирагддаг. Тухайлбал, баймж утгатай асуулт ихэнхдээ гуйлт илэрхийлэх жишээтэй.

Хэлэх үйлийн анализын иллокутив түвшинд өгүүлэмжийн утгыг иллокутив үүрэг (F), пропозиц (P) гэсэн хоёр үндсэн хэсэгт хувааж үзэн, F(P) гэсэн томъёогоор илэрхийлдэг. Жишээ нь, Хичээлээ хийхгүй юм уу? гэдэг өгүүлэмжийн пропозицын утга нь “хичээлээ хий”, иллокутив үүрэг нь “асуух” бол Хичээлээ хий! гэдэг өгүүлэмжийн хувьд пропозицын утга нь дээрхтэй адил боловч иллокутив үүрэг нь өөр буюу “захирах хүсэх” байна. Би хичээлээ хийнэ гэж амлаж байна гэдэг өгүүлэмжийн утга “би хичээлээ хийнэ” гэсэн пропозиц болон “амлах” иллокутив үүргээс тогтож байгаа бол Тэр хичээлээ хийнэ гэж амласан гэдэг өгүүлэмжийн утга “тэр хичээлээ хийнэ гэж амласан” гэсэн пропозиц болон “мэдээлэх” иллокутив үүргээс бүрдэж байна.

Хэл ярианы тусламжтайгаар хүн орчин тойрондоо, тэр дундаа эн тэргүүнд ярилцагчийнхаа ухамсарт нөлөөлөх замаар тодорхой үр дүнд хүрч байдаг. Гэхдээ энэ үр дүн нь яригчийн өмнөө тавьсан хэлэхийн бус зорилгод нийцэх нь ч бий, нийцэхгүй нь ч бий. Хэлэх үйлийг бодит үр дагавар талаас нь авч үзвэл перлокутив үйл болдог. Жишээлбэл, Хичээлээ хий! гэж ээжийгээ хэлэхэд хүү нь компьютер тоглоом тоглуулсангүй гэж уурлаж нэг болно, гэрийн даалгаврыг нь аль хэдийн шалгачихсан мөртлөө түүнийгээ мартчихаад ингэж хэлбэл гайхаж нэг болно. Хэлэх үйл ажиллагааны нэг тал болох перлокутив үйл болон түүний үр дүн болох перлокутив нөлөө гэдэг ойлголтыг эрт дээр үеэс илтгэх урлагт хэл яриагаар сонсогчдын сэтгэл зүйд нөлөөлөх үр дүнтэй арга замуудтай холбон судалж иржээ.

Перлокуц нь хэлэх үйлийн онолд хамгийн бага судлагдсан ойлголт хэвээр байна. Перлокутив үйл нь “объектод үзүүлэх хэлэхийн нөлөө (орос. ситуация С1) бөгөөд уг нөлөөгөөр үүсч болох нөхцөл байдлын (орос. ситуация С2) субъект нь дээр дурдсан объект юм” (Почепцов, 1986, хууд. 54). Перлокуц гэдэг ойлголтыг ойлгох, тайлбарлах, хэрэглэх гэсэн 3 хэсгээс тогтдог ойлгох үйл явцын салшгүй

хэсэг болох “хэрэглээ” гэдэг уламжлалт герменевтикийн ойлголтоос үүсэлтэй гэж үздэг. Хэрэглээ нь герменевтик үйл явцын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болдгийн адил перлокуц нь хэлний харилцахуйн тогтолцоонд өөрийн гэсэн байр суурь эзэлдэг. Гэсэн хэдий ч перлокуцыг хэлэх үйлийн бүрэлдэхүүнд оруулах эсэх талаар хэл шинжлэлчид санал нэгдэж хараахан чадаагүй байна.

Ж.Остин иллокутив үйл гэдэг ойлголтыг нарийн тодорхойлоогүй, зүгээр асуух, хариулах, мэдээлэх, батлан хэлэх, анхааруулах, албан тушаалд томилох, шүүмжлэх г.м. тод томруун жишээ дурдаад, хэл бүхэнд иймэрхүү үйлдэл нэрлэсэн бүлэг үг байдаг гэжээ (Остин, 1986, хууд. 86). Улмаар тэрээр иллокутив үйлийн локутив болон перлокутив үйлээс ялгарах шинжийг нь олж тогтоосон байна. Тухайлбал, иллокутив үйл нь локутив үйлээс интенционал шинж буюу тодорхой санаа зорилготой холбоотой байдгаараа, перлокутив үйлээс конвенционал шинж буюу иллокутив үйлийг амжилттай гүйцэтгэх нөхцөл болсон тодорхой дүрэмд захирагддагаараа ялгагддаг байна (Стросон, 1986, хуудсд. 131-132). Ийм дүрмийн тоонд хэлний дүрэм багтдаг. Ямар ч хэлэнд хэлэх үйлийн иллокутив үүргийг шууд болон шууд бус замаар заадаг перформатив үйл үг, үгсийн дараалал, хоолойны өнгө, дайвар үг, дохио зангаа, цэг цэглэл, өгүүлэмжийн нөхцөл байдал гэх мэт хэрэгслүүд байдаг.

Эдгээрийн дотор өгүүлэмжийн иллокутив үүргийг шууд илтгэж байдаг онцгой бүлэг өгүүлбэр чухал байр суурь эзэлдэг. Тэдгээрийг перформатив өгүүлбэр (лат. *performo* – үйлдэж байна) гэж нэрлэдэг (Verschueren, 1988, pp. 6-8). Перформатив гэдэг ойлголт болон нэр томъёог анх Ж.Остин хэрэглэсэн юм. Өгүүлэмжийн хэрэглээтэй холбоотой дээрхтэй төстэй ажиглалтуудыг Д.Юм болон хэл шинжлэлчдийн дундаас Э.Бенвенист дискурсийн онолынхоо хүрээнд хийж байжээ. Э.Равдан “Уламжлалт хэл шинжлэлд хэл нь аливаа юм, үзэгдлийг тодорхойлох үндсэн үүрэгтэй гэж үздэг бол сүүлийн жилүүдэд түүнийг нарийвчлан хэл яриагаар тодорхой үйлдэл хийж гүйцэтгэсэн үйлийн илэрхийллийг хэлний чухал нэгэн үүрэг болгон үзэх болжээ. Энэ нь олон хэлэнд чухамдаа үйлийн илэрхийлэл (*performative utterance*)-тэй юуны түрүүнд холбоотой” (Равдан, Олон хэлний хэв шинжийн судлал, 2017, хууд. 179) гэж тэмдэглэжээ. Перформатив нь дараах шинжтэй байна. Үүнд:

1. Перформатив өгүүлбэрийн үйл үг ихэвчлэн идэвхтэй хэв дээр цаг заах төлөвийн одоо цагийн 1-р биеийн ганц тоон дээр байдаг (“Би тангараглаж байна”).
2. Перформатив өгүүлбэр бол үйлдэл, үйл явдалд дүйж байдаг хэллэг мөн. Перформатив өгүүлбэр нь үйл явдлыг мэдээлдэг биш, агуулгаараа үнэн



юм уу худлаа биш, харин өөрөө үйлддэг буюу амжилттай, амжилтгүй (бүтэлгүй) байдаг үйлдэл юм (Отгонбаяр & Өлзийсайхан, 2019).

3. Перформатив нь нийгмийн хэм хэмжээ буюу хууль дүрэмд, өөрөөр хэлбэл, хэм хэмжээнүүдийн тогтолцоонд тулгуурладаг учир (Жишээлбэл, захирах, захирагдах ёс үйлчилдэг нийгэмд л тушаал гэдэг ойлголт байна) тухайн нийгэмд нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээнд нийцсэн үр дагавартай байдаг (Ярцева, 1998, хуудсд. 372-373).

Перформатив өгүүлбэрийн үгийн сан-утга зүйн бүтцийн үндэс нь иллюкутив үйл үг буюу хэл яриа заасан үйл үгийн бүлэгт багтдаг, үгийн сангийн утга нь хэлэх үйлдлийг гүйцэтгэх зорилго болон нөхцөлүүдийг заасан бүрэлдэхүүн хэсгүүдээс тогтдог гуйх, баяр хүргэх, батлан хэлэх, амлах г.м. үйл үг юм. Гэхдээ иллюкутив үйл үг орлоо гээд л өгүүлбэр перформатив өгүүлбэр болчихгүй. Үүнээс гадна уг үйл үгийг перформатив хэлбэрт буюу нөхцөл байдлыг дүрслэхийн тулд биш, харин тухайн өгүүлбэрээр яригч ямар хэлэх үйл үйлдэж байгааг тодруулахын тулд хэрэглэсэн байх шаардлагатай байдаг (Падучева, 2010, хууд. 19). “Дээрх өгүүлбэрүүдийн нэгэн онцлог нь хэл ярианы тодорхой орчин нөхцөлд үйл үгийн нөхцөлөөр илэрхийлж болох эзэн биетэй болон эзэн биегүй өгүүлбэрийн бүтэцтэй дүйж болно. Монгол, англи зэрэг цөөнгүй хэлэнд дээрх хэв шинж бүхий өгүүлбэр нь гол төлөв нэгдүгээр биеийн төлөөний нэрээр илэрсэн өгүүлэгдэхүүн, хоёрдугаар биеийн төлөөний нэрээр илэрсэн шууд бус тусагдахуун, хэд яриа цааш үл өрнөх үйл үгийн одоо цагийн хэлбэр болон тодотгон тодорхойлсон монгол хэлэнд: үүгээр, англи хэлэнд: hereby, орос хэлэнд: тем самым дайвар үгээс гадна тулган шаардаагүй утга бүхий баймж, үйл үгийн нэршсэн хэлбэр (үйлт нэр) агуулсан байна” (Равдан, Олон хэлний хэв шинжийн судлал, 2017, хууд. 179).

Перформатив өгүүлбэрийн утга зүйн өвөрмөц онцлог буюу ерийн хүүрнэх өгүүлбэрээс ялгагдах ялгаа нь ерийн хүүрнэх өгүүлбэр бодит байдлыг дүрслэх, мэдээлэх, батлан хэлэх г.м. зорилгоор хэрэглэгддэг бол перформатив өгүүлбэр яригчийн хийж байгаа үйлдлийг дүрслэх бус, харин яг ямар үйлдэл хийж байгааг нь илтгэн харуулахын тулд хэрэглэгддэгт оршдог. Би таныг зурж байна гэсэн ерийн хүүрнэх өгүүлбэрийн референт нь хэлэх үйлээс хамааралгүй оршиж байгаа тодорхой нэг нөхцөл байдал байгаа бол Би амлаж байна гэсэн перформатив өгүүлбэрийн референт нь тухайн өгүүлбэрээр илэрч байгаа хэлэх үйл өөрөө болж байна. Товчхон хэлбэл, перформатив өгүүлбэр өөрийгөө нэрлэх шинжтэй (орос. автореферентность) байдаг гэсэн үг юм (Падучева, 2010, хууд. 20). Хэрэглээнд орсон ерийн хүүрнэх өгүүлбэр үнэн, худлыг нь ярьж болох өгүүлэмж болдог бол, ердийн хам сэдэвт орсон перформатив өгүүлбэрийн үнэн, худлыг ярих боломжгүй байдаг.

Тухайлбал, Би таныг зурж байна гэдэг өгүүлбэр нөхцөл байдлаасаа хамаарч үнэн, худлын аль нэг нь байна. (Энэ өгүүлбэрт Нээрээ тийм байна эсвэл Үгүй, та өөр хүн зурж байна гэж хариулж болно). Тэгвэл Би амлаж байна гэдэг перформатив өгүүлбэрийн цагаа олсон, олоогүйг л ярихаас үнэн худлыг ярих боломжгүй юм. Гэхдээ перформатив өгүүлбэр хэлэгдэх бүрдээ үнэн буюу өөрөө үнэнээ батлах прагматик шинжтэй (англ. *pragmatic self-verification*) (Karttunen, 1977, p. 4) гэж үзэх нь ч бий.

ДҮГНЭЛТ

Прагматик хэл шинжлэлийн үндсэн судлагдахуун болох хэлэх үйлийн үндсэн шинж бол түүний иллокутив хүч юм. Түүнийг нь сонсогч ойлгож чадаж гэмээнэ тухайн хэлэх үйлийг амжилттай болсон гэж үздэг. Аливаа хэлэнд өгүүлэмжийн иллокутив хүчийг тодорхойлоход сонсогчид тусалдаг хэлний болон хэлний бус хэрэгслүүд байдаг. Тэдгээрийн дотор идэвхтэй хэв дээр, цаг заах төлөвийн одоо цагийн 1-р биеийн ганц тоон дээр байгаа, хэл яриа заасан үйл үгийн бүлэгт багтдаг перформатив үйл үг чухал байр эзэлдэг болох нь бидний судалгаанаас харагдлаа.

НОМ ЗҮЙ

1. Karttunen, L. (1977 оны January). Syntax and semantics of questions. *Linguistics and philosophy*, 1(1), 3-44.
2. Searle, J. R. (1965). What is a speech act? M. Black (Хян.)-Д, *Philosophy in America* (хуудсд. 221-239). Ithaca, NY: Cornell University Press.
3. Verschueren, J. (1988). *On speech act verbs*. Amsterdam, The Netherlands: John Benjamins B.V.
4. Остин, Д. Л. (1986). Слово как действие. Б. Ю. Городецкий (Хян.)-Д, *Новое в зарубежной лингвистике* (А. А. Медникова, Орч., Б. 17, хуудсд. 22-129). Москва, Россия: Прогресс.
5. Отгонбаяр, Ж., & Өлзийсайхан, Б. (2019, January 31). Зан үйлийн боловсролын философи үндэслэгээ [Blog post]. Retrieved from <https://khuldjo.wordpress.com/2019/01/31/%D0%B6-%D0%BE%D1%82%D0%B3%D0%BE%D0%BD%D0%B1%D0%B0%D1%8F%D1%80-%D0%B1-%D3%A9%D0%BB%D0%B7%D0%B8%D0%B9%D1%81%D0%B0%D0%B9%D1%85%D0%B0%D0%BD->



%D0%B7%D0%B0%D0%BD-%D2%AF%D0%B9%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%B1/

6. Падучева, Е. В. (2010). *Высказывание и его соотнесенность с действительностью*. Москва, Россия: Издательство ЛКИ.
7. Почепцов, О. Г. (1986). *Основы прагматического описания предложения*. Киев, Украина: Вища школа.
8. Равдан, Э. (2009). *Хэл шинжлэлийн утгазүй*. Улаанбаатар, Монгол: Admon.
9. Равдан, Э. (2017). *Олон хэлний хэв шинжийн судлал*. Улаанбаатар, Монгол: Удам соёл.
10. Сёрль, Ж., & Вандервекен, Д. (1986). Основные понятия исчисления речевых актов. В. В. Петрова (Хян.)-Д, *Новое в зарубежной лингвистике* (Б. 18, хуудсд. 242-263). Москва, Россия: Прогресс.
11. Стросон, П. Ф. (1986). Намерение и конвенция в речевых актах. Б. Ю. Городецкий (Хян.)-Д, *Новое в зарубежной лингвистике* (И. Г. Сабурова, Орч., Б. 17, хуудсд. 130-150). Москва, Россия: Прогресс.
12. Ярцева, В. Н. (Хян.). (1998). *Большой энциклопедический словарь. Языкознание*. Москва, Россия: Большая Российская энциклопедия.

ГАДААД ХҮНД МОНГОЛ ХЭЛНИЙ ХЭЛ ЗҮЙН ХИЧЭЭЛИЙГ ЗААХ АРГА ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛД

Магистр Э.Одонтулга (ОУУБИС.СБТ)

odontulga@ulaanbaatar.edu.mn

Доктор (Ph.D.) Р.Бигэрмаа (ШУТИС. ГХС)

bigermaa@must.edu.mn

Түлхүүр үг: Идэвхтэй сургалтын арга, Kahoot.it, Z үе

Abstract

The paper outlines the influence of specific game elements onto players, presents the motivational aspects of game involvement, and investigates what game elements could be responsible for increasing motivation to participate and engage in a grammar learning game. All of these are investigated on the example of a Kahoot.

It online game, which was used with the “Mongolian Grammar” course students attending the classes in “International University of Ulaanbaatar”. The main objective of the research paper is to observe and assess how the students’ motivation increases – if – to learn and practice grammar and how effective this mode of learning is. It also presents the teachers’ evaluation of the design process, its implementation and recommendations for further use.


Kahoot is a tool for using technology to administer quizzes, discussions or surveys. It is a game based classroom response system played by the whole class in real time. Multiple-choice questions are projected on the screen. Students answer the questions with their smartphone, tablet or computer.

ОРШИЛ

XXI зуун буюу мэдээллийн эрин зуунд компьютер-технологийн хөгжил дэвшлийг даган шинжлэх ухааны салбар бүрд, тэр дундаа боловсрол судлалын салбарт ихээхэн шинэчлэл өөрчлөлт бий болж, сургалтад нэвтрэснээр англи хэлийг түгээн дэлгэрүүлэх болон түүнийг заах арга зүйн таатай нөхцөл бий болов.

Тухайлбал, компьютерын MS үйлдлийн программуудаас гадна, интернэт орчины, хэрэглэхэд нээлттэй, үнэ төлбөргүй, тоглоомын олон платформууд шил дараалан гарсан, гарсаар байна. Эдгээрийг ажиглавал, орчин үед зөвхөн англи хэлний дүрмийн 225 сая гаруй тоглоомын холбоос цахимд байршсан байна.

Зураг 1. Google хайлтын системд англи хэлний хэл зүй, үгийн сангийн 225 сая тоглоомын холбоос байршижээ.



Энэ нь Их Британи, Америкийн Нэгдсэн Улс, Энэтхэг, Австрали, Канад, Ирланд, Шинэ Зеланд, Филиппин гэх мэт дэлхийн томоохон улс орнууд англи хэлийг албан ёсны хэлээр бүртгэсэнтэй холбоотой. Өнөөдөр Дэлхий дээр 340 сая хүн англи хэлийг төрөлх хэл, 1 тэрбум гаруй хүн хоёрдогч хэлээ болгосон байна [2].

Энэ тухай www.arkhangai.mn өдөр тутмын цахим сонинд: “Англи хэл нь Британийн арлууд дээр 1000 орчим жил хэрэглэгдэж, боловсронгуй болж хөгжсөний дараагаас Британийн эзэнт гүрний далайчид, цэргүүд, жуулчид, худалдаачид болон номлогчдоор дамжин дэлхий даяар тархсан байна. Энэ үед улс орнуудад “Эх хэлний бодлого”-ын тухай хараахан яригдаж эхлээгүй байсан бөгөөд англи хэл нэг л мэдэхэд дэлхийн өнцөг булан бүрд хүрсэн байжээ.

...Зуун зуунаар үргэлжилсэн Европын цагаачдын давллагаанд Америк тивийн бүх л хэл хүчээ авч байсан ч Америкийг үүсгэн байгуулагчид Нэгдсэн Улсыг байгуулах үйл явцад улс үндэстний нэгдмэл байдлыг хангахын тулд “Өөрийн гэсэн хэлтэй байх нь их чухал” болохыг мэдэрсэн бөгөөд тухайн үедээ хамгийн өргөн хэрэглэгдэж байсан тул англи хэлийг “Үндэсний хэл”-ээ хэмээн хөхүүлэн дэмжихээр болжээ.” [3] (утгачлан эшлэв) хэмээн бичжээ.

Дээрх жишээнээс бид, нэгдүгээрт, аливаа хэлийг түгээн дэлгэрүүлэхэд тухайн улс гүрний нийгэм, эдийн засаг, улс төрийн бодлого нэн чухал болохыг харж болно. Хоёрдугаарт, хэлийг сурах, сургах соёлын бодлого, тухайлбал, АНУ-ын хэрэгжүүлсэн шиг “...тив алгассан хөрөнгө оруулалт, түүгээр ч зогсохгүй англи хэл дээрх урлаг соёлын бүтээл”-ээр дамжуулан хэл соёлыг түгээдгийг бид ухамсарлах хэрэгтэй. **Тиймээс, монгол хэлийг сурах, сургах, түгээн дэлгэрүүлэх ажилд**

АНУ-ын туршлагыг жишиг болгон, ажил хэрэг болгох зайлшгүй шаардлага үүсээд байна.

Гадаад хүнд монгол хэл заах арга зүйн хувьд монгол кирилл үсгийн фондыг Windows үйлдлийн системд таниулснаас хойш (юникод) олон хувилбарт, сургалтын программыг нээлттэй ашиглах боломж бүрдсэн юм. Өөрөөр хэлбэл, уламжлалт заах арга зүйн сургалтын гол хэрэгсэл нь ном сурах бичиг, үзүүлэн, зурагт самбар зэрэг цөөн тооны материал байсан бол эдүгээ дуу, дүрс, хөдөлгөөнт дүрс, дүрс бичлэг зэрэг олон төрөлтэй болсноор монгол хэлний нарийн төвөгтэй хэл зүйн ойлголтыг хормын төдийд суралцагчдад ойлгуулах, идэвхтэй сургалтын аргыг практикт чөлөөтэй хэрэгжүүлэх боломжийг багш нарт олгоод байна.

Иймд бид энэхүү судалгаандаа монгол хэлний хичээлд хэрэгжүүлж буй техник технологи, мөн вэбэд суурилсан заах аргын туршлагаа танилцуулахын сацуу, тийнхүү заах зайлшгүй нөхцөл шалтгаан бий эсэхийг суралцагчдын танин мэдэхүйн болон ой тогтоолтын онцлог шинжтэй хэрхэн уялдаж буй талаас дүгнэн шинжлэхийг зорилоо.

Ой тогтоолт гэдэг нь “Танин мэдэхүй ба суралцахуйн гол үүрэг гүйцэтгэдэг сэтгэцийн процесс юм. Мэдлэг, чадвар эзэмших, түүнийгээ аж амьдралдаа хэрэглэх үндсэн нөхцөлийг ой тогтоолт бүрдүүлдэг.

... Ой тогтоолт нь:

1. *Дүрслэх* - Харааны, сонорын, тэмтрэх, үнэрлэх зэргээр үүсдэг ба таван мэдрэхүйн эрхтний тусламжтайгаар дүрслэх юм.
2. *Үгийн ба утгын ой* – агуулга, логик үгэн хэлбэртэй мэдээллийн хоорондын холбоо утгад тулгуурлан тогтоохыг хэлнэ.
3. *Хөдөлгөөний* – Үйл хөдлөл хөдөлгөөнийг тогтоох.
4. *Сэтгэлийн хөдлөлийн ой* – Эерэг ба сөрөг сэтгэл хөдлөлийг тогтоох гэсэн 4 хэлбэр төрөлтэй байдаг” [4] (*хураангуйлан эшлэв*) бөгөөд энэхүү уураг тархины тогтоох ойн онцлог тус бүрд тохирсон заах аргыг монгол хэлний хэл зүйн хичээлд (гадаад хүнд зориулсан) технологи, компьютер болон вэбэд суурилсан аппликейшнээр заах боломжтой. Үүнд:

А. Power point программ дээр бэлтгэсэн сургалтын материал нь суралцагчийн харах мэдрэхүйгээр дамжин дүрслэх ойд, холбоо үг, өгүүлбэрийн гишүүдийн холбоо хамаарлыг *insert animation* цэсийг ашиглан хөдөлгөөнт дүрслэлээр үзүүлэх нь тэдний үгийн ба утгын, мөн хөдөлгөөний ойд шинэ мэдлэгийг богино хугацаанд хурдан өгч, удаан хадгалах нөхцөлийг бүрдүүлнэ.

Б. Вэбэд суурилсан kahoot.it тоглоомын платформ дээр бэлтгэсэн цахим



тоглоомууд нь хэл зүйн хичээлийн дасгал, давтлага хичээл болон бататгал хичээлийн агуулгыг оюутан суралцагчдад сонирхолтой хэлбэрээр хүргэх оновчтой шийдэл бөгөөд энэ аргаар монгол хэлийг танхимаар болон ганцаарчлан гэрээр сурах боломжтой. Уг тоглоомын олон хувилбарт асуулт, түүний форматын сонирхолтой шийдлүүд нь суралцагчийн аливаа шинэ мэдээллийг үйл хөдлөл, өнгө будаг, хэлбэр дүрс, байр байршил зэрэг шинжүүдээр нь нүдлэн тогтоох нөхцөлийг бүрдүүлнэ. Харин бүлгээр буюу олуулаа хамт тоглох үед оюутан өөрийнхөө түвшнийг мэдэх, бусад оюутнаас суралцах, мэдлэг чадвараа сайжруулах урам зоригийг уг тоглоомоос авах боломжтой. Өнгө, дүрс, дуу, аудио видео эх сурвалжийг хавсаргасан төрөл бүрийн асуултаар оюутны мэдлэгийг шалгах, тухайн сэдвийн аль хэсэгт багш нэмэлт тайлбар өгөх шаардлагатайгаа ч харах боломжтой. Уг тоглоомын платформ нь суралцагчийн сэтгэл хөдлөлийн тогтоох ойг ажиллуулах өдөөгч хүч нь юм.

XXI зууны боловсрол судлалд идэвхтэй сургалтын аргын асуудал чухлаар яригдах болсон. Энэ нь техник технологийн нэн шинэ эрин үеийн оюутан суралцагчдын танин мэдэхүйн онцлог төдийгүй, суралцагчдын хүмүүжил, хандлага төлөвшилтэй ч мөн холбоотой нь сэтгэл судлалын шинжлэх ухааны сүүлийн үеийн судалгаагаар нотлогдоод байна.

НЭГ. MS POWER POINT ПРОГРАММААР СУРГАЛТЫН МАТЕРИАЛ БЭЛТГЭХ АРГА

Power Point буюу үгчлэн орчуулбал, “Заах хүч” гэсэн утга бүхий нэртэй уг программын давуу тал нь бичвэрийг зураг, дуу, дүрс бичлэг зэргээр баяжуулахын зэрэгцээ бичвэрээ хөдөлгөөнт дүрслэлээр илэрхийлэх боломжтой сургалтын сонирхолтой үзүүлэн таниулах материал бэлдэхэд зориулсан программуудын нэг юм.


Тус программаар монгол хэлний хэл зүйн нарийн төвөгтэй үзэгдэл, хэлэхийн түвшинд хэрхэн хувирч хөдлөнгө шинжтэй болох зүй тогтлыг дүрс, хөдөлгөөнт дүрс ашиглан заах нь орчин үеийн залууст сонирхолтой ойлгомжтой, идэвхтэй сургах арга болж чадаж байна. Үүний тулд Power Point программын textbox болон animations цэсийг ашиглахад л болно.

Яагаад хөдөлгөөнт загварчлал ашиглан заах ёстой вэ гэдгийг хүний ой тогтоолтын онцлог, хэв загварын үүднээс тайлбарлавал:

Хүний ой тогтоолт нь богино хугацааны, урт хугацааны, мэдрэхүйн гэсэн

3 үндсэн үе шаттай, дүрслэх ой, үгийн ба утгын ой, хөдөлгөөний ой, сэтгэл хөдлөлийн ой [3] гэсэн төрлүүдтэй. Бид компьютерт суурилсан монгол хэлний үзүүлэн хичээл бэлтгэхдээ MS PowerPoint программын insert (shapes, text box), format drawing, animations зэрэг командуудын тусламжтайгаар дээрх ой бүрд сэрэл өгч, мэдээллийг дамжуулснаар оюутан шинэ мэдлэгийг хялбар тогтоох онц ач холбогдолтой.

Жишээ нь: *Монгол хэлний хэлэхийн хэмнэлийг хэлбэржүүлэх гол аргуудын нэг нь цагт нэрийн нөхцөлийн араас нэрийн тоо, тийн ялгал, хамаатуулахын нөхцөл орох үзэгдэл бөгөөд, энэ үзэгдлийг монгол хэл анхлан сурч буй, сурч эхлээд удаагүй байгаа гадаад оюутнуудад заахдаа:* Цагт нэрийн нөхцөл нь үйлийн нөхцөлүүд дундаас нэрийн нөхцөл авч чадах ганц бүлэг бөгөөд, энэ нь хэлний хэмнэлээс болж үүсэж буй үзэгдэл юм гэдгийг ойлгуулах хэрэгтэй. Жишээ нь: *Хичээлээ ойлгодог нь гэрийн даалгавраа сайн хийдэг* гэсэн нийлмэл өгүүлбэрийн **“ойлгодог нь”** гэсэн төгс бус өгүүлэхүүн нэрийн хамаатуулах нөхцөлөөр хэлбэржсэн бөгөөд, энэ нийлмэл өгүүлбэр нь ямар ямар энгийн өгүүлбэрээс хэрхэн хувирч, “ойлго-” гэсэн үйл үндэс яагаад нэрийн нөхцөлөөр хувилсныг дараах хөдөлгөөнт дүрсээр үзүүлэн, тайлбарлавал анхлан суралцагчдад уг зүй тогтол, хэл зүйн үзэгдлийг хурдан, хялбар ойлгуулахад илүү дөхөм байх болно.



Textbox-д бичигдсэн өгүүлбэрийн гишүүн animations цэсийн lines командаар хөдлөн энэ хэсэгт байришина.

Зураг 2.

Тайлбар: 1. Нийлмэл өгүүлбэрийг энгийн өгүүлбэр болгон задлах

1. Энгийн өгүүлбэрийн гишүүн тус бүрийг text box-д бичих



2. *Энгийн өгүүлбэрийн гишүүн хэрхэн хувирч, нийлмэл өгүүлбэрт байришиж буйг animations цэсний lines товчлуураар хөдөлгөн шинэ мөрөнд байршуулах*

ХОЁР. ВЭБ СУУРЬТАЙ СУРГАЛТЫН ПЛАТФОРМ АШИГЛАН ХЭЛ ЗҮЙН ДҮРЭМ ЗААХ АРГА

Монгол хэлний үгийн сан, Монгол хэлний хэл зүй гэх мэт хичээлийг заахдаа суралцагчдын мэдлэгийг бататгах, бүлэг сэдвийн давтлага хийх, сорил авах, лекцийн хичээлийг хэрхэн ойлгож буйг шалгах, хичээлийг сонирхолтой болгох, шинэ хичээлийг хэрхэн ойлгосныг хянах зорилгоор вэбэд суурилсан цахим сургалтын платформ ашиглан заах боломжтой. Жишээлбэл: Орчин үед дэлхийн 90 шахам орны багш нарын хамгийн өргөн хэрэглэж буй сургалтын платформын нэг нь “Kahoot.it” тоглоомын платформ юм.

kahoot.it сургалтын платформ нь, google бүртгэлээрээ нэвтрэн орж, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, тухайлбал, хичээлийн төрөл бүрийн үзүүлэн таниулах материалаас гадна, оюутан залууст хэл зүйн янз бүрийн дасгал ажлыг сонирхолтой хэлбэрээр бэлтгэн гүйцэтгүүлж болох олон төрөл, хувилбартай асуулт хариулт хэлбэрээр тоглодог, мөн нөхөх, холбох, сонгох, бичих төрөл бүрийн даалгаврын сонголттой тоглоомын платформ юм. Хичээлд ашиглах тоглоомын аргаар бэлдсэн асуулт хариултууд нь дараах хувилбартай. Үүнд:

А. Суралцагч бүрийн ойлгоцын түвшинг тодорхойлоход дараах хувилбар бүхий дасгал даалгаврыг ажиллуулах боломжтой:

- [true or false] буюу 4 [quiz] хувилбарт хариултаас сонсох асуулт нь тухайн судалж буй сэдвийн агуулгаас шалтгаалан хөнгөнөөс хүнд рүү шилжих бөгөөд суралцагчид уг асуултад хариулснаар зөв ойлголт агуулгыг хоногшуулах, эсвээс уг платформын дизайн зохиомж, өнгөний шийдэл нь харааны сэрлээр нь дамжин дүрслэх ойд нь тогтох, улмаар оюутан ойлгохгүй байсан хэл зүйн дүрэм, шинэ мэдлэгээ хурдан түргэн эзэмших боломжтой.
- үг, өгүүлбэрээр хариулах асуулт [type answer]:-ын хариу нь оюутнууд өөр өөрсдийн хариуг илгээсний дараа зөв болон буруу хариулт бүрийг дэлгэцэд өнгө ялган ил харуулах бөгөөд, буруу хариулсан оюутан өөрийн алдааг зөв хариулсан оюутны хариулттай харьцуулан олж засан тогтоох боломжтой.
- зургаас тухайлсан хэсгийг онож сонгох буюу цэг тавих [pin answer] асуулт

нь шинэ үгийн сорил авахад, мөн асуултаа сайтар боловсруулсан тохиолдолд үг, бүтээвэр, өгүүлбэрийн гишүүн гэх мэт хэл зүйн мэдлэг шалгахад ч тохиромжтой.

- үгсийг зөв дараалалд оруулах, эсвэл өгүүлбэр, холбоо үгсийг зөв дараалалд оруулж цогцолбор бүтээх [puzzle] асуулт нь өгүүлбэр зүйн мэдлэгийг шалгах, эх зохиох, холбоо үг бүтээх гэх мэт чадварыг олгоход тохиромжой.

Б. Тухайн анги бүлгийн ойлгоцын хувь, түвшинг төрөл бүрийн хувилбараар харуулах:

- Цагираган [poll]
- Багнанан [scale]
- Санал асуулгын [NPS scale]
- Асуултын хариуг олж сонгох [drop pin]
- Зөв буруу хариултыг нээлттэй харуулах [word cloud]
- Цогцолбор ба өгүүлбэрээс тухайлсан үгийг олж сонгох [open-ended]
- Цогцолбор ба өгүүлбэрээс сонгосон дүрмийн дагуух үг мөн эсэх дээр санал цуглуулж, ангиас хэдэн оюутан тухайн дүрмийг зөв ойлгосон эсэхийг оношлох [brainstorm]

зэрэг дасгал даалгаврын хувилбар нь багшид хичээлийн үр дүнг урьдчилан харах боломж олгоно. Хэрэв оюутнуудын дийлэнх нь тухайн дүрмийн асуудлыг сайтар ойлгоогүй нь графикаар нотлогдсон тохиолдолд тэдэнд хичээлийн аль хэсгийг дахин давтан тайлбарлах шаардлагатайгаа багш эндээс харна.

ЖИШЭЭ НЬ:

1. Цагариган график буюу poll: зөв буруу хариултын статистикийг харуулах
2. Зөв буруу хариултыг нээлттэй харуулах [word cloud]
3. цогцолбор ба өгүүлбэрээс тухайлсан үгийг олж сонгох [open-ended]

гэх мэт оюутны мэдлэг чадварыг оношлох асуултуудыг хичээлд ашиглахын тулд:

- kahoot.it аппликэйшнийг гар утсандаа татан суулгах
- багшийн удирдан тоглуулах толгоом /kahoot/-ын кодыг апп татахгүйгээр шууд сайт дээр нь тоглох 2 арга байдаг. Энэ нь тус вэб суурьтай сургалтын платформын давуу тал юм.

Эрдэмтэн судлаачид 17-18 насны оюутан суралцагчдын суралцахуйн ур чадвар, үр дүнг даах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- *Сэтгэмж гаргах, батлах, үгүйсгэх, үнэн худлыг олох*
- *Сэтгэхүйн шүүмжлэлт чанар*
- *Тайлбарлахдаа баримт дурдах, үзэгдлийн зүй тогтлыг гаргах, батлах эрмэлзэлтэй болсон байдаг [1:32] гэжээ.*

Ийм учраас Монгол хэлийг анхлан суралцаж буй гадаад оюутнуудад монгол хэлний хэл зүйн зүй тогтлыг ойлгуулахад олон төрөлт асуулт бүхий тоглоомын арга илүү үр дүнтэй нь харагдаж байна.

Нэг талаас монгол хэлийг хоёрдогч хэл болгон сурч буй гадаад оюутанд монгол хэл заахад хэрэглэх сургалтын ерөнхий арга [1:35] буюу хичээлийн хэрэглэгдэхүүн болсон дасгал даалгаврын төрлүүд нь бичих, тэмдэглэх, асуух, тайлбарлах, мэдээлэл хайх, даган дуурайх, загварчлах, зохион бүтээх, дасгал ажиллах, турших, давтах, туршлага хуримтлуулах, санал дүгнэлт, үндэслэл дэвшүүлэх гэх зэрэг олон төрлөөр бодит жишээн дээр буулган, заах боломж kahoot.it платформ-д байна.

Нөгөө талаас, бодит амьдрал дээр хийх, нотлон харуулах, унших, сонсох, бичих үйлийг бүрэн хамарч байгаа учраас гадаад хүнд монгол хэл заахад цахим суурьтай тоглоомын арга илүү үр дүнтэй нь батлагдаж байна.

Зураг. Эдгар Дэйлийн гурвалжин



Энэ бүхнээс харахад:

1. Сургалтын идэвхтэй аргаар хичээлийг зохион байгуулах нь суралцагчдад шинэ мэдлэг олгох хамгийн дэвшилттэй, үр дүнтэй, ялангуяа тэдний ойд мэдлэгийг удаан тогтоох ач холбогдолтой. Үүний учир нь залуу суралцагчдын сурах, шинэ мэдлэгийг хүлээн авах сэтгэхүйн чадамжтай нь холбоотой.
2. **kahoot.it** платформ, мөн хөдөлгөөнт дүрс болон дуу, дүрс бичлэгээр бэлтгэсэн үзүүлэх материалууд **[ppt]** нь АНУ-ын сэтгэл судлаач Эдгар Дэйлийн зурагласнаар уламжлалт сургалтын материалаас илүү үр өгөөжтэй байна. Тодруулбал, суралцагч зорилготой болон зорилгогүй уншиж, сонсож, харсан мэдээллээс илүү дуу дүрс, өнгө будаг оруулж загварчлалын аргаар бэлтгэсэн үзүүлэх материалыг харах, сонсох, хүртэх сэрлээрээ богино хугацаанд хурдан хүлээн аваад, сайтар тогтоодог. Учир нь, тэд өөрсдөө бие даан хийж гүйцэтгэсэн, эсвэл оролцсон асуудлаа илүү бүрэн дүүрэн (50-90% хүртэл) ойлгодог ажээ. Тэрчлэн суралцагчид дүрс бичлэг үзэх, үзүүлэх сургалтад оролцох, нотолгоог харах, өөрсдөө биеэр оролцох, бичил загвар гаргах, өөрийн ойлгосноо туршиж үзэх, зураг дүрслэл, үзүүлэн таниулах материалыг биетэй, бодит байдлаар хийж үзэх замаар суралцах сонирхолтой байдаг нь туршлагаас харагдаж байна.

ГУРАВ. МОНГОЛ ХЭЛНИЙ ХЭЛ ЗҮЙН ХИЧЭЭЛИЙН СУРГАЛТЫН ИДЭВХТЭЙ АРГАД СУРАЛЦАГЧДЫН ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

Аливаа мэдлэг, мэдээллийг танин мэдэх арга нь харьцангуй бодгаль шинжтэй. Хүн бүрийн мэдээллийг хүлээн авах хурд харилцан адилгүй байхаас гадна сурах арга хэлбэр нь өөр өөр. Зарим оюутан монгол хэлийг бие даан, ганцаарчлан сурах явцдаа унших, эргэцүүлэх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг төрөл бүрийн оюун дүгнэлтийг хийж, шинэ мэдлэг эзэмшдэг бол, зарим оюутан унших, бодох эргэцүүлэхээс илүүтэй ярих, бичих, бусадтай харилцах зэргээр бүлгийн сургалтаар монгол хэлийг сурах сонирхолтой байдаг. Энэ нь тэдний танин мэдэхүйн онцлогтой холбоотой юм.

17-18 насны суралцагчдын танин мэдэх, сурах арга барилын онцлогийг судлаач Ж.Даваа, “...танин мэдэх үйл ажиллагаа нь ерөнхийлөн дүгнэх хийсвэрлэн сэтгэх үйлийн өндөр түвшинээр илэрдэг” [1.32] гэсэн бөгөөд Power Point программ болон Kahoot.it вэб суурьтай сургалтын платформ ашиглан дээр боловсруулсан монгол хэлний дүрс, дуу, хөдөлгөөнт үзүүлэн нь тэдний харах, сонсох сэрлээр дамжин



хийсвэрлэн сэтгэх болон ерөнхийлөн дүгнэх чадварт үр дүнтэй нөлөөлдөг байна.

Учир нь, сэтгэл судлаачдын үзэж буйгаар Z үеийнхэн буюу 16-25 орчим насны суралцагч оюутнуудын танин мэдэхүйн онцлог нь дараах шинж чанартай. Үүнд:

1. Анхаарал төвлөрөх байдал сул
2. Нэгэн зэрэг олон ажил амжуулах чадвартай
3. Багаар ажиллахаас илүү бие даах чадварыг чухалчилдаг
4. Өөдрөг үзэлтнүүд
5. Уламжлалт суралцах арга барилыг таашаадаггүй
6. Тэвчээр муутай хүмүүс гэж тодорхойлсон байдаг [5] ажээ.

Иймд тэдэнд шинэ мэдлэг олгохдоо сургалтын олон хувилбарт үзүүлэн ашиглаж заах нь илүү үр дүнтэй бөгөөд, бичих, цээжлүүлэх, уншуулах, сонсгох, яриулах гэх мэт уламжлалт аргаас аль болох татгалзаж, тэдний танин мэдэхүй онцлогт тохируулан сургалтын материалаа бэлтгэх шаардлагатай байна.

Гадаад оюутанд сургалтын идэвхтэй арга (дуу, дүрс, хөдөлгөөнт дүрслэл)-аар монгол хэл заахын давуу талыг нас, сэтгэхүйн онцлогтой харьцуулан тайлбарлахын тулд зөвхөн онолд суурилсангүй. Суралцагчдаас:

1. Та хэдэн настай вэ?
2. Танд монгол хэл сурахад хамгийн амархан арга зам нь юу вэ?
3. Танд монгол хэлийг сурахад хамгийн хялбар гарын авлага аль нь вэ?
4. Танд монгол хэлийг сурахад хамгийн сонирхолтой гарын авлага аль нь вэ?
5. Та монгол хэлний дараах хичээлүүдийн алийг нь тоглоомын аргаар сурмаар байна вэ?
6. Та монгол хэлний дараах хичээлүүдийн алийг нь дуу, дүрс бичлэгийн аргаар сурмаар байна вэ?
7. Та монгол хэлний дараах хичээлүүдийн алийг нь бие даан, багшгүйгээр сурч чадах вэ?

гэсэн асуултаар санал асуулга авахад дараах дүн гарлаа.

1. Судалгаанд хамрагдагчдын дийлэнх нь хувийн багштай, ганцаарчилсан сургалтыг илүүд үзсэн
2. Судалгаанд хамрагдагчдын (30%) нь дуу дүрс бичлэг болон үзүүлэн таниулах материал буюу зураг, схем, параграф (хөдөлгөөнт ба хөдөлгөөнт бус) (40%) байдлаар бэлтгэсэн ppt материалаар монгол хэлийг сурах нь үр

дүнтэй гэж үзсэн

3. Судалгаанд хамрагдагчдын дийлэнх нь дуу дүрс бичлэгийг (40%) болон цахим тоглоомын аргаар бэлдсэн хичээлийн материалыг (30%) сонирхолтой гэж дүгнэжээ
4. Судалгаанд хамрагдагчдын дийлэнх нь буюу 40% нь Монгол хэлний хэл зүйн хичээлийг, 30% нь ярианы хичээлийг тус тус тоглоомын аргаар (kahoot.it) сурмаар байгаагаа илэрхийлжээ.
5. Судалгаанд хамрагдагчдын 35% нь үгийн сангийн хичээлийг, 30% нь ярианы хичээлийг багшгүйгээр сурах боломжтой гэж үзжээ. Харин ердөө 5% нь хэлзүйн хичээлийг багшгүйгээр буюу цахим тоглоом, үзүүлэн таниулах материал ашиглан бие даан сурах боломжтой хэмээн хариулсан байна. Үр дүнг нэгтгэн ажиглахад:

Тиймээс гадаад оюутанд монгол хэлийг заан сургахдаа уламжлалт сургалтын аргаас илүү, цахим болон сургалтын шинэлэг технологид суурилсан үзүүлэх материалаар хичээлийг зохион байгуулах зайлшгүй шаардлагатай болж байгаа нь тодорхой байна.

Судалгааны үр дүнгээс харахад:

1. 55 % нь хувийн багштай, эсвэл ганцаарчлан сурах сонирхолтой;
2. 70 орчим хувь нь шинэлэг, үзүүлэн таниулах материал (Дуу, дүрс бичлэг болон зураг схем, хөдөлгөөнт зураг, загварчлал бүхий)-аар монгол хэлийг сурах сонирхолтой
3. 70 орчим хувь нь тоглоомын аргаар монгол хэлний хэл зүйн хичээлийг сурах сонирхолтой гэж хариулсан байна.
4. Харин, ихэнх хувь нь (95%) хэл зүйн хичээлийг багшгүйгээр, цахим болон шинэлэг үзүүлэн таниулах материал ашиглаад, зайнаас сурах боломжгүй гэсэн байна.

Дээрх судалгааны үр дүнгээс харахад, гадаад оюутанд монгол хэлийг заан сургахдаа уламжлалт сургалтын аргаас илүү, цахим болон сургалтын шинэлэг технологид суурилсан үзүүлэх материалаар хичээлийг зохион байгуулах зайлшгүй шаардлагатай болж байгаа нь тодорхой байна.



ДҮГНЭЛТ

Монгол хэлийг хоёрдогч хэл болгон сурч буй Z үеийн гадаад хүнд монгол заахад бидэнд сургалтын идэвхтэй аргыг түлхүү ашиглах шаардлагатай байгаа нь дээрх зүйлүүдээс харагдаж байна. Энэ нь дараах шалтгаантай:

1. Шинэ үеийн залуусын ой тогтоолтын онцлог, харах, сонсох, хүртэх мэдрэхүйд нийцэх олон төрөлт сургалтын материал нь шинэ мэдлэгийг бага цагт хурдан эзэмшүүлэх боломжтой. Үүнийг бид MS Power point, kahoot.it зэрэг программ ба платформыг ашиглан бүтээх боломжтой
2. Шинэ үеийн залуус уламжлалт сургалтын аргаас илүүтэй орчин үеийн технологид суурилсан шинэлэг сургалтын аргыг илүүд үзэж байгаа учраас тэдний эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцүүлэн сургалтын материалаа бэлддэг байх шаардлагатай байна. Туршлагаар сурах сургалтын арга нь онолын сургалтын аргаас илүү үр дүнтэй.

НОМ ЗҮЙ

1. Даваа. Ж., [2014] Сурган хүмүүжүүлэх зүй, Уб:

Цахим эх сурвалж:

2. www.wikipedia.org
3. www.arkhangai.mn
4. <https://amanguliindocument.blogspot.com>
5. <https://medium.com/>

1990 ОНООС ХОЙШИХ СОЛОНГОС НОМ, ЗОХИОЛЫН МОНГОЛ ОРЧУУЛГЫН ТОЙМ

Магистр М. Амартайван

(ОУУБИС. ХНУС)

amartaivan.m@ulaanbaatar.edu.mn

Abstract

Mongolians have a rich tradition of translation. From Korean historical sources, researcher and scientist Sumiyabaatar B., Tserendorj Ts., Erdenechimeg G., and Ariunbaigal B. have carefully translated and studied the original documents related to the history of Mongolia. In Mend N.'s article, the translation works before the 90s are concluded, while Erdenechimeg mainly registered the works after the 90s. But today almost one decade have passed immediately. It's time to know and study other translation works since that time. Specifically, it should realize which types are dominant and which types are few, and notice and pay attention to what content is related to the Korean to Mongolian translation and printed works. Internom, Azhur, National Library, City Central Library, University Library, and South Korean bookstore sites were used for this compiling the data of the translation works. Despite the fact that a complete registration is not possible, but bibliography and registrations are essential for the further researches.

Түлхүүр үг: орчуулгын өв, солонгос хэлний орчуулга, номын орчуулга, уран зохиолын орчуулга

Монголчуудын орчуулгын уламжлал эртнээс эхтэй, арвин их өвтэйг судлаач Л.Хүрэлбаатар “Монгол орчуулгын товчоон” (1995) номдоо өгүүлсэн байдаг. Эхэн үедээ ойр харилцаатай дорнын хэл соёлоос хөрвүүлж түгээж байсан бол хожмоо 20-р зуунд өрнө дахины ном зохиолоос өч төчнөөнийг сорчлон орчуулж олон түмнээ танилцуулж байжээ.

Эх сурвалж судлаач, эрдэмтэн Б.Сумъяабаатар “Монгол, Солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд(1974)”, “XIII–XIV зууны Монгол, Солонгос харилцааны бичгүүд(1978)”, “Дундад зууны Солонгос, Монголын харилцааны түүх (中世韓蒙關係史) (1997)”, “Монгол-Солонгос-Нангиад “Мянган үсгийн соёл”-ын харьцуулсан судалгаа(2011)”, “Хубилай Их хааны үеийн Монгол-Солонгосын харилцаа (2015)” зэрэг ном бүтээл, “Дундад зууны Монгол Солонгос нь номын садан орон”, “Юан (Юань 元 уиán) гэдэг нэрийн учир” зэрэг эрдэм шинжилгээний олон өгүүллээрээ Солонгосын судлал төдийгүй Монголын судлал, дэлхийн түүхэнд



чухал нээлтийг хийсээр иржээ. Энэ бүх нээлт судалгаагаа хийхдээ эх баримтыг нягт няхуур орчуулж хөрвүүлэхээс эхэлдэг. Ном өгүүлэлдээ ч ханзаар бичсэн эхийн дор солонгос хөрвүүлэг, өөрийн монгол орчуулгыг заавал оруулж, нэмж тайлбарласан байдгийг мэдэж, үлгэрлэн дуурайлтай. Зарим нээлтээс энд дурдвал, “хөхөгчин хонин жил (995 он) хоёр улс үүрд ахан дүүс байя гэж нөхөрлөлийн тангараг тавьсан, хөхөгчин туулай жил (1219 он) 41 хүнийг Гуулин улсад үлдээн гуулин хэл сурахыг даалгасан, хөхөгчин хонин жил (1295 он) Юань улсаас монгол бичгийн багш түшмэл Мангодайг Гуулинд илгээн ирүүлсэн, харагчин хонин жил (1283 он) Юанаас эрэгтэй, эмэгтэй цамчид ирж байсан” [5:42-61], Хубилай хаан 1272 онд Гуулин улсын ванд “гавьяа байгуулсан хэлмэрчид өндөр хэргэм хүртээвэл зохистой” гэж зарлигдсаныг Гуулин улсын ван дагасан, Буянт хаан 1314 онд Гуулин улсын ванд 17 мянган дэвтэр бүхий 4371 боть ном(Сүн улсын хөлгөн судар) [8] бэлэглэсэн зэрэг солонгос сурвалжийн баримтууд болно.

Түүнчлэн аргын тооллын 6-р зууны эхээр Лян (梁) улсын Жоу Шин Сы (周興嗣) зохиосон, 1000 ханзыг давхардуулалгүй дөрөв дөрвөөр шадалж, тогтооход хялбар болгосон, нангиадаас солонгос, монголоор орчуулсан сурах бичгийн монгол орчуулгыг Монголын Үндэсний номын сангийн сан хөмрөгөөс олж судалсан гавьяатан билээ. Тэгээд “Мянган үсгийн соёл (千字文)”-ын судалгаагаараа өөр нэгэн нээлт хийжээ. Энэ нь Солонгост ханз эхээс “хар тэнгэр” гэж уншиж тайлж байсныг “хөх тэнгэр” гэж залруулж тайлсан явдал юм. Монгол орчуулгын хувилбарт “хар (玄)” биш “хөх (元)” гэсэн ханзаар тэмдэглэгдсэн (Б.Сумьяабаатар: 2011). байжээ. Чухамдаа «Тэнгэр газар хар шар(天地玄黃)” гэж биш “Тэнгэр газар хөх шар (天地元黃)” гэж эхэлсэн байсан гэсэн үг.

Эрдэмтэн Б.Сумьяабаатар Монголын Нууц Товчооноос 20 жилийн өмнө буюу 1221 онд Их Монгол Улсын Чингис хаанаас илгээсэн гадаад харилцааны бичгийн нотолгоо болох 3 зарлигийг Солонгосын түүхийн эх сурвалжаас анх удаа олж орчуулж, “Их засаг” хуулийг Солонгос сурвалжаас анх удаа олж, монгол хэл дээр 1980, 2008 онуудад хөрвүүлэн тайлбар нийтлүүлжээ. [6] Дээр дурдсан Сөүлд хэвлүүлсэн “Дундад зууны Солонгос, Монголын харилцааны түүх” бүтээлд ч орчуулгууд нь бий. Түүний “XIII–XIV зууны Монгол, Солонгосын харилцааны бичгүүд” номыг Үндэсний номын сангийн мэргэжилтэн Б.Нямдорж “Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын нийслэл Пён-янд 1955-1963 онд хэвлэсэн “Гуулин улсын судар”-т 1215-1257 оны хооронд Монголын тухай өгүүлсэн явдал түүхийг түүж монголчлоод хятад, солонгос эх бичигтэй нь хавсаргаж тайлбар хийсэн судалгааны ажил билээ.” [9] гээд ихэд үнэлж бичсэн нь бий.



Эдүгээ эрдэмтэн, багш Б.Сумъяабаатараас гадна түүний шавь Ц.Цэрэндорж, Г.Эрдэнэчимэг, Б.Ариунбайгаль нар солонгос хэлнээс харилцааны сурвалж бичгийг орчуулж, судлах нүсэр, хүнд ажилд үе залгамжлан хүчин зүтгэсээр байна.

ӨМНӨХ СУДАЛГАА

Дундаа багагүй хугацаанд завсардсан хэдий ч эртнээс түүх соёлын харилцаатай байж ирсэн Монгол, Солонгос хоёр орны орчуулгын бүтээлүүдийг Н.Мэнд “Монгол хэлээр орчуулсан Солонгосын уран зохиолын тойм” (2005) өгүүлэлдээ бүртгэн толилуулж, Монголын дунд сургууль, их дээд сургуулийн уран зохиолын хичээлийн хөтөлбөрт Солонгосын уран зохиолоос судлахаар тусгасан байдгийг дурджээ. Мөн 1921-1990 онд монгол хэлээр орчуулсан гадаадын уран зохиолын болон монгол номын бүртгэл, номзүйн цуврал, 1990 оноос хойш гарсан төвийн сонин, сэтгүүлийг ашиглан монгол хэлээр орчуулсан Солонгосын уран зохиолыг 1921-1990 он хүртэл, 1990 оноос хойш гэж хоёр ангилж болох бөгөөд, нийт 197 зохиолын орчуулгад өгүүллэг, тууж, роман, шүлэг, дуу, жүжиг, үлгэр гэсэн уран зохиолын 7 төрөл, найруулал, сэтгэгдэл, дурдатгал гэсэн сэтгүүлзүйн 3 төрөл байна гэжээ. Агуулгын хувьд Солонгосын дайны үед Умардын ялалтын төлөө, 1960-аас 1980-аад онд социалист орнуудын уран зохиолыг сурталчилж байсныг өгүүлсэн байна. Эцэст нь орчуулгыг бүртгэж, дүн шинжилгээ хийн орчуулгын онол дадлагын судалгааны хэрэглэгдэхүүн бэлтгэх шаардлагатай байгааг онцолжээ. 1950-аас 1960-аад онд “Солонгос ардын үлгэрүүд”, “Газар” романы тэргүүн, дэд дэвтэр зэрэг хэд хэдэн солонгос ном зохиолыг орос хэлнээс дам орчуулсан байдаг.

Харин Г.Эрдэнэчимэг (2016) Монголын их дээд сургуулиудад солонгос хэл зааж эхэлсэн 1990-ээд оноос хойших орчуулгын талаар голлон авч үзэж, эртний сонгодог зохиол орчуулсан Д.Сайнбилэгт, түүхийн сурвалж бичиг орчуулсан Ц.Цэрэндорж, алдартай хүмүүсийн намтрыг орчуулсан Ж.Баттөр нарын бүтээлийг онцлон сайшаажээ. Түүнчлэн цаашид орчуулгын бүтээлийн номзүй үйлдэж, цахимжуулах, орчуулгын булан байгуулах, олны хүртээл болгох, шүүмж хөгжүүлэхийг санал болгосноос гадна орчуулгын чанарын асуудал бараг орхигдоод байгааг дурдсан байна. Г.Эрдэнэчимэг монгол хэлнээс солонгос хэлээр орчуулсан бүтээлийг үргэлжилсэн үг, яруу найраг, эрдэм шинжилгээ гэж хуваан, үргэлжилсэн үгийг дотор нь роман, тууж, өгүүллэг; ардын аман зохиол; бусад гэж ангилсан, харин солонгос хэлнээс монголоор орчуулсан бүтээлийг үргэлжилсэн үг, яруу найраг, эрдэм шинжилгээ гэж хуваан, үргэлжилсэн үгийг дотор нь роман, тууж, өгүүллэг; намтар; ардын аман зохиол; бусад гэж ангилжээ.



Хожим Б.Ариунбайгаль (2022) солонгос хэлнээс сонгодог ном зохиолын орчуулга 7 [1:74-83] байгаа нь хангалтгүй агаад цаашид энэ тал дээр анхаарах шаардлагатайг хэлж, орчуулгыг дундад зууны уран зохиол, сонгодог ном, үлгэр ба хүүхдийн зохиол, орчин үеийн шүлэг, өгүүллэг, тууж роман, сурах бичиг ба эрдэм шинжилгээ, намтар, зурагт ном гэж 9 төрлөөр ангилж бүртгэжээ.

Талаар нэг тарсан ном бүтээлийг олж мэдэх, бүртгэн жагсаах ажлыг уйгагүй амжуулсан эдгээр судалгаа, бүртгэлд үндэслэн бүртгэх боломж бүрдсэнийг өгүүлж, талархсанаа илэрхийлье.

БҮРТГЭЛД ХАМРУУЛСАН НОМ, ЗОХИОЛ

Н.Мэнд, Г.Эрдэнэчимэг нар солонгос ном, зохиолыг монголоор орчуулсан бүтээлийг бүртгэж, 90-ээд оноос өмнөх, хойших гэж ангилсан байдаг. Н.Мэндийн бүтээлд 90-ээд оноос өмнөхийг сайн бүртгэсэн байдаг бол Г.Эрдэнэчимэг 90-ээд оноос хойших бүтээлийг голлон бүртгэснээс хойш даруй 6, 7 жил өнгөрснийг харгалзан дутууг гүйцээх, үргэлжлүүлэх санаагаар ийнхүү 1990 оноос хойших орчуулгыг эрж сураглаж нягталж бүртгэлээ. Ингэхдээ ямар төрөл зонхилж, ямар төрөл цөөн байгааг олж илрүүлэх, орчуулга, хэвлэлтэй холбогдох ямар агуулгыг анзаарч анхаарах хэрэгтэй байгааг гарган бичихийг зорилоо. Түүвэрлэж бүртгэхэд Интерном, Аз хур, Үндэсний номын сан, Хотын төв номын сан, их дээд сургуулийн номын сан, БНСУ-ын номын худалдааны сайтуудыг ихээхэн ашиглав. Хэдийгээр хичээвч нэг хүн байтугай нэлээд олон хүн байгаад ч хүчин мөхөстөх ажил, бас одоо ч хэн нэг нь ямар нэг ном, зохиол орчуулаад сууж байгаа, хэвлүүлж амжаагүй ч зүйл бийг бодохоор бүрэн жагсаалт болгох нь нэг бодлын бүтэшгүй хэрэг боловч чадлын хэрээр бүртгээд үзэж харахаа байг гэхэд ядаж ийм тийм орчуулга гарсан, байдаг гэсэн гэж ярьж хэлж яваасай, тэр нь үзэж судлах хэн нэгний сонорт хүрээсэй гэж эрхгүй хүснэм.

Монголоос солонгосоор ч гэсэн Монголыг судлаачид “Монголын нууц товчоо”, “Гэсэр”, “Жангар”, “Хураангуй алтан товч”, “Монгол домог үлгэр”, “Цаасан шувуу”, “Оюун түлхүүр”, “Тунгалаг Тамир”, “Цасны домог”, “Монгол домог зүйн дүр”, “Монгол гэр бүлийн ёс заншил ба уламжлал” зэрэг номыг орчуулан гаргаж байгаа боловч нэг талаар цаг давчууг харгалзан, нөгөө талаар Солонгосыг судлаачдад зориулж бичиж байгаагаа ухамсарлаж эхний удаад солонгос ном, зохиолыг монголоор орчуулсныг бүртгэхийг оролдлоо. Солонгос номыг өөр хэлнээс дам орчуулсныг, Солонгосоос бусад орны номыг солонгосоор

орчуулснаас мөн дам орчуулсныг бүртгэлд бас багтаалаа. Солонгос гаралтай америк зохиолчийн солонгосын түүхэн сэдэвт, англиар бичсэн “Пачинко” номын орчуулгыг бас жагсаалтад оруулах нь зүйтэй гэж бодлоо. “Амьд бамбар: Чун Тай Ил-ийн намтар” зэрэг цөөн номыг англиас орчуулсан байж магадгүй ч солонгос эх ном байдаг учраас бүртгэлд орууллаа.

Монгол, солонгос багш, судлаач, оюутны хамтарсан эрдэм шинжилгээний хурал, семинарын эмхэтгэл зэргийг ч мөн л орчуулагч, судлаач, оюутан нар орчуулж ирсэн, орчуулсаар байгааг сайтар бүртгэн авалтай. Бүртгэлд Зүүн хойд азийн түүхийн сан (ЗХАТС)-гаас Монголын ЕБС-ийн Түүх, нийгмийн багш нарт солонгосын түүхийн мэдлэгийг нь сайжруулах зорилгоор жил бүр зохиодог семинарын эмхэтгэлийг хожмоо 5 ном болгон хэвлэснийг орууллаа.

Ж.Ломбын эмхэтгэсэн харилцааны түүхийн “Монгол Улс, БНСУ-ын харилцаа 30 жил, Монгол Улс, БНАСАУ-ын харилцаа 70 жил” номуудад багтсан дипломат баримт бичгүүдийг орчуулахад магад өөрөө оролцсоныг нь таамаглаж орчуулгын номын бүртгэлд оруулах нь зөв гэж бодов.

Номоор нь тооцвол нийт бүртгэлд 1992 оноос 2023 онд орчуулсан 200 гаруй ном багтжээ. Бүртгэлийн эхний хэсэгт эх номын зохиогч, зохиолчийн нэрээр эрэмблэв. Тэр орчуулагч төдөн ном орчуулж гэхээсээ тэр зохиогч, зохиолчийн номыг тэр тэр хүн орчуулж гэдэг нь илүү сонин байх болов уу гэж найдна. Удаах хэсэгт өгүүллэг, шүлгийн түүврүүдэд багтсан өгүүллэг, шүлгүүдийг бүртгэлээ.

Солонгосын “Утга зохиолын орчуулгын сан (문학번역원)”-гийн цахим бүртгэлд 3 номын нэрийг хэвлэгдэхээс өмнөх хувилбараар “Ким Далжин найрагчийн шилмэл түүвэр”, “Куаг Хюухуань найрагчийн шилмэл түүвэр”, “Солонгосоор баясахуй” гэж оруулсан байсныг хэвлэгдсэн нэрээр нь “Хүсэмжлэх ертөнц байгаа болохоор...”, “Уйтгар гунигийн учиг”, “Солонгос түмнийг тольдохуй” гэж бүртгэлээ. Ер нь бүртгэсэн бүх ном, зохиолын зохиогч, зохиолч, номын нэрийг хэвлэгдсэн байдлаар нь оруулах нь зүйтэй гэж шийдэв.

Койкагийн ажилтан Жон Жиньчол (Монгол нэр нь Шинээ)-ын эмхэтгэж хэвлүүлсэн өвөрмөц хэллэг, зүйр цэцэг үг, угтвар дагаврын орчуулгын толь бичиг байдгийг урьд үзэж байсан боловч холбогдох тодорхой мэдээллийг олж чадаагүйгээс бүртгэлд оруулсангүй.

С.Энхзул “Гадаад хүнд зориулсан Солонгосын соёлын унших бичиг”-ийг М.Амартайвантай хамтран орчуулсан боловч захиалагч талаас нэг нь хянагчаар нэрээ бичүүл гэж шаардсанаар М.Амартайван хянасан гэж хэвлэгдсэн түүхтэй. Бүртгэлд хамтарч оруулснаар нь орууллаа. Орчуулах явцад цаг давчуу, амжихгүй



болсон учраас хамтарч орчуулсан, тэр тухайгаа орчуулга захиалагчид хэлсэн боловч М.Амартайван дангаар орчуулсан мэт хэвлэгдсэн “Холын улс ба хөрш улс”, “Шилдэг 3 зохиол” номуудыг хамтран орчуулагч Б.Энх-Амгалан, Ч.Мандахнар нарын нэрийг цуг бүртгэж “залруулга” хийлээ. Зүй ёсондоо захиалагч тал залруулга хийх учиртай байв.

Шүүмж биш учраас орчуулгын агуулгын сайн мууг энд хэлэлцэхгүй. Ташрамд дурдахад солонгос киног монголоор орчуулахад гаргаж буй алдааны талаар нэн тустай шүүмжийг Ц.Цэрэндоржийн бичсэн “Буруу ярьж, зөв ойлгоно оо гэж...” [11] нийтлэлийн “Орчуулга гэдэг хэцүү ажил” хэсгээс уншаарай. Бас солонгос хэлнээс орчуулсан бүтээлийн талаар Г.Эрдэнэчимэгийн хоёр шүүмжийг “Орчуулгазүй” [7] сэтгүүлээс үзэж болно. Зөвхөн муулж гоочлоод өнгөрөх биш сайн мууг үндэслэл баримттай нь, залруулах аргатай нь хэлж зөвлөж байя. Нөгөө талаар шүүмжийг хүлээж авдаг, алдаагаа засдаг, цаашдын орчуулгадаа тусгадаг байвал зохино.

ОРЧУУЛГЫН БҮТЭЭЛИЙГ ТӨРЛӨӨР АНГИЛЖ ҮЗЭХЭД

Бүртгэсэн ном, зохиолыг төрлөөр нь ангилж үзвэл анагаах ухааны ном 11, бизнес эдийн засгийн ном 5, боловсролын ном 7, намтар 9, орчуулгын онол 1, соёл 1, солонгос хэлний ном 10, сэтгэл судлалын ном 2, түүхийн ном 18, уран зохиолын ном 79, хоолны жорын ном 1, хуулийн 1 ном, хүний хөгжлийн ном 25, хүүхдийн ном 21, шашны ном 6, эсээний ном 7 байна.

Уран зохиолын 79 номоос яруу найргийн ном 25, үргэлжилсэн үгийн ном 42, үлгэр домгийн ном 4, зурагт ном 6 байна.

Хамгийн элбэг байгаа нь уран зохиол, хүний хөгжил, хүүхдийн ном, түүх, солонгос хэл, намтар, анагаах ухаан. Гэтэл онол, хууль, хоолны жор, соёл, сэтгэл судлалын ганц хоёрхон ном байгаа бөгөөд сэтгэлийн судлалынх нь дам орчуулга байна.

Анагаах ухааны ном, солонгос хэлний сэдэвт номууд бараг бүгд сурах бичиг ажээ. Хүний хөгжлийн номууд 2009 оноос хойш тасралтгүй орчуулагдаж байгаа нь цагийн өнгө, дэлхий нийтийн бодол хандлагыг илтгэх мэт. Харин шашны 6 ном л бүртгэгдсэн боловч Христийн цуглаануудад гарын авлага болгож хэрэглэдэг олон номыг солонгосоос орчуулсан байдаг бөгөөд энэ талаар тусгай нарийн судалгаа хэрэгтэй.

Харин дам орчуулгын хувьд англи номыг солонгос хэлнээс орчуулсан 14, япон номыг солонгосоос орчуулсан 2, хятад, польш зохиолыг солонгосоос орчуулсан

1, 1 тохиолдол байна. Солонгос номыг англиас орчуулсан 5 тохиолдлын 3 нь үргэлжилсэн үгийн зохиол ажээ.

ОРЧУУЛГА, ХЭВЛЭЛТЭЙ ХОЛБОГДОХ АНЗААРЧ АНХААРАХ ЗҮЙЛ

Орчуулгын ном, зохиол бүртгэх явцад дараах хэдэн зүйл анзаарагдлаа. Анхаарах зүйл байж юуны магад.

Шүлгийн түүврүүд, “Чүнхянг бүсгүйн домог”, “Хон Гилдон нэрт шастир”, “Турван улсын нөхсөн судар” гэх мэт зохиол бүтээлийн орчуулгыг солонгос эхтэй нь хэвлэсэн нь тун олзуурхууштай болжээ.

“Хорвоо дэлхий уудам, хийх ажил их байна”, “Мянган жилийн түүхэн хүн” зэрэг цөөн тооны ном хэдэнтээ хэвлэлтэд оржээ.

Монгол орчуулгыг Солонгост хэвлүүлсэн тохиолдол ч байна. Тухайлбал “Талд ургах солонго”, “Утгыг тайлж хялбаршуулсан Хүнмин Жонгым” номуудыг дурдаж болно.

Ричард М.Стирсийн англи номыг орчуулахдаа “Хүнд сорилт – хэзээ ч бүү бууж өг” гэж Жон Жү-ёны өөрийн бичсэн намтар номын нэрээр (시련은 있어도 실 패는 없다) орчуулсан нь сонирхолтой.

“Аянга цахилгаан” бол Монголд ажиллаж амьдарч байсан солонгос эмч, тусгаар тогтнолын төлөө тэмцэгч И Тэжүний намтар зохиол.

Анх “Манай ангийн овгор” нэрээр орчуулсан зохиолыг сүүлд Монсудар – Утга зохиол цувралд багтааж “Манай бүдэрсэн баатар” нэрээр дахин хэвлэжээ. Нэр өөрчилсөн шалтгааныг Монсударгаас бичсэн өмнөх үгэнд “Манай ангийн овгор гэсэн нь 1-р биеийн хүүрнэгчийг бус харин өөр дүрийг тодотгож буй аястай болжээ” гэж тайлбарласан байна.

Үлэмж паблишинг хэвлэлийн газраас хүүхдэд зориулсан танин мэдэхүйн “Яагаад?” цувралын 10 ном гаргахаар төлөвлөснөөс 3-ыг 2022 онд гаргажээ.

“Яг өнөөдрөөс алхаж эхэл” номыг Интерномын юүтүүб сувагт байрлуулсан нэвтрүүлгээр танилцуулахдаа редакторыг орчуулсан гэж хэлсэн нь хүмүүсийг төөрөгдүүлэхэд хүргэж байна.

Солонгос хэлнээс орчуулсан “Алибаба группыг үндэслэгч Жэк Ма-гийн амжилтын нууц” номын зохиогчийг Ким Шин Ху гэж Азхурын сайтад бичсэнийг нягталж шалгахад үнэндээ эх номыг нь солонгосоор орчуулсан орчуулагчийн нэр байв.



“Би “би”-гээрээ амьдрахаар шийдсэн” номыг япон хэлнээс орчуулж, солонгос хэлний эхтэй тулгаж хянажээ.

“Христийн шашны мартагдсан түүх” гэж орчуулсан номын нэрийг “Мартагдсан Христийн шашны түүх” гэж өөрчилж хэвлэсэн нь тоогүй.

Ким Ёнха-гийн зохиолыг Майнд сангаас “Солонгос эмэгтэй өөрөө шийдэв”, “Би өөрөө шийдэв” гэсэн хоёр өөр нэрээр хэвлүүлж байжээ.

Зарим өгүүллэг, шүлгийн хоёр гурван орчуулга байгаа нь харьцуулж үзэхэд сонирхолтой байж болзошгүй.

ДАМ ОРЧУУЛГЫН ТАЛААР ХЭДЭН ҮГ

Энгийнээр хэлбэл орчуулгаас орчуулахыг дам орчуулга гэнэ. Тагтаа, Улбаршар хэвлэлийнхэн солонгос зохиолчийн сайн зохиолыг сонгож англи хэлнээс орчуулж хэвлүүлж байна. Дам орчуулгыг онолын хувьд сайшаадаггүй боловч өөр хүн эх хэлнээс нь шууд орчуулж байгаагүй, эсвэл тааруухан орчуулсан бол байж болох тохиолдол. Гол нь энэ тохиолдолд эх хэлнээс нь орчуулсан анхны орчуулга сайн байх ёстой. Тиймгүй бол орчуулгаас орчуулж буй дам орчуулгын чанарт сөргөөр нөлөөлнө. Бас галиглахдаа бусад хэлээр дамжуулж биш тухайн хүн, тухайн газар хэлэлцдэг хэлнээс монголоор шууд хэрхэн галигладгаар галиглахыг зорих хэрэгтэй. Тухайлбал И Минжин гэх нэрийг англиас орчуулахдаа Мин Жин Ли гэж овгийг ард оруулахгүй байх ёстой. Зохиолч нь нэгэнт Америкийн иргэн болсон учраас Америкт бичиж дуудаж заншсанаар оруулсан байж ч болзошгүй.

Гэтэл зохиогчийн 송хонб (宋鴻兵 Song Hongbing) хэмээх хятад нэрийг Сонг Хонбин гэж солонгосоос оноосон нэрийг галигладгаар орчуулсантай таарав. Сун Хун Бин, эсвэл Сун Хунбин гэх байв. Монголд Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс 2016 онд “Хятад хэлний үеийн галиг” [10]-ийг баталсан байдаг. Хятад номыг солонгосоор орчуулснаас орчуулах, ерөөс солонгос ном зохиолд гарч байгаа хятад хүн, газар усны нэрийг энэ журмыг ашиглан галиглаж болно. Солонгос ба бусад түгээмэл хэлний галиглах журмыг ч гэсэн хэлэлцэн батлах хэрэгцээ шаардлага бий. Эрдэмтэн Ц. Шагдарсүрэнгийн үзэж байгаачлан, хятад ханзыг галиглахдаа орос хэлний нөлөөнөөс салж чадаагүй. Гэтэл монгол бичигт тийм нөлөө байгаагүй. Түүнчлэн хятад ханз, солонгос үсгийг монголоор зөв буулгах бүрэн боломж байгаа атал тэр бүр зөв буулгаж чадаагүй нь анзаарагддаг. Ялангуяа социализмын үеийн орос хэлний нөлөөгөөр монгол хэлнээ буруу тэмдэглэсэн хятад, солонгос нэр үг дэндүү олон болсныг дурдах нь зүйтэй. Товчхондоо, эх

хэлнээс нь өөр хэлээр дамжилгүй шууд галиглах зарчмыг баримталж галигийг нэг мөр болговол зохино.

ДОТООД ГАДААДЫН БАЙГУУЛЛАГЫН ДЭМЖЛЭГ

Солонгос хэлнээс 1996, 2000 онуудад хэвлүүлсэн “Солонгос өгүүллэгийн дээжис 1, 2” түүврүүдийг тус тус SBS корпорацийн соёлын сан, Дипломат харилцааны 10 жилд зориулж БНСУ-ын Гадаад сурталчилгааны Агентлагаас ивээн тэтгэсэн байдаг.

Г.Эрдэнэчимэг(2016) монгол уншигчдыг Солонгосын уран зохиолтой танилцахад БНСУ-ын “Утга зохиолын орчуулгын сан (문학번역원)”, “Тэсань соёлын сан (대산재단)” хэмээх хоёр сангийн дэмжлэг чухал үүрэг гүйцэтгэснийг онцлон дурдсан байдаг. Эдгээр сан одоо ч ажил үйлсээ үргэлжлүүлсээр эхнийх нь монгол хэлээр орчуулж хэвлүүлэх 29 ном, дараагийнх нь 6 номыг ивээн тэтгэсэн байна.

БНСУ-ын Боловсролын яам, Судалгааны сан (대한민국 교육부와 한국연구재단)-гийн дэмжлэгээр сувилахуйн ухааны 10 сурах бичгийг орчуулуулж хэвлэжээ.

Leader book байгууллагаас хүүхэд багачуудад зориулсан үзэгтэй номыг монгол хэлээр орчуулж цувралаар гаргаж байна.

Монгол дахь “Сөүл ирээдүй соёлын сан”-гаас олон улс, орон судлалын 4 номыг солонгос хэлнээс орчуулуулж хэвлүүлэв.

БНСУ-ын Зүүн хойд азийн түүхийн сан хурал, семинарын 5 эмхэтгэлийг монголоор орчуулуулж гаргав.

Монголын Орчуулагчдын Эвлэлээс зохион байгуулдаг өгүүллэгийн уралдаанд оролцогчдын бүтээлээс хэвлэдэг “Сонгодог өгүүллэгийн дээжис” цувралын 1, 3, 5, 6 дахь дугаарт солонгос өгүүллэгийн орчуулгууд багтжээ.

НЭМЖ БҮРТГҮҮШТЭЙ ОРЧУУЛГА

Төрөл бүрийн орчуулгын бүртгэл хэрэгтэй бөгөөд, тэрхүү бүртгэлээ цахимжуулаад тодорхой хугацааны мөчлөгтэй засаж дэлгэрүүлдэг байвал тун сайн сан. Чухамхүү олон хүн гар сэтгэл нийлж хамтарч ажиллах хэрэгтэй. Тухайлбал кино, нэвтрүүлэг, дуу, эрдэм шинжилгээний бүтээлийн орчуулгыг ч дэлгэрэнгүй бүртгэж, судалж, таниулах хэрэгтэй. “Дуу төрсөн түүх” гэж нэвтрүүлэг байдаг шиг



“Орчуулга төрсөн түүх” гэж хүмүүсээр яриулж тэмдэглээд ном гаргавал төрөл бүрийн орчуулгын сонин содон баримт мэдээг сонсож болохын сацуу тэдний алдааг давтахгүй, онооноос нь сурахад тустай санагдана.

а. Кино, жүжгийн орчуулга

Н.Мэнд 1998-2005 онд бүрэн бус тоогоор 50 орчим кино орчуулсан нь солонгос нийгэм соёл, ахуй амьдралыг ойлгоход ихээхэн тустай байгааг дурдаж байв. Харин үүнээс хойш бараг тоогоо алдсан гэхэд болохоор ажээ.

Тэнгис кино театрт 2004-2011 онуудад нэлээд олон кино хадмал орчуулгатай гарч байв. Монголд гарсан олон солонгос киног Д.Оюунцэцэг орчуулсан гэдэг. Ярилцлага хийж, туршлага судлуултай. “Халтар царайт”, “Хуан Жү гэг”, “Ошин”, “Тэ Жангым” тэргүүтэй, олон улс үндэстний сайхан киног үзэж байсан боловч хэн орчуулсныг нь төдийлөн ойшоодоггүй. Чадварлаг орчуулагч нараа мэддэг, тэднээс суралцдаг байх учиртай сан. Мэдээж муу орчуулга ч бишгүй гардаг. Орчуулагчийн чадвараас гадна цаг тулгуу, үнэлгээ тааруу байдаг нь их нөлөөлдөг.

Жүжгийн орчуулгын тухайд гарын арван хуруунд багтахар цөөн байгаа болов уу. Жич, С.Сүх-Очир “Тамгагүй төр” жүжгийг монголоос солонгосоор орчуулсан гэдэг.

б. Нэвтрүүлэг

Солонгостоо олон хүн үздэг, гадаадын олон оронд орчуулагдсан “Оддын хаан(Star King)”, “Running man” зэрэг нэвтрүүлгийг орчуулагч нар монголоор орчуулж зурагтаар гаргаж байсныг санаж байна. Хэн орчуулсныг тодруулж бүртгүүштэй.

Сүүлийн үеийн жишээ гэвэл “Хүргэлт ирлээ (택배는 몽골몽골)” цуврал нэвтрүүлэг. Хэн орчуулсныг бас л мэдүүштэй. Алдаа оноогоо хэлэлцэж сайжруулаад явмаар байна. Солонгос нэвтрүүлэгт хадмал их хэрэглэдэг. Тэгэхээр дүрс бичлэгийн хадмал орчуулгын тухай ч ярих ёстой болно. Энэ талаар М.Амартайван МУИС-ийн Орчуулгазүй сэтгүүлийн 6 дахь дугаарт “Дүрс бичлэгийн орчуулгад анхаарах зарим зүйл” өгүүллийг нийтлүүлж байв.

в. Дууны орчуулга

Шүлгийн орчуулгаас гадна дууны орчуулга гэж шандас, ур ухаан шаардсан ажил бий. Утгаас гадна хэмнэлийг нь аль болох хадгална гэвэл суух, бодох ажил

нэмэгдэж байгаа нь тэр. Солонгосын ардын дуу “Ариран”-ыг Д.Ёндон, Арион Кори(Жү Чэхёг) нар аянд нь тааруулж дуулж болохоор орчуулсныг 1996 онд хэвлэгдсэн *한·몽골교류협회, 한·몽골 교류 천년* (Солонгос, Монголын мянган жилийн харилцаа) номоос үзэж болно.

Бас хэдэн жилийн өмнө Ц.Цэрэндорж фэйсбүүк хуудсандаа “Тэ Жангым” киноны дууны эхний бадгийг орчуулснаа танилцуулж, “Энэ дууг Солонгосын эртний Гурван улсын үеийн ардын дууны маягаар зохиосон тул солонгос хүн ч ойлгодоггүй ажээ. Тайлбарыг нь харж байж орчуулав.” гэсэн байдаг.

Энэ мэт ул суурьтай хандаж чамбай орчуулсан бүтээлүүдийг мэдэж таниулах нь мөн л бидний хийх ёстой ажлын нэг болов уу.

г. Эрдэм шинжилгээний орчуулга

Эрдэм шинжилгээний орчуулга ч гэсэн нэн чухал байдаг. Хэн хүссэн нь хийдэггүй. Чадах хүн нь буюу тухайн мэргэжлийн хүн л чамбай хийнэ. Нэг жишээ дурдвал одоо ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал, судалгаа, сурвалжийн орчуулга хийдэг Ц.Цэрэндорж *Монгол Солонгосын эрдэм шинжилгээний анхдугаар симпозиум, БНСУ-ын Үндэсний музей, МУ-ын ШУА-ийн Археологийн хүрээлэн, МУТМ, Сөүл-УБ, 2003 (солонгос-монгол, монгол-солонгос орчуулга), Дуурлиг нарсны хүннү були (Тусгай үзэсгэлэнгийн каталог), Сөүл-УБ, 2009 (солонгос-монгол хамтын орчуулга)* гэх мэт хоёр улсын музей, судалгааны хүрээлэнгийн хамтарсан судалгаа шинжилгээний хурал, тайлан, үзэсгэлэнд зориулсан олон бүтээлийг орчуулсан байдаг.

Түүчнлэн МУИС-ийн багш Г.Эрдэнэчимэг “Гурван улсын түүхэн тэмдэглэл”-ийн 13, 14-р дэвтэр “Когүрийогийн их вангуудын намтар”-ыг орчуулж, МУИС-ийн Солонгос судлал 3, 4 дугаарт хэвлүүлсэн, Б.Ариунбайгаль “Туулин улсын судар”-аас 1270-1280 оны захидал харилцааны бичгүүдийг орчуулж, тайлбар зүүлт хийн судалж, эрдмийн зэрэг хамгаалаад зогсохгүй ном болгон хэвлүүлж эрдэм шинжилгээний эргэлтэд оруулсан байдаг.

Эдгээрээс гадна өөр олон салбарын нарийн ширийн агуулгатай эрдэм шинжилгээний бүтээлүүд нэгэнт цөөнгүй орчуулагдсан учир Г.Эрдэнэчимэг багшийн эхлүүлсэн бүртгэлийг баяжуулж, мэдэх нэг нь мэддэгээ нэмэн бүртгүүлэх нь зүйтэй.



ДҮГНЭЛТ

Өнгөрсөн гучаад жилд цөөн гэхээргүй ном зохиол орчуулан хэвлүүлжээ. Энэ олон орчуулгуудаас үзэж танилцаж үр шимийг нь хүртэх, эрдэм шинжилгээнд ашиглаж эргэлтэд оруулах, үгүй ядаж “салхи оруулж” эргүүлж тойруулж харахын тулд наанадаж чанартай бүртгэх, сайтар танилцуулах ажил нэн шаардлагатай байна. Нэг нэгнийхээ дутууг гүйцээж дундуурыг дүүргэн бусдын соёл түүхээс суралцаж өөрийн соёл түүхийг харьцуулан таниулах ажил бас чухал хэвээрээ байна. Энэхүү бүртгэлд эндүү ташуу, дутуу хүтүү юм эрхбиш бий. Хүлцэл өчөөд дараах гурван саналыг дэвшүүлье.

Хэзээ нэгэн цагт бүртгэхэд тустайг бодож аль хэлнээс орчуулсныг ном хэвлэхдээ зориуд тусгаж тусгуулж байх, цахим сан бүрдүүлж орчуулгын номын булан үүсгэхийн тулд орчуулагч, багш, судлаач нар дэмжин туслах байгууллагатай хамтарч ажиллах, орчуулсан ном зохиолыг уншиж ярилцах уулзалт дугуйлан байгуулах.

Цаг, цаасны хязгаартайг бодолцож энэ удаад монгол ном, зохиолын солонгос орчуулгыг түр хойш тавьсан боловч мөн адил чамгүй олон бүтээлийг орчуулсан байдаг. Магад тал талд тус тусдаа цуглуулж бүртгэсэн зүйл байх аваас нэгтгэн нэг том цахим сан үүсгэхийн ач тусыг үгээр хэлэлтгүй биз ээ. Монголын судлалын нэгэн том төв болсон БНСУ-д эрдэмтэн судлаач нар судалгаа, орчуулга хийж, ном бүтээл зогсолтгүй туурвисаар байна. Эрлийг сургаар, эрдмийг хичээлээр гэдэгчлэн эрж сураглан цуглуулж бүртгэснээс хүсэл сонирхол, ажил зорилгодоо нийцүүлэн сонгож аваад үзэж харж сайныг нь сайшааж таарууг нь таньж суух юутай сайхан завшаан билээ. Нэг хоёроор ахиулсаар нэг л мэдэхэд арвин сан бүрдэх нь лавтай. Тэр өдөр мөдхөн ирэх болтугай.

НОМ ЗҮЙ

1. Ариунбайгаль, Б., (2022). 한문고전 및 한국문학의 몽골어 번역에 관한 연구, Ази судлал ЭШБ. Уб: МУИС 8. 74-83т
2. Сумьябаатар, Б., Чой Гихо, (2011). Монгол, Солонгос, Нангиад «Мянган үсгийн соёл»-ын харьцуулсан судалгаа. Уб
3. Эрдэнэчимэг, Г., (2016). Солонгосын утга зохиолын монгол орчуулгын тойм. Орчуулгазүй ЭШБ. Уб: МУИС 5, 93-109т



4. 멘дс, (2005). 몽골어로 소개된 한국 문학 및 번역에 대한 고찰. 제2회국제학술세미나 자료집. 한국·몽골문학연구회. pp.47-56
5. 수미야바타르, (1996). 몽골과 고려와의 관계, 한-몽골 교류 천년. 한-몽골교류협회. pp.42-61
6. *Википедиа чөлөөт нэвтэрхий толь*. <https://mn.wikipedia.org/wiki>
7. *Орчуулгазүй эрдэм шинжилгээний бичиг. МУИС*. <https://journal.num.edu.mn/TranslationStudies/issue/archive>
8. Сумъяабаатар Б., (2004). Дундаж зууны Монгол Улс Солонгос 471 боть ном бэлэглэж байжээ. *Өнөөдөр сонин*. https://maral-books.net/moco_4371boti/
9. *Үндэсний номын сан*. (2023.01.11.) <https://www.facebook.com/National.Library.of.Mongolia/>
10. Хятад хэлний үеийн галиг. *Хэлний бодлогын үндэсний зөвлөл*. <https://nclp.mn/content/140>
11. Цэрэндорж Ц., (2003.07.25.). Буруу ярьж зөв ойлгоно оо гэж... *Өдрийн сонин*. https://orch.blogspot.com/2010/07/blog-post_60.html
12. *Азхур номын дэлгүүр*. <https://book.mn/>
13. *Интерном номын дэлгүүр*. <https://internom.mn/>
14. *МУИС-ийн номын сан*. <https://catalog.num.edu.mn/>
15. *ОУУБИС-ийн номын сан* <https://iuu.lib4u.net/>
16. *Үндэсний номын сан*. <https://nationallibrary.mn/catalog/>
17. *Хотын төв номын сан*. <http://koha.pl.ub.gov.mn/>
18. *교보문고*. <https://www.kyobobook.co.kr/>
19. *알라딘 인터넷 서점* <https://www.aladin.co.kr/>
20. *영풍문고*. <https://www.ypbooks.co.kr/>
21. *재단 지원 출판 목록*. 대산재단, (2022.01.24). <https://www.daesan.or.kr/>
22. *번역원지원 출간도서*. 한국문학번역원, (2023.09.25). <https://ltikorea.or.kr/kr/pages/archive/translationBook.do>



МОНГОЛ СОЛОНГОС ХЭЛНИЙ СЭТГЭЛ ХӨДЛӨЛИЙГ ИЛЭРХИЙЛСЭН ҮЙЛ ҮГИЙН ХАРЬЦУУЛАЛТ

(Сэтгэл хөдлөлийн “Баярлах” утга заасан үйл үгийн жишээн дээр)

Магистр Б. Пүрэвжаргал

(ОУУБИС. ХНУС)

purevjargal.b@ulaanbaatar.edu.mn

Abstract:

Verbs are more widely used than other words and are unique in that they are present in every sentence. There is no case where there is no verb in the structure of any language. Therefore, even when expressing emotions, it is necessary to express them with the help of verbs. The characteristics and classification of the verb “Bayarlah”, which expresses emotions in Mongolian and Korean languages, are generally considered with examples. Looking at the classification and characteristics, similarities and differences of the verb “Bayarlah”, which expresses emotions in Mongolian and Korean languages, it can be seen that the classification and diversification in both languages are similar. In Mongolian, positive emotions include the meanings of “bayarlah” and “hayrlah”, while in Korean, positive emotions include the meanings of “bayar tul” and “taashaah”. It has been observed that the speaker expresses his joy not to himself but to the other person, or his mood is expressed in an outward-facing sense, which is quite common in use. However, the verbs related to “Rejoice” in both languages are related to positive emotional meanings, but upon closer inspection, it can be seen that the difference is that while Mongolian is more likely to express gratitude to oneself and others, Korean is more likely to express feelings of joy or pleasure.

Түлхүүр үг: эерэг, хэвшмэл хэллэг, утга, ангилал

Монгол солонгос хүмүүсийн сэтгэл нь хөдлөхөөрөө ямар үгээр хэрхэн илэрхийлдэг мөн ямар үйл хөдлөл ихэвчлэн хийдэг болох зэргээс улбаатайгаар эдгээрийн дотроос ялангуяа баярлах сэтгэлийн хөдөлгөөнөө ямар үйл үгээр илэрхийлэх, тэдгээрийн онцлог, ангилал, адил төстэй илэрхийлэл хир байгааг харьцуулан судлахыг зорилоо. Юуны өмнө хоёр хэлний үйл үгийн талаар товч авч үзвэл **Монгол хэлэнд :**

¹ Үйл үг нь үгсийн аймгийн бусад үгсээс тоо хэмжээ, үүрэг хэрэгцээгээрээ

¹ Лувсанвандан.Ш “Орчин цагийн монгол хэл зүй”, Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, УБ, 1966, 129 т

илүү нарийн хэлзүйн үзэгдлүүдийг агуулсан амин чухал үгс болохыг эрдэмтэн П.Бямбасан тодорхойлсон байна. Монгол хэлний үйл үг нь хэв, байдал, цаг, бие төлөвийн харьцаа заахаас гадна захирах чадвар, тусах, эс тусах, идэвхтэй ба идэвхгүй шинжийг агуулсан байдаг. Монгол хэлний үйл үгс нь гол үгсийн ангилалд багтдаг. Өөрөөр хэлбэл: Үгс Гол үгс Үйл үг Тусах ба эс тусах үйл үг гэж ангилдаг.

Үйлийн нөхцөлүүдийг үгийн бүтцэд тохиолдох байр, гүйцэтгэх үүргээр нь үндэс үүсгэх, үндэс үл үүсгэх нөхцөл гэж хоёр ангилна. Байдлын нөхцөлүүд нь үйл үндсийн дараа орж, өөрөө үйлийн бусад нөхцөлүүдийг залгах үндэс үүсгэдэг байна. Үйлийн үндэс үүсгэх нөхцөлүүдийн нэг хэсэг нь үйл үгийг бусад үгтэй холбох, зарим нь өгүүлбэр төгсгөх үүрэгтэй. Үүн дээр тулгуурлаж холбох ба төгсгөх нөхцөл гэж ангилна. Холбох нөхцөлүүд нь үйл үгийг бусад үгтэй холбох үндсэн үүрэгтэй боловч нэг хэсэг нь үйл үгийг үйл үгтэй, нөгөө хэсэг нь үйл үгийг нэр үгтэй холбодог. Төгсгөх нөхцөлүүд нь өгүүлбэр төгсгөх ерөнхий шинжтэй боловч нэг хэсэг нь цагийн харьцаа, нөгөө хэсэг нь биеийн харьцаа заадаг. Монгол хэлний үйл үгийн нөхцөлүүд нь утга, үүргээрээ бие биеэ нөхөж эсрэгцсэн нарийн тогтолцоотой.

Солонгос хэлэнд: үйл үгийг хувилах үг гэнэ. Хувилах үг гэдэг нь өгүүлэгдэхүүнийг хүүрнэх үүрэгтэй үгс бөгөөд үйл үг, тэмдэг үйл үг багтдаг.² Үйл үг нь “Юмс үзэгдлийн үйл хөдлөлийг заасан үгсийн ангилал”-аар үйл үгийн үндсэн шинж нь “үйл явцын шинж”-д байдаг гэдэг. Үйл үг нь өгүүлбэрийн өгүүлэгдэхүүний үйл хөдлөлийг заадаг бөгөөд хүний үйл хөдлөл болон байгалийн өөрчлөлтийг илэрхийлдэг. Үйл хөдлөл заасан үйл үг, байр байдал заасан үйл үг гэж ч хуваадаг.

Мөн шууд тусагдахууныг шаардаж байгаа бол тусах үйл үг гэх ба шаардахгүй байгааг нь эс тусах үйл үг гэнэ.

Бие даасан шинжээр нь бие даасан үйл үг ба туслах үйл үг гэж хуваана. Туслах үйл үг нь эрхшээлт үйл үгтэй төстэй ба зэрэг залгуурууд нь туслах үйл үгэнд хамрагдаж байгаа ч үүнийг залгаврын шинжтэй туслах үйл үг гэнэ.

Солонгос хэлний үйл үг нь дүрмийн болон дүрмийн бус хувирлаар хувирах бөгөөд үйлийн нөхцөлөөр хэлбэрждэг. Үйлийн нөхцөлийг дотор нь үйлийн бүрэн бус төгсгөх нөхцөл, үйлийн бүрэн төгсгөх нөхцөл гэж ангилна. Үйлийн бүрэн төгсгөх нөхцөл нь үйлийн төгсгөх нөхцөл, үйлийн холбох нөхцөл, үндэс үүсгэн холбох нөхцөл гэж ангилагддаг. Солонгос хэлний үйл үг нь үйлийн айд хамаарагддаг. Үйл үгсийн хувьд авч үзвэл: Үгсийн аймаг (품사) Үйлийн ай (용언) Үйл үг (동사) Тусах, эс тусах үйл үг (자동사, 타동사) гэх мэт.



МОНГОЛ СОЛОНГОС ХҮНИЙ СЭТГЭЛ ХӨДЛӨЛИЙН АНГИЛАЛ

Монгол хүний хувьд: Сэтгэлийн хөдөлгөөн нь хүний амьдрал, үйл ажиллагааны үр бүтээлийг дээшлүүлж хүний танин мэдэх болон бие бялдар, оюун санааны эрчим хүчийг өрнүүлж байвал тэр нь идэвхтэй сэтгэлийн буюу **зэрэг сэтгэлийн хөдөлгөөн** юм. Харин сэтгэлийн хөдөлгөөн нь хүний амьдрал үйл ажиллагааны эрчим хүчийг бууруулж, идэвх сонирхлын түвшинд саад болж, хүний бие бялдар, оюун санааны төвшинг алдагдуулахад нөлөөлдөг бол тэр нь идэвхгүй сэтгэлийн хөдөлгөөн буюу **сөрөг сэтгэлийн хөдөлгөөн** юм.³ Жишээ нь: баяр бахдал, урам зориг, хайр дурлал, хүсэл тэмүүлэл зэрэг нь идэвхтэй сэтгэлийн хөдөлгөөн юм. Энэ хэлбэрүүд нь хүний сэтгэл санаа, үйл ажиллагаанд сайнаар нөлөөлнө. Харин айж эмээх, уурлаж уцаарлах, гуньж гутрах, сандарч мэгдэх зэрэг нь идэвхгүй сэтгэлийн хөдөлгөөн юм.

Зэрэг сэтгэл хөдлөл Сэтгэлийн хөдөлгөөний янз бүрийн хэлбэр байдаг бөгөөд баяр баясгалан, хөгжөөн наргиан, сэргэлэн цовоо байдал, хайр дурлал, инээж цэнгэх, бахархах, талархах, урам зориг, таашааж амтархах, сэтгэл ханах, хөнгөн байдал, тайвшрал зэрэг нь сэтгэлийн эерэг буюу идэвхтэй сэтгэлийн хөдөлгөөнд орно. Сэтгэлийн эерэг идэвхтэй хөдөлгөөн нь хүнийг уян хатан, ээлдэг зөөлөн, аливаа зүйлд баяр бахдалтай, сэргэлэн цовоо ханддаг болгон хүмүүжүүлдэг.

Сөрөг сэтгэл хөдлөл Сөрөг сэтгэлийн хөдөлгөөнд гуньж гутрах, айж эмээх, уурлаж уцаарлах, хорсох, дургүйцэх, эгдүүцэх, хямрах, занах, гомдох, харуусах, үл нийцэх, үзэн ядах зэрэг хэлбэрүүд багтана. Сэтгэлийн сөрөг идэвхгүй хөдөлгөөн нь хүнийг гутранги, өөртөө итгэлгүй, уур уцаартай, унхиагүй, шүүмжлэмтгий, болгон хүмүүжүүлдэг. Сөрөг сэтгэлийн хөдөлгөөн ихтэй хүмүүс өөрийн гадаад байдлаараа дотоод сэтгэлээ халхлан далдалж нууж бусдад илчлэхийг хүсдэггүй.

Солонгос хүний хувьд : Солонгосчууд сэтгэл хөдлөлөө баяр баясгалан, уур хилэн, уй гуниг, баяр хөөр, хайр, дургүйцэл, хүсэл эрмэлзлэл зэрэг олон үгээр илэрхийлдэг. Солонгосчууд сэтгэл хөдлөлөө илэрхийлэхийн тулд сэтгэл хөдлөлтэй холбоотой үндсэн үг хэллэгээс гадна олон янзын нийлмэл болоод зүйрлэл, хэлц хэллэг ашиглан дотоод сэтгэлийн нарийн төвөгтэй мэдрэмжээ илэрхийлнэ. Солонгос хэлэнд сэтгэл хөдлөл илтгэдэг 400-аад үг хэллэг байдаг. Эдгээр үгнээс “баярлаж байна, сонирхолтой юм, баяртай байна, баярлалаа, хайр хүрмээр” гэх мэт үгийг Солонгосчууд байнга хэрэглэдэг гэсэн дүн гарсан байна. Ерөнхийдөө аз жаргал, баяр баясгалан гэх зэрэг сэтгэл хөдлөлийн бүх үгийн эерэг талын үг 30%, харин эвгүй дургүйцсэн өнгө аястай үг 70%-ийг эзэлжээ.⁴

³ Санжжав.Д “Сэтгэл судлал”, УБ, 1999 он, 215 т

⁴ Солонгос хэлний цогц сурах бичиг – 4

Солонгосчууд Күнзийн уламжлалт сургаал ёсоор сэтгэл хөдлөлөө ил харуулах ёсгүй хэмээн заалгаж ирсэн ард түмэн. Тиймээс гудамд Солонгос хүнтэй таарвал нүүрний ямар ч хувиралгүй байдаг гэж гадаадынхан ярьдаг байв. Харин орчин үеийн залуус сэтгэл хөдлөлөө ил тод илэрхийлэх нь нэмэгдэж байна. Сэтгэл хөдлөлийг ангилахдаа эерэг ба сөрөг гэсэн ангилалд авч үзсэн байна. Эерэг сэтгэл хөдлөлд баяр хөөр, хайр таашаах зэрэг багтдаг бол сөрөг сэтгэл хөдлөлд айдас, жигшил зэвүүцэл, уйтгар гуниг, гутамшиг, уур хилэн зэрэг багтдаг.

Монгол солонгос хэлний “Баярлах” сэтгэл хөдлөлтэй холбоотой үйл үгийн тухайд

Өгүүлэгчийн эерэг сэтгэлийн байдал бүхий үнэлэх баймж утга

Өгүүлэгч ямар нэгэн тодорхой учир шалтгааны улмаас хөөрөн баясаж сэтгэл нь ихэд хөгжсөн утга үүнд хамаардаг. Өгүүлэгч баярласан сэтгэлээ өөртөө бус харин харилцагч бусад этгээдэд хариу болгож илэрхийлсэн буюу түүний сэтгэлийн байдал гадагшаа хандсан баймж утга.

Монгол хэлэнд: Монгол хэлний баярлах утга нь юуны улмаас илэрч байгаагаар нь дараахтай адил ангилж болно.

1. Өгүүлэгч ямар нэгэн тодорхой учир шалтгааны улмаас хөөрөн баясаж сэтгэл нь ихэд хөгжсөн утга үүнд хамаардаг. Тухайн өгүүлэгчийн сэтгэлийн байдал, хөөр баярын шалтгаан, харилцааны хандлагаар нь энэхүү баймж утгыг нарийвчлан тодорхойлж болно. Хэл судлаач, багш Г.Гантогтох /1987/, Ц.Сүхбаатар /1988/, М.Базаррагчаа /1993/, Б.Пүрэв-Очир /1993/ нар энэ утгын талаар дурджээ. Жишээлбэл:

(1) Энэрэнгүй сайхан санагдахад элэг зүрх минь догдолж, хосгүй баярын нулимс хоёр нүдийг минь бүрхдэг. (Ч.Чимэд).

Дээрх жишээ нь баярлах утга нь **“хосгүй баярын нулимс”** гэсэн хэсэгт байгаа бөгөөд сэтгэл нь хөөрч баярласандаа нулимс гарах гэж тухайн хүний хир зэрэг баярлаж бахдаж байгааг мэдэж болох юм.

2. Гаднын ямар нэгэн үйл явдлын үр дүнд өгүүлэгчийн сэтгэл хөөрөн баярласан баймж утга. Ийм тохиолдолд өгүүлэгч ихэвчлэн өөртөө хандсан байх бөгөөд баярласан сэтгэлийн төв нь голдуу өөрт нь оногдсон байдалтай юм. Жишээ нь:

(2) Ээ гялай, гялай, ямар азаар даргатайгаа тааралдав (Л.В).

(3) Дээрх жишээ нь тухайн хүн өөр өөртөө баярлаж байгаа утга илтгэснийг дотроо даргатайгаа тааралдаасай гэж бодож явснаар нь дүгнэж болно.

Тийнхүү дотроо бодож явсан сэтгэлээ илэрхийлэхдээ **өөрөө өөртөө баярлаж, өөрийн эрхгүй баярлах сэтгэл** өөрт нь төрж байгаа болно.

3. Өгүүлэгч баярласан сэтгэлээ өөртөө бус харин харилцагч бусад этгээдэд хариу болгож илэрхийлсэн буюу түүний сэтгэлийн байдал гадагшаа хандсан баймж



утга. Өгүүлэгч болоод харилцагчийн харилцан эргэх холбоон дээр энэ утга илрэх тул харилцааны учир холбогдолтой байна. Жишээ нь:

(4) Та ч нэгэн адил баярлах болов уу. (Я.Цэвэл, МХТТТ)

Жишээнээс харахад харилцагч талын баярлах сэтгэлийг онцолж байгаа буюу, өөрөөр хэлбэл өөртөө бус харилцагч буюу бусад этгээдэд хариу болгож илэрхийлсэн сэтгэлийн гадагш байдал ажиглагдаж байна.

(5) Нээрээ би ойлгодоггүй байснаас биш Бадам минь надад хэзээнээс хайртай байсныг би сүүлд мэдсэн. Намайг хүний зэрэгт хүрэхэд минь ч ёстой нөхрийн ёсоор тусалсан юм даа. (Л.В)

Дээрх жишээ нь 3-р жишээнээс арай өөр байгаа нь Бадамын тус болсонд нь баярлаж байгаа сэтгэлээ илэрхийлэхдээ **юу хийж өгсөн буюу тус болсныг нь дурсан санаж** байгаа бөгөөд цэвэр харилцагч хүндээ хандсан жишээ юм.

Энэхүү хэв маягийн утгыг талархах баймж утга хэмээн давхар тодотгож болох юм. Энэ утга нь баярла-, гялай-, таларха-, сэтгэлийн тал өг- гэх мэт үйл үг, хэллэг задлаг хам бүтцийн тусламжтайгаар ил илрэх нь нэлээд түгээмэл юм. Жишээ нь:

(5) А. Над тус болсонд чинь их гялайлаа. /도와 주셔서 너무 감사합니다./

Б. Тус хүртэж гялайв. /도움을 받았으니 감사했다./

В. Хүсэл ханаж гялайв. /원한대로 됐으니 감사했다./

(6) За хүү минь гялайлаа даа, ах чинь ер нь чиний ачийг хэзээ ч мартаггүй (Л.В), Та чухам намайг аварлаа. Би ер танд яая даа, юугаа өгье(Ч.О).

(5а, б, в) болон (6)-д гарч байгаа гялайх гэдэг үйл үг нь талархах, баярлах баймжын утгад орж байгаа бөгөөд ихэнхдээ уран зохиол, өгүүллэгт илэрдэг бол ярианд баярлах гэдэг утгаараа илэрдэг.

Баярлан талархах эл утгын хүрээнд өгүүлэгчийн зүгээс бусад этгээдэд баяр хүргэсэн, амжилт хүссэн зэрэг сэтгэлийн гадагш хандсан байдал илэрхийлэх утга багтана. Жишээ нь:

(7) Баяр хүргэе чамд. Чи надтай маргааш уулзах уу(Ч.Л).

Уг жишээн дээр талархах утгад хамрагдах бусдад баяр хүргэсэн утга хамрах хүрээний хэмжээнд илэрхийлэгдэж байгаа утга бүхий баяр хүргэе хэмээх үг нь эл утгыг гаргаж өгч байна.

Хэрэв талархах утга нь “нэгдүгээр этгээд – хоёрдугаар (талархагч) этгээд – нэгдүгээр этгээд” гэсэн харилцааны эргэх холбоонд үндэслэдэг бол таашаах утга нь зөвхөн “нэгдүгээр (таашаагч) этгээд – хоёрдугаар этгээд” гэсэн чиглэл бүхий харилцааг илэрхийлдэг.

Өгүүлэн үнэлэгч эзэн бие бусад этгээдэд таашаан үзэх маягаар, зөвхөн нэг чиглэлээр хандсан эл утгыг “ойшоох, тоомсорлон үзэх, сэтгэлдээ сайшаах” хэмээн тодорхойлсон нь бидний баримтлалд нийцэж байна. Таашаах баймж утга нь

баярлах баймж утгын бусад эгэл утгаас гадна зөвшөөрөх баймж утгын гуравдах хэв маягтай зарим үед сүлжилдэн холбогдож илэрдэг. Энэ утгыг илэрхийлэхэд ашгүй, за яамай, яасан сайн юм, яасан сайхан юм. юутай сайн, юутай сайхан гэх мэтийн үг хэллэг нэлээд тогтвортой хэрэглэгдэж байна. Ажиглалтаас үзвэл, энэ хэв маягийн баймж утгыг илэрхийлэхэд чанар, эерэг үнэлэмж заасан тэмдэг нэр ихээхэн оролцдог байна.

Солонгос хэлэнд: Долоон мэдрэмжээс баяр хөөр (희(喜))-т багтдаг сэтгэл хөдлөл болох “баяр хөөр”-тэй утгыг агуулсан үйл үг гэвэл дараах үгс юм. (Хүснэгт – 1) “Баяр хөөр”-ийн утгад хамаарагдаж байгаа сэтгэл хөдлөл илэрхийлсэн үйл үг нь “хайр”-ын утгад хамаарах сэтгэл хөдлөл илэрхийлсэн үйл үгтэй хамт сэтгэл хангалууныг багтаасан сэтгэл хөдлөл илэрхийлсэн үйл үг гэсэн талаас нь нийтлэг юм. “Баяр хөөр” болон “Хайр”-д багтдаг үйл үгсийн ялгаатай тал нь “баяр хөөр”-д багтдаг үйл үгс нь баяр хөөр болон тухайн байдлыг илэрхийлдэг үгс бөгөөд, “хайр”-д багтдаг үйл үгс нь “хайрын сэтгэл хөдлөл”-өөр дамжуулан хоёрдох “баяр хөөр”-ийн утгыг оролцуулж байдаг.⁵

Хүснэгт-1 “Баярлахыг дотор нь доорхтой адил ангилж болно.”

Ангилал	Сэтгэл хөдлөл заасан үгс	Жишээ
1.Баярлах утга	들뜨다 - сэтгэл хөөрөх, гэгэлзэх, сал맛나다 - амьдралын амт, хүслэн, 설레이다 - гэгэлзэх, догдлох, байж ядах, 기뻐하다 - Баярлах, 신명나다 -урамтай, баяр хөөртэй, 신바람나다 - баяр хөөр төрөх, 우습다 - инээдтэй, хошин, 즐기다 - дуртай байх, дурлах, 황홀하다 - гял цал, 흐뭇하다 -гааламжтай, хангалуун, 흥겹다 -хөгжилтэй, хөөртэй, 흥나다 - сэтгэл догдлуулах, 흥분하다⁶ -хөөрөх г.м	시험에 합격하여 기뻐하다 -шалгалтанд тэнцэж баярлах, 봄이 되면 마음이 들뜨게 쉽다 -хавар болохоор сэтгэл санаа гэгэлзэхдээ амархан байдаг, 낚시를 즐기다 - загас барихад дурлах, 남의 행복을 부러워하다 -бусдын аз жаргалд атаархах г.м

Сэтгэлийн хөдөлгөөний баярлахтай холбоотой хэвшмэл хэллэг

Од нь гялалзах. /Аз хийморьтой байх, ажил үйлс нь өөдрөг байх./

Жишээ нь: Тэр ч ёстой од нь гялалзаж яваа залуу даа. /Б.Бааст. Хоёр хун./

⁵ Тиймээс “баяр хөөр”-ийн утгын хүрээнд баяр хөөрийг шууд илэрхийлдэг үйл үг л багтдаг гэж ялгаад “хайр”-ын утгын хүрээтэй тусдан авч үзэх болжээ.

⁶ Хөөрөх(흥분하다) нь тухайн нөхцөл байдлаасаа хамаараад сэтгэл хангалуун, сэтгэл хангалуун бус байдлыг хоёулангаар нь хэрэглэдэг. Сэтгэл хангалуун байдлыг зааж байх тохиолдолд “баяр хөөр”-ийн хүрээнд хамаарагддаг бол сэтгэл хангалуун бус байх үеийн утгыг гаргаж байгаа тохиолдолд “уур хилэн”-гийн хүрээнд хамаарагдана.



Гэрт чухам хэн ч үгүй байснаа Баяр гүнгийн дуу эхлэн сонсдов. – Ингээд үнэнийг хэлэхэд залуу жанжин чи сайн байна. Дайны чинь од ид сайхан орой дээр чинь гялалзаж яваа юм байна. Араас чинь улаан орос туслах л биз. Гэлээ ч чи дийлэх үү? /Д.Намдаг. Цаг төрийн үймээн./

Нулимс гарах. /Сэтгэл хөдлөх./

Жишээ нь: Өнчин хоцорсон намайг хүн болгосон ачийг нь бодохоор өөрийн эрхгүй нулимас гараад ирдэг юм. Харин би тэр ачийг нь хариулж чадсан билүү, яалаа гэж тэр үед өөрөөсөө өөрөө асуудаг байж билээ.

Ээжийн тухай дуу дуулахаар хар аяндаа нулимас гардаг боллоо. Нас тогтож байгаагийн шинж юм уу даа. Олимпийн аваргын алтан медаль зүүж эх орны төрийн дуулал эгшиглэхэд нүднээс нулимс гарч билээ.

눈물이 나다. /눈물이 날 정도로 어떠한 감정이 생나다./

예) 창문을 열어봤죠. 하얀 눈이 소복이 내려와 있었죠. 내 눈엔 눈물이 내리죠.

Самсаа шархирах, хоолой зангирах, аньсага чийгтэх. /Нулимас гарахуйц сэтгэл хөдлөх./

Жишээ нь: Хурдан морины түрүүч барианы газар луу орж ирэхийг хараад самсаа шархирдаг болжээ. Нас ахисны шинж биз. Залуу насныхаа эмгэнэлт амьдралын тухай тэр хүүрнэхдээ үе үе хоолой нь зангирч, сонсож суусан миний аньсага чийгтэж, тодруулж асууж ч чадсангүй, эцэст нь шүүрс алдаж билээ.

눈시울을 붉히다. /눈물을 흘릴 만큼 감동하다. 울다./ *눈시울: 눈의 언저리의 속눈썹이 난 곳.

예) 그는 사연을 털어놓으면서 눈시울을 붉히다 결국 얼굴을 적셨다. <이찬우, 정몽준 출생 비밀, 2002>

Нар гарах. /Хүсэн хүлээсэн баярт үйл явдал болох, туйлын хүсэл биелэх./

Жишээ: Хойт даваан дээгүүр улаан туг хийсэн үзэгдэхэд хүлээстэй хүмүүсийн нар гарч, ардын цэргийн ура хашгирахад авилгач дайснуудын сүнс зайлан, ард түмний сүлд хөгжино. /Д.Нацагдорж. Үзэгдээгүй юм./ Арай гэж нэгэн өдөр Ерөөлт эргэж ирэхэд Болормаагийн нар гарч уйтгарлахыг түр зуур мартана. /Л.Түдэв. Уулын үер./ Энэ байдал Сайнцогийн сэтгэлийг гүйцэд баясган, насан туршдаа үзээгүйгээр “нар нь гарч” яваа шив гэлтэй харагдана. /Ж.Пүрэв. Ундрах инженер./

동이 트다. /새벽이 되어 동쪽 하늘이 밝아오다. 새 세상이 시작되다. *동: 동쪽. ‘동이 트다’는 ‘동쪽 하늘이 밝아 온다’는 뜻이다./

예) “2차 세계 대전이 끝나 이후 우리 민족에게도 동이 트기 시작했다.” **뽕하고 해 뜰 날.** /운이 트일 때./

예) “이제 정말 뽕하고 내 인생에도 해가 떴구나 싶었는데, 아뿔싸 IMF가 터졌다.” <김상경, 사과나무>



Хөл алдах. /2. Ихэд баярлах./

Жишээ: Баяр сургуулиа тарахаар Бадмаагаа дагуулаад харивал ээж яах бол? Баярлаад хөл алдана даа гэж бодохоос нэн сайхан санагдав. /Н.Банзрагч. Тэр жилийн хавар./ Энэ бол Содномынх байсан бөгөөд “Биднийг хамба багш явуулсан” гээд ирэгсдийн нэгний хэлснийг сонсмогц Содном хөл алдан тарган мах чанав. /Ч.Лодойдамба. Тунгалаг Тамир./

Хөл газар хүрэхгүй. /Маш их баярлах./

Жишээ: Нутагтаа очиж Дугар аавтайгаа уулзана гэхээс түүний сэтгэл хөөрч хөл газар бөөн баяр болж байлаа. /Н.Банзрагч. Зам./ Балжид ахайтан баярлаж хөл нь газар хүрмээргүй хөнгөрчээ. /Т.Нацагдорж. Алтан хүүхэд./ Дамба хотод хэд хонохдоо хөл газар хүрэхгүй баярлаж явав. /Д.Гармаа. Цагаан булаг./ Хас-Эрдэний эх хажуунаас: Энэ чиг Хоролмааг үзээд бүр хөл нь газар хүрэхгүй байгаа байх... гэв. /Д.Ядамсүрэн. Гурван хүүхэн./

Зүрх маажих. /Сэтгэлийг уяруулан догдлуулах, сэтгэлийг хөдөлгөх гогдох./

Жишээ: Санамсаргүйбайтал,модонбайшингийнцонхнызавсраарнэгхөгжмийн эгшиг шургалан орж ирээд, суусан Чулууны зүрхийг маажлан догдлуулахад даруй сэтгэл тогтож ядан, түүнийг дагуулан гадаа гарав. /Д.Нацагдорж. Нэгэн сэтгэлийг бөмбөрүүлсэн үе./ Яаран дугуйндаа мордож гүйцэн иртэл охин гэдрэг алгуур эргэж, эелдэг хос нүдийн инээмсэглэн тормолзох тусгалаар Жалцаны цээжийг шарх гартал нэвтлэн харж, доторхи зүрхийг маажсаар аажим алхан бяцхан улаан хаалганд оров. /М.Ядамсүрэн. Залуу хос./

심금을 울리다. /외부의 자극을 받아 마음의 감동을 일으키다. *심금: 외부의 자극을 받아 움직이는 미묘한 마음./ 예) “그의 살아온 이야기는 듣는 이의 심금을 울렸다.”

Хамрын үзүүр шархирах, хамар шархирах. /Сэтгэл хөдлөн нулимас гарах дөхөх./

Жишээ: Соёолон морины түрүүч бариа руу орж ирэнгүүт унасан хүүхдийг нь хараад хамрын үзүүр шархираад ирэв. “Жинжиймаа” киноны эх, охин хоёрын уулзалтын хэсгийг үзээд хамрын үзүүр шархирч билээ.

코끝이 찡하다. /눈물이 날 정도로 슬프거나 감격스럽다./

예) “나를 돌봐주는 그녀의 모습을 보니 코끝이 찡해졌다.”



ДҮГНЭЛТ

Монгол солонгос хэлний “Баярлах” сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлсэн үйл үгийн утгын ангилал хийгээд онцлог, адил төстэй тал болон ялгаатай талыг харвал тус хоёр хэлэнд ангилж, төрөлжүүлсэн байдал нь төстэй гэж харагдахаар байна. Монгол хэлэнд эерэг сэтгэл хөдлөл дотор “баярлах”, “хайрлах” утгууд, багтдаг бол Солонгос хэлний хувьд ч мөн л адил эерэг сэтгэл хөдлөл “баяр хөөр”, “Таашаах”-утгуудад ордог байна.

Өгүүлэгчийн эерэг сэтгэлийн байдал бүхий үнэлэх баймж утга нь өгүүлэгч ямар нэгэн тодорхой учир шалтгааны улмаас хөөрөн баясаж сэтгэл нь ихэд хөгжсөн утга үүнд хамаардаг. Өгүүлэгч баярласан сэтгэлээ өөртөө бус харин харилцагч бусад этгээдэд хариу болгож илэрхийлсэн буюу түүний сэтгэлийн байдал гадагшаа хандсан сэтгэлийн хөдөлгөөн байна. Мөн тухайн өгүүлэгчийн эерэг сэтгэлийн байдал бүхий үнэлэх баймж утга нь өгүүлэгч ямар нэгэн тодорхой учир шалтгааны улмаас хөөрөн баясаж сэтгэл нь ихэд хөгжсөн утга хамаардаг. Өгүүлэгч баярласан сэтгэлээ өөртөө бус харин харилцагч бусад этгээдэд хариу болгож илэрхийлсэн буюу түүний сэтгэлийн байдал гадагшаа хандсан баймж утгаар илэрч байгаа нь хэрэглээнд нилээд нийтлэг байгаа нь ажиглагдлаа. Гэвч тус хоёр хэлний “Баярлах”-тай холбоотой үйл үгс нь сэтгэл хөдлөлийн эерэг утгад хамаарагдаж байгаа боловч нягтлан харвал монгол хэлэнд өөртөө болон бусдад баярлаж талархсанаа илэрхийлэх нь илүү давамгайл байхад, солонгос хэлэнд баяр хөөр болох эсвэл таашаах мэдрэмжийн илэрхийлэл илүү байгаа ялгаатай тал гэж үзэж болохоор байна.

НОМ ЗҮЙ

Монгол ном зүй:

1. Мөнх – Амгалан. Ю, “Орчин цагийн монгол хэлний баймжийн ай”, УБ, 1998 он
2. Өнөрбаян. Ц, “Орчин цагийн монгол хэл”, УБ, 2008 он
3. Уянга. Х, “Монгол Солонгос хэлний сэтгэл хөдлөлийг илэрхийлэх өвөрмөц хэлцийн харьцуулсан судалгаа” магистрын зэрэг горилох бүтээл, УБДС, 2008 он
4. Нарантуяа. Ж, “Монгол Солонгос хэлний туслах үйл үгийн харьцуулсан судалгаа” магистрын зэрэг горилсон бүтээл, УБДС, 2012 он
5. Цэвэл. Я, Монгол хэлний товч тайлбар толь, УБ, 2013 он



6. Солонгос номзүй:
7. 김향숙. 2003. "한국어 감정표현 관용어 연구." 인하대학교 대학원 국어국문학과.
8. 김향숙. 2001. "한국어 감정표현 관용어 연구." 인하대 박사학위논문.
9. 김은영. 2004. "국어 감정동사 연구." 전남대학교 대학원 국어국문학과.
10. 김은영. 2005. "현대국어 감정동사의 범위와 의미 특성에 대한 연구." 한국어의미학.
11. 임은하. "감정동사 연구."
12. 김세중. 1994. "국어심리술어의 어휘의미구조." 서울대학교 언어학과 박사학위논문.
13. 박영준. 1991. "국어 명령문 연구." 고려대 박사학위논문.
14. 홍종선.정연주. "감정동사의 범주 규정과 유형 분류."
15. 한몽 사전. 몽골국립대학교 한국학과.



КИРИЛЛ БИЧГИЙН ЗӨВ БИЧИХ ДҮРМИЙН АСУУДАЛД

*(Их дээд сургуульд суралцагчдын түгээмэл алддаг зөв бичих дүрэмд хийсэн
ажиглалтын жишээгээр)*

Магистр Л. Мятаг

(Боловсрол, Соёл эрх зүйн дээд сургууль)

myadag@ecl.com

ABSTRACT

One of the most important issues to be addressed in the use of language by students is the fact that people today do not follow the norms of written language, write incorrectly, and do not understand the grammar.

On the one hand, they do not seem to know the rules of correct writing, but on the other hand, the process of globalization and technology are affecting the lives of students, and they are in danger of violating the norms of written language.

Therefore, the aim is to address this issue, observe the grammar that students lose the most in their “Mongolian Stylistics” course, study how written language norms are violated, and find a way to write without mistakes.

ТҮЛХҮҮР ҮГ

Кирилл бичгийн зөв бичих дүрэм, түгээмэл тохиолддог хэл зүйн алдаа, хэлний дархлаа

УДИРТГАЛ

Эдүгээ бид дэлхий нийтээрээ даяаршлын, мэдээллийн эрин зуунд амьдарч байна. Шинжлэх ухаан, техник технологи өндөр хөгжсөн өнөөгийн нийгэмд улс үндэстэн бүр хэл соёлоо хадгалж хамгаалах, үндэсний ондоошлыг авч үлдэх, улам хөгжүүлэх бодлого баримталж, өөрсдийн оршин байхуйг хамгаалдаг.

Монгол Улсад хэл соёлоо хөгжүүлэх, тусгаар тогтнолоо хамгаалах, өв соёл, уламжлалаа хадгалах, хэлний дархлаагаа сайжруулахын тулд төр засгаас төрөл бүрийн арга хэмжээ авч байгаагийн нэг нь нийгэм хэл шинжлэлийн чухал судлагдахууны нэг болох хэлний бодлогын тухай асуудал юм. “Улс орон

нийгмээс хэлний асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн үзэл суртлын зарчим болон практик арга хэмжээнүүдийн нийлбэр цогцыг хэлний бодлого”¹... гэнэ. Аливаа улс үндэстэн бүр эх хэл, соёлоо хамгаалах, хөгжүүлэх, боловсронгуй болгоход төрөөс баримталж буй хэлний бодлого чухал үүрэгтэй байдаг.

Хэлний бодлогын нэн чухал асуудлын нэг иргэн бүр бичгийн хэлний хэм хэмжээг сахих, зөв бичих дүрмийн алдаагүй бичих явдал юм.

Монголчууд эрт дээр үеэс бичгийн соёлын асар их уламжлалтай ард түмэн бөгөөд монгол хэл нь монгол үндэстний оюуны соёлын үнэт өв, үндэсний соёл иргэншлийн язгуур үндэс, улс орны нэгдмэл байдал, үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын нэгэн баталгаа мөн² юм.

Эх хэлнийхээ тогтвортой байдлыг хангахын тулд төрөөс бодлогоор дэмжиж, “Монгол хэлний тухай хууль”-ийг 2015 онд батлуулсан бөгөөд энэхүү хуульд:

8.1.Монгол улсын хэмжээнд кирилл болон үндэсний бичгийн зөв бичих тус тусын нэгдмэл дүрэмтэй байх бөгөөд иргэн, хуулийн этгээд уг дүрмийг дагаж мөрдөнө. 19.1.1.монгол хэлний зөв бичих дүрэм, орчин цагийн утга зохиолын монгол хэлний хэм хэмжээг чанд баримтлах;

20.1.1.монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, монгол хэлээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар санаачилга гаргах;

20.2.1.монгол хэлний хэм хэмжээг дагаж мөрдөх;

15.1.3.энэ хуулийн 21.1-д заасан эрх бүхий байгууллагын баталсан кирилл болон үндэсний бичгийн хооронд харилцан хөрвүүлэг хийх, зөв бичих дүрмийн алдаа хянах болон бусад холбогдох программын хэрэглээг нэмэгдүүлэх, цахим орчинд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;³ хэмээн заажээ.

Мөн 2018 оны 08 сард МУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь”-ийг эрхлэн гаргаж, орон даяар хэрэглэж байгаа билээ.

Техник технологи хөгжиж, дэлхий нийтээр даяаршиж буй өнөөгийн нийгэмд кирилл бичгээр зөв бичих дүрмийг төдийлөн анхаарахгүй байгаагаас оюутан сурагч, албан хаагч, иргэд хөдөлмөрчид алдаатай бичих нь түгээмэл үзэгдэл болсноос гадна бичгийн хэл, ялангуяа цахим орчин дахь зөв бичих зүйн асуудал хэм хэмжээнээсээ хэтэрч, бичихдээ зөв бичгийн дүрэм баримтлахгүй бичих нь түгээмэл болжээ.

¹ Ширнэн.Б. (2006).Монголчуудын үсэг бичгийн хэрэглээг нийгмийн хэл шинжлэлийн үүднээс судлах нь. УБ

² Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь.,(2018),УБ., 4 дэх тал

³ Монгол хэлний тухай хууль.,(2015)



Өнөөдөр монголын нийт хүн амын 80 орчим хувь нь цахим сүлжээ ашиглаж байна гэсэн судалгаа байдаг. Тэдний 80 гаруй хувь нь 10-35 насныхан байна. Гэтэл цахим сүлжээнд бичгээр харилцаж буй хүмүүсийн ихэнх хувь нь хэлний дуудлагаар бичих, үг товчлох, гадаад үг хэрэглэх, хэл ярианы соёлд харшлах үг хэллэг хэрэглэх зэрэг түгээмэл алдааг гаргадаг.

Иймд энэхүү өгүүлэлдээ бид дээрх асуудлыг хөндөж, “Бага ангийн багш” мэргэжлээр суралцаж буй оюутнуудын бичгийн хэлэнд түгээмэл тохиолддог алдаануудыг ажиглан, дүгнэлт хийхийг хичээлээ.

ҮНДСЭН ХЭСЭГ

Монгол хэлний тухай хуулийн 8.3-д кирилл болон үндэсний бичгийн зөв бичих дүрмийг баримтлан зохиосон толь бичгийг энэ хуулийн 22.1-д заасан эрх бүхий судалгааны байгууллага хянаж, эрх бүхий байгууллага хэлэлцэн батална...” гэж заасны дагуу үндэсний бичгийн зөв бичих дүрмийг батлуулж, толийг нэгтгэн хэвлүүлэх; Монгол хэлний үндэсний хөмрөг (national corpus) бий болгох ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга аргачлалаар, чанартай, гүйцэтгэх; Үндэсний бичгийн нэгдсэн цахим хуудас (portal site)-ыг үүсгэж, хөгжүүлэх; Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 11 дүгээр зүйлийн 11.1.2, 24 дүгээр зүйлийн 24.2-г заасны дагуу 2025 оноос төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулах хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2019, 2022 онд хийсэн Төрийн албан хаагчийн монгол бичгийн мэдлэгийн түвшнийг тогтоох гурав дахь шатны судалгааг 2024 авч, үндэсний бичгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах; Кирилл бичгийн зөв бичих дүрэм, толийг дагаж мөрдөх ажлыг олон нийтэд сурталчлах, хэвшүүлэх; Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан брайль, сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан уншдаг ном зохиох зэрэг ажлуудыг төлөвлөн хийж эхлээд байна.

Бид эхний ээлжинд суралцагчдаар төрөл бүрийн эсээ бичүүлж, эсээг хянах замаар зөв бичих дүрмийн алдааг ажиглав. Тус судалгааг хийхдээ багш:

1. Суралцагчдад тодорхой сэдэв, үгийн тоог өгч төрөл бүрийн эсээ бичүүлэх;
2. Хичээлийн тэмдэглэл, өдөр тутмын бичгийн хэлийг ажиглах.
3. “Монгол хэлэнд эргэлзээтэй бичигддэг үгс” тоглоом зохиох;
4. Хичээлийн агуулгатай холбоотой асуулт өгч, бичгээр хариулт авах;

5. Тодорхой сэдвийн дагуу мэдээ мэдээлэл, илтгэл бичүүлэх;
6. Баримт бичиг боловсруулах:Өргөдөл, тодорхойлолт, сурлага хүмүүжлийн тодорхойлолт, ажлын төлөвлөгөө бичүүлэх зэрэг бичгийн хэлний хэм хэмжээг зөв хэвшүүлэх төрөл бүрийн дасгал даалгавруудыг ажиллуулж, гүйцэтгэсэн даалгавар дээр ажиглалт хийлээ.

Энэ судалгаанд 2023-2024 оны хаврын улиралд “Монгол хэлний найруулга зүй” хичээл сонгон судалсан 100 оюутан оролцов. Тэднээс 30 оюутны ажлыг түүвэрлэн авч, ажиглалаа. Багш суралцагчдын даалгаврыг авч, зөв бичих дүрмийн алдаан дээр ажиглалт хийж үзэхэд, олон алдаа байсан. Үүнд:

Жишээ 1. Цэг цэглэлийн дүрэм. Том үсгийн дүрэм

~~өО~~доогоор маш хурдтай хөгжиж байгаа уг тоглоомын “Дэлхийн аварга” ~~гэсэн~~ цолыг авахыг би зори~~ь~~сон байгаа юм. Мөн амжилт гэдэг амар олдохгүй. Уудахгүй 9_сарын1-нээс 9_сарын 20 хүртэл үргэлжлэх юм. ~~тТ~~эр үед бүх чаддаг зүйлээ харуулж хичээх болноо.

~~Харин дараагаар нь бБи~~ их туранхай хүүхэд 178см 59кг гэдэг бол маш туранхай. ~~тТ~~эгээд би усан бассайн фитн~~е~~эсст явж өөртөө таарсан бага зэрэг масс нэмхээр зор~~ь~~иж байна. ~~сон мМ~~агадгүй 1_жил явах шаардлагатай байгаа. Одоо бага зэрэг холын зорилгоос дурдвал сургуулиа амжилттай төгсөж аав ээжийг~~а~~ээ баярлуулахыг маш их хүс~~ч~~эж байгаа.

Хүн болгон_л ШУТИС төгсдөггүй хэцүү яанаа гэх мэт хэлж байсан_ч би нэг өдөр Сод-Од багшийн ботгонуудад зориулсан бичлэгийг үзээд тэрээр өөрөө хичээлдээ дуртай байгаад цааш нь гүнзгий ухах мэдээд сурвал 3.5+ гол~~ч~~жтой төгсөж болохыг надад ойлгуулсан. ~~Эзэн~~ хичээвэл заяа хичээнэ шүү_дээ... Хүний амьдралд ойрын холын жижиг том маш олон зорилго бий.

~~Х~~харин миний ойрын том зорилго бол ~~энэ~~???? юм. Үг 221

Жишээ 2. Гээгдэх эгшгийн дүрэм: Г+Урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад, эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гээгдэнэ.

Монголдоо өөрсдийн гэсэн технологийн компанитай болж гаднаас авах биш гадаад руу гаргах зорилготой. ~~Тээхийн туядИйм учраас~~ энэ мэргэжилийг би сонгож орсон. Миний зорилго бол монголд энэ мэргэж~~ил~~ээр ажил~~лаж~~, амжилттай явж өөрийн хүссэн зүйлдээ хүрэх хэрэгтэй.

Жишээ 3. Зарим тийн ялгалын нөхцөлийг буруу бичих. Тухайлбал: Өгөх оршихын тийн ялгал: шалгалтанд, амжилтанд, сургалтанд гэх мэт.

~~нь~~ надад сонирхолтой байдаг. Гудамжинд гуйлга гуйж суугаа хүүхдээ тэвэрсэн эхийн хажуугаар алхаж өнгөрөх, дэлхийн хамгийн баян хүнийг яаж амжилтанд хүрснийг



Жишээ 4. Зарим тийн ялгалын нөхцөлийг буруу бичих. “-ийн, -ийг, -ын, -ийг” нөхцөл

орчинтой томоохон холбоотой байдаг. Харин цагийн эрхэнд зарим мөрөөдөл нь мартагдаж өнгөрөх ч хэвийн үзэгдэл юм. Хүүхэд нийгэмшиж сургуульд суралцахын явцад мөрөөдөл нь илүү бодит байдлыг олж зүгээр мөрөөдлөөс амьдралын зорилго болон хувирдаг. Бусдыг л адил би ч мөн бага балчир байхдаа мөрөөдөж, өсөж томрох тусам уг мөрөөдлөө зорилго болгон түүнийхээ төлөө явж байна.

Жишээ 5. Нэршүүлэх “-х” дагаврыг буруу бичих

сонингоос унших мэт эдгээр зүйлсийг би өөрийн сонголтоо хийхэд идэвхиждэг юм шиг. Энэ яг л надад зориулагдан цаанаасаа кодлогдчихсон мэт. Магадгүй өөр нэгэн ертөнцөд өөрийн “бас нэг” амьдралаасаа уйдаж, хийсвэр ертөнцөд одоогийн миний амьдрал гэдэг тоглоомыг бүтээсэн суут программистын тоглоомны гол дүр байх. Хэрвээ би Шинжлэх Ухаан Технологийн Сургуульд элсэн орохгүйгээр өөр их дээд сургуулийг сонгосон бол энэ эсээг бичиж суух гэсэн код идэвхижихгүй байсан байх. Шинэ танилууд, хичээл заах

Жишээ 6.

“-Я”-гийн төрлийн урт эгшгийг буруу бичих.

Миний хувьд алсын зорилгоо их нандигнаж нууцалдаг яагаад ч юм энэ бүхэн надад нууц хувь хүний орон зайд байх ёстой юм шиг санагддаг учир нь нууцлаг байх тусмаа илүү нандин чухал зүйл минь байж чадах юм болов уу гэж хувьдаа боддог. Харин ойрын

Жишээ 7.

Заримдаг гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгчээр төгссөн залгавар залгахад эгшиг жийрэглэнэ. Бусдадаа, нөхдөдөө, ажилчдадаа гэх мэт.

Харин миний хувьд би өөртөө холбоотой бүхий л хүмүүст чин сэтгэлээ зориулж чаддаг сайн хүн болохыг хүсчэж байна. Би зүгээр л сайн найз, сайн хүүхэд байхыг л хүсчэж байна. Энэ бол миний туйлын хүслэн, туйлын зорилго. Дэлхий дээр байх энэ хугацаандаа алдар нэрийн төлөө яваад яах ч

Жишээ 8.

Дараалсан 2,3 гийгүүлэгчийн дүрэм

Хүн төрөлхтөн хаанаас үүссэн юм бэ?


Хүн төрөлхтөн хаанаас үүсэн гэж олон таамаг байдаг. Харь гаригаас гаралтай үсэл мөн загас зэрэг ямар нэг өвөрмөц зүйлээс хүн үүссэн үүсэл гэж олон сонирхолтой баримт байдаг ч шинжлэх ухааны үндэслэлээр гаргаснаар хүн мич хомо хобистаас үүссэн гэж одоогоор үзээд байгаа юм. Чарльз Дарвин: Хүн нь мичний төрлийн амьтнаас үүссэн буюу байгалийн-байгалийн шалгарлиг Эволын онолыг гарган хэлсэн байна. 200 жилийн Анторполийн судалгаагаар хүн одоогоор Африкын Олдувайн хөндийг эртний хүмүүсийн агуйлах-агуулах гэж үзэж болно. Олдувайн хөндийд хүн төрөлхтөн 2,5 сая жилийн түүх агуулагдах 1936 оноос хойш судалгаа хийж, олон олон олдвор олджээ. Хомо хабис нь байгалийн олон

Дээрх алдаанууд буюу суралцагчдын хамгийн их алдаж буй зөв бичих дүрмийн алдааг түүвэрлэн авч, графикаар илэрхийлэхдээ улирлын эхэнд буюу хичээл эхлэхэд 1-2 удаа хянаж, ажиглаад, алдаж буй үгсийн дүрмийг дахин тайлбарлаж, дасгал ажиллуулан бататгав.

Хүснэгт 1. Улирлын эхэнд суралцагчдын хамгийн олон алдаж байсан дүрмүүд

Алдаж буй зөв бичих дүрэм	Ажиглалтад хамрагдсан суралцагчдын тоо	Алдсан алдааны тоо	Алдааг хувиар илэрхийлбэл:
Гээгдэх эгшиг (Г+урт эгшиг)	30	30	100.0
Нэршүүлэх “-х”	30	28	93.3
Үйл үг үүсгэх “-л”	30	27	90.0
Гээгдэх эгшиг (3+3 - эгшиг)	30	24	80.0
Ялгах эгшиг	30	23	76.7
Цэг цэглэлийн алдаа	30	22	73.3
Тогтворгүй “-н”	30	21	70.0
Дараалсан 2 ба 3 гийгүүлэгч	30	20	66.7
Уламжлалын зарчмаар бичсэн үг	30	19	63.3
Тийн ялгалын нөхцөл (“+ийг, -ыг”)	30	13	43.3
Тийн ялгалын нөхцөл (“-ийн”)	30	11	36.7
Тусгаарлагч ъ,ь тэмдэг	30	9	30.0
Я-гийн төрлийн урт эгшиг	30	9	30.0

График 1. Улирлын эхэнд суралцагчдын хамгийн олон алдаж байсан дүрмүүд






Багш судалгаанд анализ хийж, цаашдын ажлыг төлөвлөхдөө дээрх үр дүн, задаргааг ажиглаж, дүгнэлт хийх бөгөөд ажиглалт тус бүрийн үр дүнг тооцож, суралцагч бүр дээр ахицыг тэмдэглэж байлаа. Алдаагүй бичиж ахиц гарч байгаа учраас суралцагчид цаашид суралцах хүсэлтэй, ялах, мэдлэг эзэмших, бусадтай хамтран ажиллах зэрэг хүсэл эрмэлзэл, идэвхтэй байдалтай байгаа нь харагдаж байв.

Цаашид суралцагчдад дүрмийг ойлгуулах төрөл бүрийн ажил, тухайлбал, эсээ бичүүлэх, АХА тэмцээн зохиох, тоглоом тоглуулах, багаар ажиллуулах, илтгэл, мэдээ мэдээлэл хийлгэх гэх мэтийг зохион байгуулж, улирлын туршид ажилласны дараа улирлын төгсгөлд ажиглалтад оролцож буй суралцагчдыг дахин эсээ бичүүлж, сорил ажиллуулан (улирлын эхэнд авсан агуулгын дагуу) ажиглалт хийж үзэв. Үүнд:

Хүснэгт 2. Улирлын төгсгөлд суралцагчдын хамгийн олон алдаж байсан дүрмүүд

Алдаж буй зөв бичих дүрэм	Ажиглалтад хамрагдсан суралцагчдын тоо	Алдсан алдааны тоо	Алдааг хувиар илэрхийлбэл:
Гээгдэх эгшиг (Г+урт эгшиг)	30	27	90.0
Нэршүүлэх “-х”	30	19	63.3
Үйл үг үүсгэх “-л”	30	18	60.0
Гээгдэх эгшиг (З+З - эгшиг)	30	18	60.0
Ялгах эгшиг	30	19	63.3
Цэг цэглэлийн алдаа	30	15	50.0
Тогтворгүй “-н”	30	15	50.0
Дараалсан 2 ба 3 гийгүүлэгч	30	18	60.0
Уламжлалын зарчмаар бичсэн үг	30	11	36.7
Тийн ялгалын нөхцөл (“+ийг, -ыг”)	30	9	30.0
Тийн ялгалын нөхцөл (“-ийн”)	30	6	20.0
Тусгаарлагч ъ,ь тэмдэг	30	5	16.7
Я-гийн төрлийн урт эгшиг	30	5	16.7

График 2. Улирлын төгсгөлд суралцагчдын гаргаж буй алдаа



СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Ажиглалтын эцсийн үр дүнд хоёр судалгааг харьцуулан, суралцагчдын ахицыг гаргалаа. Үүнд дээрээ тулгуурлан цаашид ямар дүрмийг яаж заах, ойлгуулах, юун дээр анхаарах талаар өөрийн төлөвлөгөөг боловсруулна.

Хүснэгт 2. Ажиглалтын үр дүнгийн харьцуулалт

Зөв бичих дүрэм	I анализ	II анализ	Алдаа буурсан хувь
Гээгдэх эгшиг (Г+урт эгшиг)	100.0	90.0	10.0
Нэршүүлэх “-х”	93.3	63.3	30.0
Үйл үг үүсгэх “-л”	90.0	60.0	30.0
Гээгдэх эгшиг (3+3 - эгшиг)	80.0	60.0	20.0
Ялгах эгшиг	76.7	63.3	13.4
Цэг цэглэлийн алдаа	73.3	50.0	23.3
Тогтворгүй “-н”	70.0	50.0	20.0
Дараалсан 2 ба 3 гийгүүлэгч	66.7	60.0	6.7
Уламжлалын зарчмаар бичсэн үг	63.3	36.7	26.6
Тийн ялгалын нөхцөл (“+ийг, -ыг”)	43.3	30.0	13.3
Тийн ялгалын нөхцөл (“-ийн”)	36.7	20.0	16.7
Тусгаарлагч 'ь,ь' тэмдэг	30.0	16.7	13.3
Я-гийн төрлийн урт эгшиг	30.0	16.7	13.3

График 3. Улирлын эцэст суралцагчдын гаргаж буй алдаа буурсан хувь



Анх суралцагчид дээрх дүрмүүд дээр хамгийн их алдаж байсан бол, улирлын эцэст дүрмээ ойлгож, эргэлзээтэй бичигддэг зарим үгсийг нүдлэх хандлага ихсэж, өмнө алдаж байсан үгээ 50-100% хүртэл алдаагүй бичиж чаддаг болов. Ялангуяа дараах дүрмүүдийг ойлгож бичихэд ихээхэн ахиц гарчээ. Үүнд:

- “Нэршүүлэх “-х” дагавар (идэвх, чадавх, дараахх...)”)
- Үйл үгийн “-л” (сурвалжилга, сурталчилгаа...)”)
- Заримдаг гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгчээр төгссөн залгавар залгахад эгшиг жийрэглэнэ. Нэгэнт гээсэн эгшгийг шаардлагагүй бол дахин сэргээхгүй. (бусдадаа, нөхдөд, ажилчдад)
- Ялгах эгшгийн дүрэм (унаганы, танилыг, үнэрээр...)”)
- Тусгаарлагч “-я,-е, -ё” үгсийг зөв бичих дүрэм (хүргэе, өгье, танилцъя...)”)
- Уламжлалын зарчмаар бичдэг (галавын, төлөвийн, тэнхимийн...)”)

Ажиглалтын эхний болон эцсийн үр дүнг харьцуулбал, дээр дурдсан дүрмүүдийг алдах алдаа 20-30%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Суралцагчдад энэхүү судалгаанд оролцох нь сонирхолтой байсан бөгөөд багш эргэлзээтэй үгсийг нүдлүүлэх сорил тест ажиллуулах, тоглоом зохиож тоглосны дараа үгийг нүдлэх хандлага ажиглагдаж байв. Тоглоомын эцэст багш, дүрмийг тайлбарлаж өгөх замаар 2-3 удаа давтсаны дараа энэ үр дүнд хүрсэн.



ДҮГНЭЛТ

Дээрх судалгаанаас харахад, суралцагчид:

- Зөв бичих дүрмийг дутуу ойлгох;
- Бичгийн хэлний хэм хэмжээг сахихгүй, хайнга хандах;
- Цахим орчинд хэтэрхий орж, латин үсгээр чат бичих;
- Гадаад үгийг их хэрэглэх;
- Ном сурах бичиг уншихгүй байх зэрэг шалтгааны улмаас алдаатай бичих үзэгдэл түгээмэл болжээ.

Үүнийг засаж, бичгийн хэлний хэм хэмжээг сахиулах, төрөлх монгол хэлээрээ зөв бичдэг болгохын тулд багш сурган хүмүүжүүлэгчид хамтран ажиллаж, анхаарлаа хандуулах цаг болсон байна. Ийм учраас дээрх судалгааны үр дүнг танилцуулсан бөгөөд бид эх хэлээ хайрлах, хамгаалах ажлын нэг хэсэг суралцагчдыг зөв бичүүлж, эх хэлээ зөв хэрэглэх дадал төлөвшүүлэхэд оршино.

НОМ ЗҮЙ

1. Монгол хэлний тухай хууль (2015)., Уб
2. Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь (2018)., Уб., 4 дэх тал
3. Teaching English with Technology (2017), 16 (3), page 17-36
4. Их сургуулийн сургалтад идэвхтэй сургалтын аргуудыг хэрэглэх нь., (2018)

Цахим эх сурвалж:

5. <https://www.vcsu.edu/cmsfiles/433/373bd6a842.pdf>
6. <http://staffmotivationmatters.co.uk/pink>
7. <http://www.fewtjournal.org>34



ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН ТОДОРХОЙ СЭДВИЙГ ЗААХДАА ЭКО-ХЭЛ ШИНЖЛЭЛИЙН ЗАРИМ ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ТУСГАХ НЬ

Магистр Р. Түмэндэмбэрэл

(ШУТИС, ГХС)

tumee@yahoo.com

SUMMARY

Some scholars answered that “It includes the image culture of thinking and talking, the upbringing of linguistics’ specialist feeling, protecting and normalizing written language, to define the way of enriching and improving correctly, and speaking aesthetics”.

The special things of any nation such as language and culture, custom, religion are ignored and sometimes they are posing a threat to them. In this situation, (today) we should pay more attention on language ecology. If any country wants to protect and develop its culture they should pay more attention on their mother language, and acquire, study, and promote the oral and written language heritage, the encyclopedia of the nation’s thinking, and inherits them to the next generation. It is straightly related to the independence of the nation. Also the language ecology is the basic root of the cultural ecology.

ТҮЛХҮҮР ҮГ

Монгол хэний дархлаа, *хэлний экологи*, хэрэглээний хэл шинжлэл

УДИРТГАЛ

Хүн төрөлхтний түүхэн дэх дэлхийн соёлын гайхамшигт зүйлийн нэг нь үндэстний хэл юм. Аливаа үндэстний эх хэл нь тухайн түүх соёл, мэдлэг боловсролын үндэс, орчлон ертөнцийг танин мэдэх хамгийн чухал хэрэгсэл, үндэстэн ястан оршин байхын гол тулгуур багана болдог билээ. Өөрөөр хэлбэл, дэлхийн соёлын салшгүй хэсэг, үндэсний сэтгэлгээний бэлгэ тэмдэг, монголчуудын оюуны өндөр чадамжийн илэрхийлэл юм.

Даяаршиж буй өнөөгийн нийгэмд хүн төрөлхтний нийтлэг шинжүүд эвлэлдэн

нэгдэж, улс үндэстэн бүрийн өвөрмөц шинж дархлаажих үйл явц мэдэгдэж байна. Иймд өдгөө улс үндэстэн бүр өөрийн түүх соёл, өв уламжлал, үндэсний онцлог, ёс заншлаа хадгалж үлдэхийн тулд эх хэлээ хамгаалах, авч үлдэх нь чухал.

Иймд нэг талаас үндэсний хэлнийхээ экологийг хадгалах тухай асуудал, нөгөө талаас хилийн чанадад амьдарч буй монгол хүүхдүүдэд монгол хэлийг хоёрдогч хэл болгон заах тухай асуудал нь эн зэрэгцсэн чухал асуудал болж байна.

Энэ талаар проф Ш.Чоймаа “Эх хэл бол сэтгэхүйн зэвсэг, гадаад хэл гэдэг нь тухайн хүн өөрөө мэдлэг боловсролоо тэлж, илүү мэдээлэл олж авдаг хэрэгсэл юм” гэсэн байна. Энэ нь хүн эх хэлээ хэдий чинээ сайн эзэмшинэ гадаад хэлийг төдий чинээ сайн судалж, ухаж ойлгоно гэсэн үг юм.

Дээрх шалтгаануудын улмаас эко-хэлшинжлэлийн тухай асуудал нь бидний зайлшгүй судлах, хэрэгжүүлэх чухал асуудлын нэг юм.




График 1. Хэлний экологи

ҮНДСЭН ХЭСЭГ

Эко-хэлшинжлэл нь 1990-ээд оноос эхлэн үүссэн хэлшинжлэлийн судалгааны шинэ урсгал чиглэлийн нэг бөгөөд зөвхөн хэлний хам утга бус экологи, нийгмийн хам сэдэвт бичвэрийг судалдаг ажээ.

Энэ нь дотроо хоёр салбар болон хуваагддаг. Үүнд:

1. Эко шүүмжлэлт бичвэрт задлал хийх

1990 онд Английн хэл шинжүүч Майкл Халлидей (Michael Halliday) “New ways of meaning: The challenge to applied linguistics”- Утгын шинэ замууд: Хэрэглээний хэл шинжлэлийн өрсөлдөөн” илтгэлээ XXI зууны хэл шинжлэлтэй холбогдолтой асуудал, ялангуяа орчин үед түгээмэл болсон экосистемийн сүйрлийн тухай



асуудлыг дэвшүүлэн тавьснаар үндэслэжээ.

Энэ нь байгаль орчин болон байгаль орчныг хамгаалах тухай ямар ч төрлийн эх бичвэрт анализ хийх бөгөөд хязгаарлагдмал бус, янз бүрийн үзэл санаануудыг гаргаж, таамаглал дэвшүүлнэ. Бүрэн хэлбэртэй байх үедээ экосистемийн ирээдүйд гарч байгаа үр дагаврын тухай ямар нэгэн бичвэр, тухайлбал, эдийн засаг, хэрэглээний бүтэц, хүйсийн тэнцвэртэй байдал, улс төр, хөдөө аж ахуй, байгаль орчин зэрэг бичвэрүүдийг өөртөө багтаадаг. Ингэхдээ дээрх бичвэрүүд дээр гол анхаарлаа хандуулах бус, голчлон экологийн хувьд илүү тогтвортой нийгэмд хувь нэмрээ оруулахад судалгаагаа чиглүүлдэг байна.

2. Хэлний экологи

“Экология” хэмээх үг нь грек гаралтай бөгөөд “oikos”-орон байр, орших газар, “logos”- судлал, сургаал гэсэн нийлмэл үг юм. “Оршихуйн судлал” хэмээсэн утгатай “экологи” гэсэн нэр томъёог анх германы биологич Эрнст Геккель 1866 онд хэрэглэсэн түүхтэй аж.

Америкийн хэл шинжээч, проф. Einar Haugen (Эйнер Хауген) “*The Ecology of Language*” бүтээлээрээ үндэслэсэн¹ ажээ.

Энэ нь дэлхий дээр яригдаж буй хэлнүүдийн харилцан хамаарлыг тодорхойлоход экосистемийн хэлцийг ашиглаж буй хэл шинжлэлийн салбар ухаан юм. Төрөл бүрийн хэлний хэлбэрүүдийг агуулсан хэлний экологи нь эрүүл экосистемийн гол үндэс болох бөгөөд төрөл бүрийн хэл дэх хэлний экологийн мэдлэгийг бий болгох үндэс суурь нь болж өгдөг.

Эндээс үзвэл, эко-хэлшинжлэл нь тухайн нийгмийн тулгамдсан асуудлуудад хэл, хэлшинжлэлийн оролцох үүргийг тодорхойлно гэсэн үг бөгөөд дэлхий нийтээр даяаршиж буй өнөөгийн нийгэмд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын тухай асуудал, ялангуяа экосистемийн сүйрэл нь анхаарал татахуйц чухал байр эзэлж байгаа учраас хэл, хэл шинжээчдийн судалгааны чухал хэсэг болоод байна.

Эндээс, “**Эко-хэлшинжлэл гэдэг нь** хүрээлэн буй орчны асуудлыг шийдвэрлэхэд хэл, хэлшинжлэлийн шинжлэх ухааны гүйцэтгэх үүрэг, эзлэх байрыг тодорхойлдог хэрэглээний хэл шинжлэлийн салбар ухааныг хэлнэ.” хэмээн тодорхойлж болно.

Тэгвэл бид дээрх үзэл баримтлалыг хичээл заахдаа хэрхэн тусгах вэ? Жишээ авч үзье.

Сэдэв: Эко-хэлшинжлэлийн үзэл баримтлалыг англи хэлний хичээлд тусган хэрэгжүүлэх арга зүй “Seasonal duties in Nomadic Culture” сэдвийг сонгон авч,

¹ Бигэрмаа, Р (2010), *Эко хэл шинжлэл, тогтвортой хөгжихүйц англи хэлний боловсрол*. УБ. 2010

тус хичээлийн агуулгыг ашиглан, хичээл заахдаа дараах үзэл баримтлалыг хэрэгжүүлнэ. Тухайлбал:

Хэрэгцээ:

1. Дэлхий нийтээр даяаршиж буй орчин үед үндэсний уламжлал, соёл, зан заншил, тэдгээрийн онцлогийг судлах, хичээлийн агуулгаар мэдлэг олгох;
2. Эх хэлний экологийг хадгалах зорилгоор монголчуудын амьдралын онцлогийг эх хэлээрээ хадгалж үлдэхийн тулд ярилцах, хэрэглэх чадвартай болгоно.

Зорилго:

1. Жирийн одоо цаг, түүний хэрэглээ (Present simple tense and usage)
2. Монголчуудын улирлын ажил эрхлэлтийн онцлог (Nomadic lifestyle)
3. Хэлний экологи буюу (Eco-linguistics)

Зорилт:

1. Мэдэхүйн цогц чадамж (Competence learning to know)
 - Жирийн одоо цаг (Present simple tense)
 - Хэрэглээ (Usage)
 - Монголчуудын амьдралын хэв маяг (Nomadic lifestyle)
 - Улирлын чанартай ажил хөдөлмөрийн онцлог (Seasonal duties of Mongolian nomads)
 - “Present simple tense”-ийг хэрэглэж чаддаг болох
 - Нүүдэлчин монголчуудын амьдралын хэвшил, онцлогийг өөрсдийн амьдралд хэрэгжүүлэх
 - Өгөгдсөн өгүүлбэрээс дексизийн анализ хийж чаддаг болох
 - Нүүдэлчдийн зан заншил яагаад устаж үгүй болж мэдэхээр байгаа шалтгааныг олж, анализ хийж сурах
 - Байгаль орчин, цаг агаарын өөрчлөлтийг хүмүүсийн амьдралд хэрхэн нөлөөлдгийг мэдэж тооцоолох

Оршин байхуйн цогц чадамж (Competence learning to be)

- Нүүдэлчин монголчуудын зан заншил, монгол уламжлалыг хамгаалах ажилд өөрийн хувь нэмрийг оруулах
- Хүмүүсийн үйл ажиллагаа байгальд эерэг ба сөрөг ямар нөлөө үзүүлж байгааг ажиглан, сөрөг үйл ажиллагааг зогсоох арга хэмжээнд оролцох
- Эрүүл аж төрөх, хэлний экологийг хамгаалах орчин бүрдүүлэхэд анхаарч,



хамт олноороо асуудлыг шийдвэрлэдэг чадвартай болох

- Хичээлээр олж авсан мэдлэгээ амьдралд хэрэгжүүлж чаддаг болох

Хамтдаа нийгэмшин амьдрахуйн цогц чадамж (Competence learning to socially live together)

- Монголчуудын амьдралын хэвшил, зан заншил, соёл ахуйн тухай өөрсдийн санаа бодлыг илэрхийлж, бусадтай хуваалцаж сурах
- Энэхүү зан заншил, байгалиа нөхөн сэргээх талаар бусдад ойлгуулах, хамтын үйл ажиллагаанд оруулах
- Санаа бодлоо харилцан хэлэлцэж, шийдвэрлүүлж сурах зэрэг болно.

Арга зүйн хувьд:

- Харилцан ярилцаж сурагчдыг сэдэлжүүлэн “Present simple tense” шинэ хичээлийн агуулгыг гаргах
- “Present simple tense” –ийг хэрэглэж, эзэмших үйл ажиллагааг удирдан чиглүүлэх
- Монголчуудын амьдралын хэв маягийн талаар өмнө нь ямар байсан, одоо ямар байгаа, цаашид ямар арга зам байгааг асуудал дэвшүүлэн ярилцах
- Дүрмийг ойлгохгүй байгаа оюутнуудад тайлбарлан ярих
- Монголчуудын улирлын ажил үүргийн талаар харилцан ярилцах
- Байгаль орчин, эдийн засаг, нийгмийн ач холбогдлын талаар ярилцах
- Сурах бичгээс уншиж ярилцах
- Зааварчилгаа өгч, үнэлж дүгнэх
- “Present simple tense” онцлог, ач холбогдлын талаар мэдлэг, мэдээлэлтэй танилцаж, тэмдэглэл хийх
- Хэрэглээний талаар ярилцах, мэдээлэл солилцох, санал бодлоо илэрхийлэх, дасгал ажиллах
- Монголчуудын амьдралд жилийн дөрвөн улирал, байгаль ямар нөлөө үзүүлдэг, ач тусын талаар харилцан ярилцаж, санал бодлоо солилцох
- Өөрийн болон бусдын санал бодолд үнэлэлт дүгнэлт өгөх
- Шинэ мэдлэгээ бататгах зорилготой дасгал, даалгавруудыг гүйцэтгэх ажлыг багш удирдан чиглүүлж, тухайн хичээлийн агуулгаар эко хэл шинжлэлийн үндсэн ойлголтуудыг төлөвшүүлэх зорилго тавина.

Үнэлгээ:

K1: Жирийн одоо цагийг ойлгосон эсэхийг төрөл бүрийн дасгал,

даалгавар ажиллуулж үнэлэх

К2: Монголчуудын үндэсний уламжлал, амьдралын хэв маяг хаягдаж гээгдэхийн хор холбогдлыг эхийн агуулгыг уншуулж, дүрмийг тайлбарлуулж, үнэлэх

К3: “Seasonal duties of Mongolian nomads” сэдвээр хэлэлцүүлэг, харьцуулалт хийлгэж үнэлэх

К4: Өөрсдийн хийж байгаа зүйлд анализ хийлгэж, диаграм зохиолгож үнэлнэ.

ДҮГНЭЛТ

Эндээс бид, тогтвортой хөгжлийн үзэл санаа, нөгөө талаас, эко хэл шинжлэлийн үндсэн агуулгыг хоёрдогч хэл заахад нэвтрүүлэхдээ дараах арга замаар олгоно. Үүнд:

1. Эхийг сонгож авахдаа, агуулгаар дамжуулан олгоно. Тухайлбал:
 - Эхийн агуулгад байгаль орчныг хамгаалах болон тогтвортой хөгжлийн үзэл санаа туссан эсэх
 - Хүний үнэ цэнийн тухай ойлголт туссан эсэх
 - Сонирхолтой болж чадсан эсэх
 - Ойлгомжтой тодорхой болж чадсан эсэх (Уншигчдын 70-аас дээш хувь нь ямар нэг нэмэлт тайлбаргүйгээр шууд хүлээн авч ойлгодог эсэх. Тийм шаардлагыг бүрэн хангаж чадах аваас түүнийг ярилцан тал талаас шүүмжлэн хэлэлцэхэд хүн бүр оролцох боломжтой болно)
 - Хэлний хэрэглүүрийн задлал хийх бүрэн боломжтой, сайн жишээ болохуйц болж чадсан эсэх
 - Асуудал дэвшүүлж, шийдэл гаргуулж чаддаг байх эсэх зэргийг харгалзана.
2. Арга зүйгээр дамжуулан олгоно.
3. Хамтын үйлээр дамжуулан олгоно.
4. Маргаан мэтгэлцээн, шүүн хэлэлцэх үйл явцаар дамжуулан олгох боломжтой юм.



НОМ ЗҮЙ

1. Ammaria Derni. (2008). The Ecolinguistics paradigm issue
2. Бигэрмаа.Р. (2010). Эко хэл шинжлэл-тогтвортой хөгжихүйц англи хэлний боловсрол. УБ
3. Bang.J. (2000)., Ecolinguistics Framework conference of Linguistics., Stockholm
4. www.ecolinguistics.com
5. www.en.wikipedia.org/wiki/ecolinguistics
6. Равдан.Э. (2009). Хэл шинжлэлийн утга зүй., УБ
7. Равдан.Э. (2006). Орчин цагийн хэл шинжлэл., УБ
8. Чоймаа.Ш. (2009). Хэлний экологи.,МУИС.,МХСС.,ЭШБ.,УБ. 126-р тал



МОНГОЛ АРДЫН АМАН ЗОХИОЛ ХЭЛНИЙ ДАРХЛААГ ХАМГААЛАХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БОЛОХ НЬ

(Морины тухайт үг хэллэгийн жишээгээр)

Магистр Ц. Цэвэлмаа

ШУТИС, ГХС

tsevelmaa@yahoo.com

ABSTRACT

Depending on the economy, natural conditions, and environmental conditions of a nation, language, culture, and customs are inextricably linked. For Mongolians, who have a nomadic civilization, the harsh climate and the four seasons of the year depend on the characteristics of their life, which includes herding and migrating cattle.

For this reason, it is important for anyone learning a language as a second language to be familiar with the customs, history, and culture of that people, how their attitudes and worldviews are expressed in their native language, and how they are called, as well as the words and terms that are characteristic of the nation.

Therefore, in this article, we have selected and drawn conclusions from Mongolian folklore in order to clarify the effectiveness of Mongolian folklore in improving language immunity.

ТҮЛХҮҮР ҮГ: Монголчуудын сэтгэлгээний онцлог,

УДИРТГАЛ

Аливаа нийгмийн оршин тогтнох гол үндэс нь хэл бөгөөд дан ганц харилцааны хэрэглүүр төдий бус тухайн улс үндэстэн, ард түмний өв уламжлал, түүх соёлын салшгүй нэгэн үнэт зүйл, тусгаар тогтнолын баталгаа юм. Шинжлэх ухаан технологийн өндөр хөгжил, даяаршлын эрин үед амьдарч буй монголчууд бидний хувьд ч эх хэлээ хадгалах, хөгжүүлэх, хайрлан хамгаалж хойч үедээ уламжлан үлдээх нь чухал бөгөөд даяаршлын эл нийгэмд хэлний дархлаа гэж юу вэ, түүнд юу нөлөөлөх вэ зэрэг асуудал чухал билээ.

Ямар нэг улс үндэстний эрхэлж буй аж ахуй, байгалийн байдал, орчин нөхцөл зэргээс шалтгаалан, хэл, соёл, зан заншил салшгүй холбоотой байдаг



билээ. Нүүдлийн соёл иргэншилтэй монголчуудын хувьд эрс тэс уур амьсгалтай, жилийн дөрвөн улиралд таван хошуу малаа маллан, нүүдэллэж ирсэн амьдралын онцлогоос шалтгаалдаг. Ийм учраас аливаа хэлийг хоёрдогч хэл болгон суралцагч хүн тухайн ард түмний зан заншил, түүх соёл, тухайн ард түмнийх аливаад хандах хандлага, ертөнцийг үзэх үзэл эх хэлээрээ хэрхэн нэрлэгдэж буй, үндэстний онцлог бүхий үг хэллэг, нэр томьёог сайтар мэддэг байх нь чухал юм. Иймд бид энэхүү өгүүлэлдээ хэлний дархлааг сайжруулахад монгол ардын аман зохиолын үр нөлөөг тодруулахын тулд морины тухайт үг хэллэгийг түүвэрлэн авч, дүгнэлт хийхийг хичээлээ.

ҮНДСЭН ХЭСЭГ

Монгол ардын аман зохиолын нэг хэсэг болсон зүйр цэцэн үгс нь тухайн ард түмний оюун санааны чадамж, сэтгэлгээний онцлогийг илэрхийлэхийн зэрэгцээ ахуй амьдралын үндэсний онцлог шинж илрэн гардаг байна.

Монголын ард түмний оюуны соёлын нандин өв болох ардын аман зохиолын баялаг сан эртний уламжлалтай бөгөөд монголчуудын нүүдлийн соёл иргэншлийн үнэт зүйлсийг сонгодог хэлбэрээр нь бүтээж байдаг. Ардын аман зохиол нь бидний үе хүртэл үеэс үед уламжлан хөгжиж ирэхдээ ард түмний амьдралын хэв маяг, нүүдлийн соёлын өвөрмөц онцлог, ёс заншил, сэтгэлгээ, иргэншлийн онцлогийг хадгалж, бусад улсын соёлоос ялгарах гол шинж¹ нь болж иржээ. Үүний нэг жишээ бол ардын аман зохиол дахь морины тухайт үг хэллэгийн сан юм.

Зүйр цэцэн үгс нь тэр хэлээр хэлэлцэгч ард түмний үндэсний онцлог, эрхэлж буй аж ахуй, байгаль орчин, амьдралын хэв маягтай нягт холбоотой учир өөр улс үндэстнүүд шууд ухан ойлгоход бэрх байдаг.

Судлаач Г.Эрдэнэтогтох “Монгол ардын цэцэн үгийн үүсэл хөгжлийн замын эхийг монгол ардын аман зохиол хэдийд үүссэн бол, зүйр цэцэн үг мөн төдийд үүссэн гэж тоймлон үзэж болно.” хэмээсэн байдаг. Мөн судлаач Ж.Дашдорж, Г.Ринчэнсамбуу нар “Монгол ардын цэцэн үг бусад орны ардын аман зохиолын адил ажил үйлдвэрлэлийн туршлагатай нягт холбоотойн дээр хүмүүс бодол сэтгэгдэл, ажиглалт дүгнэлтээ ихэд задруулан өгүүлж хараахан чадахгүй, эн тэргүүнээ гарын ойрхи буюу аль сайн мэдэх эд юмсаар адилтган илэрхийлж байсан эрт дээр үед үүсчээ.”² гэж зүйр үгийн үүсэл гарлын талаар өгүүлсэн байна.

¹ Бигэрмаа. Р. (2022) *Монгол, япон хэлний зүйр цэцэн үгийн харьцуулсан судалгаа*. УБ

² Отгонжаргал.О. (2015). *Зүйр цэцэн үгийг соёлын үүднээс тайлбарлах нь*. УБ

Монгол ардын аман зохиолд онч мэргэн үгс, зүйр цэцэн үг, оньсого, таавар, цэцэн үгс гэх мэт баялаг сан бий. Эдгээр нь монгол хүний гүн ухаан, уран санаа, сэтгэхүйн онцлогийг гүн гүнзгий илэрхийлсэн, монгол ахуй, амьдралын гүнээс эхтэй учраас нийтэд ойлгомжтой, амьдралын жам ёсонг гүн гүнзгий танин мэдэхэд зохицсон, түүнийхээ хэрээр үндэсний оюун санааг баяжуулдаг уран сайхан, гүн ухааны үлэмж ач холбогдолтой төрлүүд юм. Тэрчлэн аман зохиолын нэгэн төрөл болох ерөөл, магтаал, цол нь нүүдэлчин ард түмний аж төрөх ёс, зан үйл, сэтгэлгээ, эдлэл хэрэглэлийн онцлогийг тусган өгүүлдэг. Ерөөл магтаалд туссан хэл сэтгэхүйн онцлог нь тухайн цаг үеийн нийгмийн байдал, түүхийн онцлог, зан заншил, өв соёл, эдлэл хэрэглэлийг судлах судлагдахуун болох юм.

Хувь хүмүүсээс амьдралыг үзэх үзэл, түүнд хандах хандлага, хүн болон байгаль, нийгмийн мөнхийн холбоо, түүний жам ёсыг гүн ухааны үүднээс уран сайхны аргаар нээн илэрхийлсэн, хүмүүсийн өдөр тутмын амьдрал ахуйд түгээмэл тохиолддог үзэгдлийг гүн ухааны үүднээс тунгааж илэрхийлсэн хоёр ба түүнээс дээш холбоо үг, өгүүлбэр, хэлц хэллэгийн түвшинд илэрхийлсэн гүн утга, уран санаа, өргөн агуулга бүхий хураангуй цогц уран хэллэгийг зүйр цэцэн үг гэнэ. Жишээлбэл: Монгол ардын аман зохиолын дээрх төрлүүдэд адууны тухай өгүүлсэн бүхэл бүтэн үг хэллэгийн сан бий. Монголчууд адууны тухай өгүүлсэн зүйр цэцэн үг, оньсого таавар, ерөөл, магтаал, цол элбэгтэй ард түмэн юм. Үүнд:

1. Монголчуудын морины тухайт үг хэллэгийн дотор зүйр цэцэн үг элбэг байдаг. Эдгээр нь морины зүсэм, гүйдэл явдал, зан араншин, түүний эдлэх эдлэл хэрэгсэлтэй холбогдох нь олонтаа. Жишээлбэл: **Бусдыг сурган хүмүүжүүлэх агуулга бүхий зүйр цэцэн үгэнд:**

Хол аян хөөвөл морины сайныг мэднэ

Хоног өдөр одвол хүний чанарыг мэднэ

Холын замд морины сайныг мэднэ

Хоногийн удаанд нөхрийн сайныг танина

Аавын бийд хүнтэй танилц

Агтын бийд газар үз

Ааваа байхад хүн тань

Агтаа байхад газар тань³

Ороо морь жороо шинжтэй, отгон хүүхэн ноён шинжтэй

Ороо морийг уургаар, ууртай хүнийг аргаар⁴

³ Ванчиг.Б (2014) “Зураг урлагт тууль: Адуун соёл”. ӨМ-ын ардын хэвлэлийн хороо, Хөх хот. 18

⁴ Ванчиг. Б (2014) “Зураг урлагт тууль: Адуун соёл”. ӨМ-ын ардын хэвлэлийн хороо, Хөх хот.18



Адууны алаг сайхан

Аяганы алаг муухай гэх мэтээр морины тухай зүйрлэн цэцэлдэг. Учир утгыг зүйрлэхдээ адууны ерөнхий шинж, зан араншин, явдал гүйдэл, эдлэл хэрэгслээс сэдэвлэдэг тул амархан цээжлэгдэн, аман яриа болдог байна.

Монголчууд адууг сайн мэдэхийн хувьд аливаа зүйлтэй нь адилтган зүйрлэхгүйгээр шууд морины ерөнхий байдлаас сэдэвлэн цэцлэхэд, түүний цаад утгаас энэ үгийн агуулга юунд чиглэгдсэн гэдэг нь харагдана. Үүнийг ганц монгол хүн, малчин хүн л ойлгоно. Жишээ нь:

“Ороо нь ороогоороо, жороо нь жороогоороо” гэдгээс ороо морь ороотойгоо ижилдэж, жороо морь жороотойгоо гишгэгдэл нэгдэнэ гэсэн утга агуулагдана. Далд утга нь сайн хүн сайн хүнтэйгээ, муу хүн муу хүнтэйгээ гэсэн утга бий.

Харин “Хээр алгаас шийр алаг, хэлтэн гүүнээс шувтан унага” гэдэг нь адууны удамшлаас сэдэвлэж, муу гүүнээс муу унага төллөх гэсэн утгатай болно. Далд утга нь эцэг эх ямар бол хүүхэд нь тийм гэсэн утга байгаа юм. Энэ мэтийн далд утгатай цэцэн үгээс бид гүн ухааны сургаал харж болдог. Жишээ нь:

Яравч явган бүү суу

Ядравч бүү ташуураа тул гэдэгт морийг яриагүй ч “Мориноосоо битгий сал” гэсэн утгыг цэцэлсэн байдаг.

2. Ардын аман зохиолын түгээмэл хэлбэрийн нэг бол оньсого таавар бөгөөд энэ төрөл зүйлд морин соёлын агуулга бүрэн агуулагдаж, сонин содон сэтгэхүй, уран гойд хэллэгээрээ монгол оньсогын урын санг баяжуулж байдаг.

Морины тухай үг хэллэгийн санг баяжуулж буй оньсогуудыг ажиглахад, үндсэн хоёр онцлогтой байна. Энэ нь морины тухай сэдвээр оньсголсон нэг онцлог байхад, нөгөө нь уран яруу хэллэгээр морины гадаад дотоод шинж чанарыг далдлан өгүүлсэн бас нэгэн онцлог ажиглагдаж байна. Иймд *морины сэдэвт оньсогыг үндсэн хоёр зүйлд ангилж болно.*

а. Морины сэдэвт оньсого

Энэ хэсэгт аливаа зүйлийг оньсголохдоо морины тухай сэдвийг сонгон авч, аливаа зүйлийг оньсголсон байдаг.

Хар моринд хазаар ч үгүй, тохом ч үгүй /ус урсах/

Хар морь ногоон ногттой /монгол гутал/

Хар морь хантраатай, халиун булга бөгтрөөтэй /нүд/

Урт хар морийг уургаар барьж болохгүй /гол/

Ирмэгт харагч гүүгээс эр хар унага гарна

Үүнийг сургасан хүн эргүү мунхаг болно /архи/

Ойд байгаа мод огторгуйд байгаа од

Эргэл бугын эвэр, эр морины шандас /нум сум/

Хээ цагаан морь хивс цагаан тохомтой /гэр/

б. Моринд холбогдох оньсого

Уран сайхан үг, урсам сайхан хэллэгээр далд агуулгыг биедээ агуулсан шүлгийн хэлбэртэй оньсогод морины тухай, морин соёлын тухай олон оньсого байдаг. Жишээлбэл:

Төр улсыг тогтооход түргэн зорчих хүрд

Түмэн газрыг гэтлэхэд төмөр сэлүүрт онгоц

Түвшин энхийн цагт хөлийг амраагч гутал

Төрөлх түүнээ цөсийг үзэх гэж дэлхийн хүмүүс шуугилдана /Морь/

Алс газрыг довтлогч гоо тогос /Морь/

Гэрт байдаггүй гарт байдаг /Уурга/

Атганд багтаад авдарт багтдаггүй /Уургалах/

Төмөр шат, модон даваа /Дөрөө/

Ооны хоёр эвэр, онгоцны хоёр хажуу

Найман сайхан шандас, шаны хоёр зоос /Эмээл/

Хээлсэн мод дөрвөн хэсэг

Хайнагийн шар найман хэсэг

Ган төмөр хоёр хэсэг /Эмээл/ гэх мэт.

3. Ардын аман зохиолд оньсого, таавраас гадна өвөрмөц онцлогтой тусгай төрөл зүйлийн нэг бол ертөнцийн гурав юм. Морины тухайт үг хэллэгийн санд энэхүү төрөл тодорхой байр эзэлнэ. Жишээлбэл:

Салхитай тэнгэрийн үүл хурдан

Саруул ухаантны санах хурдан

Сайн морины явдал хурдан

Эргээ хальсан ус догшин

Эмээлээ хөглүүлсэн морь догшин

Эрээ голсон эм догшин

Аманцар морь авын шившиг



Аальгүй авгай гэрийн шившиг

Муу нохой хотны шившиг

Эрхэм тэнэг морио магтана

Энгийн тэнэг эхнэрээ магтана

Эргүү тэнэг биеэ магтана

ДҮГНЭЛТ

Дээрх зүйлүүдээс дүгнэлт хийж үзвэл:

1. Ардын аман зохиолын төрлүүдэд морины тухайт үг хэллэгийн сан тодорхой байрыг эзэлдэг бөгөөд тус бүрд нь нарийн ажиглавал сонирхолтой дүгнэлт гарч болох юм.
2. Эдгээр нь өөр өөрийн онцлогийг тусгахын зэрэгцээ морины тухайт үг хэллэгийн бүхэл бүтэн санг үүсгэсэн байна.
3. Монгол хэлний дархлааг сайжруулахад, монголчуудын нүүдлийн соёл иргэншилтэй холбоотойгоор эрхэлдэг мал аж ахуй, түүнтэй холбоотой зан заншил, уламжлал чухал ач холбогдолтой болох нь харагдаж байна.

НОМ ЗҮЙ

1. Катуу.Б. (2008). “Хотогойд ардын аман зохиол”. УБ
2. Ванчиг.Б(2014). “Зураг урлагт тууль: Адуун соёл”. ӨМ-ын ардын хэвлэлийн хороо,Хөх хот
3. Жамбалдорж. С. (1996). Морин эрдэнэ.УБ
4. www.urlag.mn
5. [www.http//holboo suljee](http://holboo.suljee)
6. [www. https://mn.wikipedia.org/wiki](https://mn.wikipedia.org/wiki)

ГЭР БҮЛ, СЭТГЭЛ СУДЛАЛ

А.МӨНХЖИН

Эрэгтэйчүүдийн стрессийг хөдөлмөр эрхлэлтийн байдалтай нь
хамруулан судалсан нь

П.СҮНЖИДМАА

Сэтгэл хөдлөлийн оюун ухааныг хөгжүүлэхэд
сэтгэл заслыг ашигласан үр дүн



ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН СТРЕССИЙГ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛТАЙ НЬ ХАМААРУУЛАН СУДАЛСАН НЬ

Магистр А.Мөнхжин

(ОУУБИС. ХНУС)

munkhjin.a@ulaanbaatar.edu.mn

Түлхүүр үг: Эрэгтэй хүн, стресс, стрессор

Keyword: a man, stress, stressor,

Summary:

The difference between the average life expectancy of men and women in Mongolia is 9.7 years, and the average life expectancy of men in the capital is 8.2 years, which is a higher age difference. The reason for the high rate of death and suicide among men is that, according to traditional rituals, men take care of the house, because of their strong character, they do not pay attention to their health, work environment with difficult working conditions, as well as overcome their emotional and pessimism. problems such as poor expressive ability (psychological) are more affected (NCG, 2020)

According to the results of the survey conducted by the NSC, men between the ages of 25 and 44 make up 16% of the total population of Mongolia in the last three years, and they have a high percentage of the total number of employers. etc., they form the majority of the society. Therefore, keeping young men physically and psychologically healthy is important for keeping the mass of society healthy, so there is a need to study men's stress related to work and employment.

УДИРТГАЛ

Монгол Улсын эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүтэй байдалд хүн амын эрүүл мэндийн асуудал гол нөлөө болсон бөгөөд эрэгтэйчүүдийн нийт нас баралтын 83% нь өвчлөлөөс шалтгаалдаг бол үлдсэн 17% нь зам тээвэр, амиа хорлолт, үйлдвэрлэлийн осол зэргээс болдог гэжээ. Монгол улсын эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 9,7 жил, нийслэлд эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдтэй харьцуулахад 8,2 жил буюу насны зөрүү өндөр байна. Эрэгтэйчүүдийн нас баралт болон амиа хорлолт өндөр байгаагийн

шалтгаан нь уламжлалт зан үйлээр эрэгтэйчүүд гэр орноо авч явна, хүчтэй байна гэдэг шалтгаанаар нэрэлхүү зангаасаа болоод эрүүл мэнддээ анхаарахгүй, ажил, хөдөлмөрийн хүнд нөхцөлтэй ажиллах орчин, мөн сэтгэл санааны хүнд, гутранги байдлаа даван туулах болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвар муу (сэтгэл судлалын) зэрэг асуудал илүүтэйгээр нөлөөлж байгаа юм (ЖҮХ, 2020)

2020 оны байдлаар Монгол улсын нийт хүн амын тоог АНУ-ын хүн ам тооллогын товчоо 3'359'765 (ҮСХ, 2020) хэмээн тоолсон байна. ҮСХ-оос хийсэн судалгааны дүнг ажиглахад сүүлийн гурван жилийн дунджаар 25-44 насны эрэгтэйчүүд монгол улсын нийт хүн амын 16%-ийг эзэлж байгаа бөгөөд нийт ажил эрхлэгчдийн өндөр хувийг эзэлдэг мөн эдгээр насны эрэгтэйчүүд нийгмийн оролцоо, ажиллах боловсон хүчний эзлэх жин, гэр бүл зохиох гэх мэт үзүүлэлтүүдээр дээгүүрт жагсдаг болохынхоо хувьд нийгмийн олонх хэсгийг бүрдүүлдэг. Иймд залуу идэр насны эрэгтэйчүүдийг бие махбод, сэтгэл зүйн хувьд эрүүл байлгах нь нийгмийн массыг эрүүл байлгахад чухал нөлөөтэй учир эрэгтэйчүүдийн стрессийг ажил, хөдөлмөр эрхлэлттэй нь хамааруулан судлах хэрэгцээ шаардлага үүсч байна.

Судлагдсан байдал:

Ажлын байрнаас үүдэлтэй стрессийг илрүүлэх болон стресс менежмент сургалтын хүрээнд дараах судалгаа нь хийгдсэн байна. Хэд хэдэн байгууллагууд өөрийн ажилчдын дунд ажлын байртай холбоотой нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн байгаагаас Хөдөлмөрийн яамнаас явуулсан судалгааг авч үзвэл амралтын цаг, өсөн хөгжих боломж, ажлын ачаалал, цалин гэсэн асуулт дээр огт сэтгэл ханамжгүй 14.5 хувь, хангалуун бус 36 хувийн үзүүлэлттэй байгаагаас (ХНХЯ, 2015) үзэхэд Монгол дахь ажлын байрны нөхцөл хэр хангалтгүй байгааг харж болох юм.

Азийн орнуудад хийгдсэн судалгааны ажлаас дурьдвал Шри Ланк, Гайна болон Япон улс нь дэлхийд амиа хорлолтоороо тэргүүлдэг. Эдгээр улсуудын амиа хорлолтын голлох шалтгаануудад ажлын ачаалал, сургуулийн дарамт, эргэн тойрныхны гутаан доромжлолт байдаг бөгөөд Япон улсын ЗГ-аас гаргасан тоо баримтаар 2020 оны байдлаар 2153 хүн амиа хорлосон байна (Амгалан, 2020)

Дэлхий дахинд хийгдсэн судалгааны ажлуудаас дурьдвал АРА агентлагаас жил бүр хийдэг «Америк дахь стресс» судалгаанаас үзэхэд Америкчуудын ихэнх стрессийн эх үүсвэр нь ажлын стресс байдаг гэжээ (СХҮХ, 2020).

Судалгааны зорилго: Удирдлагын болон ажилчдын хэвийн ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх зорилгоор залуу идэр насны эрэгтэйчүүдийн стресстэхэд



нөлөөлөх ажлын байран дахь хүчин зүйлсийг судлах

Судалгааны арга, аргачлал

Судалгааны зорилгын хүрээнд сэтгэц оношилгоо болон стрессийг тодорхойлох асуулгын тусламжтай олж авсан үр дүнд SPSS21 программыг ашиглан чанарын болон статистик боловсруулалт хийсэн. Судалгаанд ашигласан аргачлалууд.

- ✓ Стрессийг тодорхойлох асуулга.
- ✓ Түгшүүрийг үнэлэх Спилбергер, Ханин нарын тест

Судалгааны боловсруулалт

- Чанарын боловсруулалт
- Статистик боловсруулалт - “SPSS 25” программ

Судалгааны түүвэр:

Санамсаргүй түүврийн аргаар нийт 90 эрэгтэй судлуулагч оролцсон

Эрэгтэй хүнийг тайлбарласан онол

Эрэгтэй хүйстэн нь хүн төрөлхтөн үүссэн цагаас эхлээд хүний хөгжлийн аль ч цаг үед бие физиологийн бяраа чадал, тэсвэр хатуужил, эрэлхэг зоригоороо ахуй амьдрал, нийгмийн оролцоонд хүнд хүчир, хатуу ширүүн гэсэн ажлуудыг хуваарилж авдаг түүгээр зогсохгүй одоог хүртэл сэтгэл зүйн хатуу чанга байр суурийг эрхэмлэж явахыг захидагтай холбоотойгоор нас биед хүрсэн үедээ ч сэтгэл хөдлөлөө гаргадаггүй, дотогшоо шинж чанартай, сэтгэл хөдлөлийн буглиу байдал ихээхэн ажиглагддаг. Энэ нь гэр бүлдээ өсөж торних, найз нөхдийн хүрээнд, эхнэр, хүүхдийн дунд тэр тусмаа ажлын байран дээр үүссэн стрессэд тухайн цаг дор нь өөрийн сэтгэл хөдлөлийн хариу урвалаа эерэг зөвөөр гаргаж илэрхийлж сурахад нь сөргөөр нөлөөлдөг.

Эрэгтэй хүнд нийгмээс тохсон эзэн, хүчирхэг, хамгаалалт гэх мэт ойлголт болон тэдний эрэгтэй хүний үүрэгтэй нь нягт холбоотойгоор сайн эцэг, сайн хань, нөхөр мөн сайн ажилтан байхыг шаарддаг. Тиймээс нийгмийн зүгээс тэдэнд эхлээд “халамж” үзүүлэх болон тэднийг зөв төлөвшилтэй бие хүн болоход нь анхаарах хэрэгтэй. 1973 онд Ж.Хоманс (1910-1989) нь хүмүүс хоорондын харилцан үйлчлэлийг сайшаал, шийтгэлийн нөлөөгөөр явагддаг бөгөөд сайшаагдаад байгаа үйлдлээ дахин дахин давтах хандлагатай байдаг гэж үзсэнээс солилцооны онол үүссэн. Нийгмийн солилцооны онолын үүднээс ажил мэргэжил эрхлэгчдийн зан байдлыг тайлбарлавал амжилтын зарчмаар шагнагдах тусмаа аливаа нэг үйл

даштагддаг, урамшууллын зарчмаар хэрэв шагнал тодорхой тохирсон нөхцөлд явагддаг байсан бол ажилчид тэр л нөхцлийг дахин хангах болно, үнэт зүйлс эрхэмлэлийн зарчмаар хэрвээ шагнал нь сэтгэл ханамжтай болгодог бол ажилчид хэдий хүртэл хүч зарцуулсан ч чадна гэсэн зарчмууд ажилладаг.

Эрэгтэй хүмүүс дээр зөрчилдөөний онолын үүднээс тайлбар хийвэл эрэгтэйчүүд нь зөвхөн ажил хөдөлмөр эрхэлж гэр бүлээ санхүү, эдийн засгийн хувьд хангах бус эрэгтэйчүүд нь гэр бүл төлөвлөлтийн хүрээнд эцэг, нөхөр, ээж аавынхаа хүү нь байх зэрэг олон дүрүүдийг хамтад нь үүрч байна. Иймд эрэгтэй хүний хувьд стресстэх, уур бухимдлаа гадагшлуулах хэрэгцээ үүсэх бөгөөд энэ үед нь нийгэм, эдийн засагтай холбоотойгоор төдийгүй ажлын байрны орчинд нь ч мөн тодорхой хэмжээний зохих тусламж дэмжлэгийг үзүүлж байх нь чухал юм.

Стрессийг тайлбарласан онол

Стресс гэх ойлголтыг хамгийн анх Канадын эрдэмтэн Г.Селье гаргаж тавьж байсан бөгөөд стресс гэх нэр томъёо нь хүчээр үйлчлэх, доргиох, хүч гэсэн утга бүхий үг. Цаашлаад “Хүнд гаднаас үйлчилж буй эерэг, сөрөг хүчин зүйлийн үйлчлэл, түүнд хариу өгөх чадвар, дасан зохицох чадварыг стресс гэнэ. Стрессийг үүсгэж буй хүчин зүйлс буюу тухайн нөхцөл байдлыг стресс үүсгэгч /stressor/ гэх бөгөөд өдөөгчид /stimuli/ ямар нэг хариу үйлдэл /reaction/ үзүүлнэ. Өөрөөр хэлбэл бороо орж газрыг норгоход газар усаар норж орхихыг хэлж болно. Энэ тохиолдолд бороо орж байгаа нь гаднаас ирж буй өдөөгч, газар норж байгаа нь хариу үйлдэл үзүүлж буй юм. Стрессийг илэрч буй илрэлээр эерэг /эустресс/, сөрөг /дистресс/ хэмээн 2 ангилна (Селье. 2015). Стрессээс үүдэн гарах эрсдлүүдийг үнэлэх замаар Холмес, Рахе нар /Holmes and Rahe/ стрессийн хэмжүүрийг буюу түвшинг тодорхойлох арга боловсруулж гаргасан. Стрессийг дотор нь хөнгөн, дунд, хүнд гэж ангилах бөгөөд тухайн хүний эмзэг байдал, дасан зохицох чадвараас хамаараад гадагшаа эерэг болон сөрөг хэлбэрээр илрэн гарч байдаг. Гэсэн ч энэ нь сэтгэцийн эмгэггүй хүнд тохиолдож болох ба сэтгэл гутралаас хөнгөн түвшний сэтгэл зүйн ойлголт. Стресс бий болсон бол шинж тэмдгүүд нь ихэвчлэн гадны нөлөөллөөс хэдэн минутын дараа гарч ирдэг бөгөөд холимог буюу гэнэт огцом өөрчлөгдөж буй дүр төрхийг харуулдаг төдийгүй ухамсрын талбайн зарим хэсэг нарийсаж улмаар анхаарал төвлөрөлт буурч, өдөөгчийг ухамсарлаж, хэвийн ойлгож чадахгүйд хүрэх гэх мэтээр илэрч хэд хоног эсвэл хэдэн цагийн дараа стресс нь арилдаг байна.

Гэвч ихэнхдээ стресс нь хүнийг сэтгэлийн хямралд оруулах, бухимдаж

Стресс үүсгэх ерөнхий шалтгаануудыг эдийн засаг, санхүүгийн асуудлууд,



гэр бүл төлөвлөлт, хосын болон хүүхэдтэй холбоотой, ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой, биеийн өвчлөл, эмгэг зэрэгтэй холбоотой гэж авч үзсэн. Хотын амьдрал хэвийн байх ёстой ачааллаас илүү хурд шаарддаг. Иймээс бухимдал илүү үүснэ. Оюун ухааны хяналтын төв хүний духны хэсэгт байрладаг. Сэтгэл хөдлөлдөө автахад цусанд ялгарч байгаа даавар нь оюун ухаан хэвийн ажиллахад саад болж эхэлдэг. Ихэнхдээ хүмүүс уур бухимдлаа сул дорой хүмүүст гаргана. Өөрөөсөө эрх мэдэл болон биеийн хүчээр илүү хүн рүү гаргаж чадахгүй. (Б.Номин, 2020) Тиймээс ажлын байрнаас үүдэлтэй стрессийн хариу үйлдлийг тэр даруйд нь бус гэр бүлийн болон найз нөхдийн хүрээнд гаргадаг талтай. Үүнийг гэр бүлийн хүчирхийлэл хэмээн андуурч ташаа тоо баримт гарах өндөр магадлалтай.

Стрессийн өөр нэг хэлбэр нь түгшүүр. Түгшүүрийг нь хэвийн болон эмгэг гэж хоёр ангилдаг. Хэвийн сэтгэл түгшилт нь ямар нэг нөхцөл байдлын улмаас бий болдог бөгөөд асуудал намжих үед сэтгэл түгшилт ч мөн арилдаг. Үүгээрээ стресстэй адил төстэй юм.

Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой онол

Ажлаас үүдэлтэй стресс гэх ойлголт хамгийн анх хувийн ашиггүй, хэрэгцээгүй гэсэн мэдрэмжтэй хосолсон ядаргааны туйлдсан байдал хэмээх утга агуулгаар хэрэглэгдэж байжээ.

Сэтгэл судлалын хэд хэдэн салбар нь мэргэжлийн стресс тэр дундаа эмнэл зүйн сэтгэл судлал, хөдөлмөрийн эрүүл мэндийн сэтгэл судлал, хүний хүчин зүйл болон эргономик /хүн, техник хоорондын харилцаа хамаарлыг судалсан салбар шинжлэх ухаан/ мөн үйлдвэрлэл, байгууллагын сэтгэл судлал гэх зэрэг асуудлуудтай нягт холбогддог. Ажлын стресс нь ажилтан болон ажил олгогч, удирдлагуудын аль аль талд бие махбодын болон сэтгэл зүйн хувьд хамааралтай байдаг тул байгууллагын уур амьсгалд төдийгүй ажлын гүйцэтгэлийн үр дүнд шууд нөлөөлж энэ нь эргээд дарга удирдлага, ажилчдад сөргөөр нөлөөлдөг тасралтгүй гинжин хэлхээ юм. Ажлаас үүдсэн стрессийг таньж ойлгож, ажлын байран дээрх стресс үүсгэгч шалтгааныг илрүүлсэн үед зохицуулах боломжтой. Тийм учраас ажилчдын хэвийн ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх зорилгоор хүнээс болон бусад хүчин зүйлсээс хамаарч болох хамгийн боломжит хувилбарыг гарган ирэх явдал нь туйлын чухал.

Хөдөлмөрийн сэтгэл судлалын шинжлэх ухааны үүднээс мэргэжилтэн болох үйл явцыг олон талаас нь судалсан байх бөгөөд Э.Эриксон, Д.Сьюпер, Австрийн сэтгэл судлаач А.Адлер, Голландын сэтгэл судлаач Б.Ливехуд, Оросын сэтгэл судлаач Е.А.Климов, А.К.Маркова, Н.С.Пряжников, Э.В.Зеер, Монголын сэтгэл

судлаач Д.Санжжав, Ц.Нина зэрэг олон эрдэмтнийг дурьдаж болох бөгөөд эдгээр эрдэмтэд нь 25-дээш насны хөдөлмөр эрхлэгч мэргэжилтнүүд нь ажил мэргэжлийн сонирхол төлөвших үйл явцын аль шатанд байдгийг тодорхойлсон бөгөөд 25-35 насны үед мэргэжиж хөгжих үйл явц эрчимтэй явагдах, мэргэжлийн шинж төрхийг олох, жинхэнэ мэргэжилтэн болж төлөвших гэсэн шинж чанаруудыг агуулдаг байна. 36-аас дээш насны үед мэргэжлийн ур чадварын дээд түвшинд хүрэх, ажил мэргэжлийн эв дүй, техник, ур чадваруудыг бүтээлчээр эзэмших, шилдэг мэргэжилтэн болох зэрэг шинжүүдийг агуулдаг. Гэтэл энэ насны үед боловсрол, мэдлэг доогуур, боломж бололцоо тааруу, өөрийн сонгосон салбартаа амжилт гаргаж чадаагүй, ажил, хамт олондоо өөрийн байр суурийг үнэлүүлж, эл авах ёстой мэдрэмжүүдээ авч чадахгүй байх нь ажил мэргэжлийн стрессэд өртөх үндэс болдог байна.

Судалгааны үр дүн

Хүснэгт 1. “Ажил эрхлэлтийн байдал”

Ажил эрхлэлт					
		Frequen- cy	Percent	Valid Per- cent	Cumulative Percent
Valid	Төрийн байгууллага	21	23.3	23.3	23.3
	Хувийн байгууллага	51	56.7	56.7	80.0
	Хувиараа	18	20.0	20.0	100.0
	Total	90	100.0	100.0	


Ажил эрхлэлтийн байдлыг нь авч үзвэл төрийн байгууллагад ажилладаг 23.3%, хувийн байгууллагад ажилладаг 56.7%, хувиараа хөдөлмөр эрхлэгч 20% тус тус хамрагджээ.

Хүснэгт 2. “Ажилласан жилийн эзлэх хувь”

Ажилласан жил					
		Frequen- cy	Percent	Valid Per- cent	Cumulative Percent
Valid	0-3 жил	34	37.8	37.8	37.8
	4-7 жил	23	25.6	25.6	63.3
	8-10 жил	8	8.9	8.9	72.2
	10-с дээш жил	25	27.8	27.8	100.0
	Total	90	100.0	100.0	

Ажилласан жилээр нь аваад үзвэл 0-3 жил ажилласан 37.8%, 4-7 жил ажилласан 25.6%, 8-10 жил ажилласан 8.9%, 10-с дээш жил ажилласан 27.8% тус тус гарч байна.

Зураг 1. “Ажлын шалтгаант стрессийн график”



Судалгаанд оролцогчдын хувьд бухимдуулж стресстүүлээд байгаа ажлын шалтгаант стресс бий гэж 74.4% нь бөглөжээ.

Хүснэгт 3. “Ажлаа хийхэд саад учруулж буй голомтот асуудлууд”

	Давтамж	%
Ажлын ачаалал	32.00	35.56%
Хамт ажиллагсад таарамж муу	14.00	15.56%
Удирдлага ойлголцох хүнд	19.00	21.11%
Цаг тулсан ажил	28.00	31.11%
Тоног төхөөрөмж хангалтгүй	15.00	16.67%
Ажиллах орчин тухгүй	19.00	21.11%
Ажилд ахих боломж муу	20.00	22.22%
Ажилчид хов хэрүүл их	23.00	25.56%
Цалин урамшуулал муу	26.00	28.89%
Саналаа солилцдоггүй	11.00	12.22%
Үнэлгээ хангалтгүй	19.00	21.11%
Сургалт мэдээлэл хангалтгүй	16.00	17.78%
Давхар ажил хийлгэдэг	16.00	17.78%

Мэргэжлийн чадваргүй байдал	8.00	8.89%
Чадвараас давсан ажил	6.00	6.67%

Ажлын байран дээрх ажлаа хийхэд саад учруулдаг тулгамдсан асуудлуудаас хамгийн давтамжтай буюу ажлын ачаалал 35.5%, цаг тулсан ажил 31.1%, хамгийн бага буюу мэргэжлийн чадваргүй байдал 8.8%, чадвараас давсан ажил 6.6% тус тус эзэлж байна.

Зураг 2. “Ажлын байран дахь тулгамдсан асуудлуудыг эрэмбэлсэн нь”



Ажлын байранд тулгамддаг асуудлын талаар судлахад ажлын ачаалал, цаг тулсан ажил, цалин хөлс, ажилчдын хов яриа хамгын өндөр саад учруулах хүчин зүйлс болж байна.

Хүснэгт 4. “Нөхцөл байдлын түгшүүр болон бие хүний түгшүүрийн хамаарал”

Correlations		Нөхцөл байдлын түгшүүр	Бие хүний түгшүүр
Бие хүний түгшүүр	Pearson Correlation	.693**	
	Sig. (2-tailed)	.000	
Ажлын ачаалал	Pearson Correlation	.252*	.251*
	Sig. (2-tailed)	.017	.017
Хамт ажиллагсад таарамж муу	Pearson Correlation	.219*	.303**
	Sig. (2-tailed)	.038	.004
Ажилчид хов хэрүүл их	Pearson Correlation	.225*	.250*
	Sig. (2-tailed)	.033	.017
Сургалт мэдээлэл хангалтгүй	Pearson Correlation	.239*	
	Sig. (2-tailed)	.023	

** . Correlation is significant at the 0.01 level (2-tailed).



*. Correlation is significant at the 0.05 level (2-tailed).

Нөхцөл байдлын түгшүүр болон бие хүний түгшүүр нь хоорондоо хамааралтай ($r=0.693$, $P \text{ value}=0.000$) байна. Хамаарлын коэффициент эерэг утгатай байгаа нь шууд хамааралтай болохыг илэрхийлж байна. Доор зөвхөн хамааралтай ($\text{Sig}>P \text{ value}$) утгуудыг оруулсан болно. Нөхцөл байдлын түгшүүр нь ажлын ачаалал ($r=0.252$, $P \text{ value}=0.017$), хамт ажиллагсад таарамж муу ($r=0.219$, $P \text{ value}=0.038$), ажилчид хэрүүл хов их ($r=0.225$, $P \text{ value}=0.033$), сургалт, мэдээлэл хангалтгүй ($r=0.239$, $P \text{ value}=0.023$) зэрэгтэй эерэг хамааралтай мөн бие хүний түгшүүр нь ажлын ачаалал ($r=0.251$, $P \text{ value}=0.017$), хамт ажиллагсад таарамж муу ($r=0.303$, $P \text{ value}=0.004$), ажилчид хэрүүл хов их ($r=0.252$, $P \text{ value}=0.017$) зэргүүдтэй эерэг хамааралтай байна. Нөхцөл байдлын түгшүүрээс ялгарах нь сургалт, мэдээллийн муу байдалтай хамааралгүй байгаа юм.

ДҮГНЭЛТ

1. Судалгаанд оролцсон нийт хүмүүст чанарын болон статистик шинжилгээ хийхэд ажлын шалтгаант стресст өртсөн хүмүүс нийт судлуулагчдын дийлэнх буюу 74 хувийг эзэлж байна. Ажлын байран дээрх ажлаа хийхэд саад учруулдаг тулгамдсан асуудлуудаас хамгийн давтамжтай буюу ажлын ачаалал 35.5%, удаад нь цаг тулсан ажил 31.1%, хамгийн бага буюу мэргэжлийн чадваргүй байдал 8.8%, чадвараас давсан ажил 6.6% тус тус эзэлж байна. Үүнээс дүгнэхэд мэргэжлийн чадваргүй байдал, чадвараас давсан ажил гэсэн хувилбарууд бага давтамжтай байгаа нь судлуулагчдын хувьд чадвараас давсан ажил болон мэргэжлтийн чадваргүй байдал багатай эсвэл тухайн чадвар, мэргэжилд нь тохирсон ажлыг ихэнх нь гүйцэтгэдэг гэсэн үг юм.
2. Ажлын байранд дээр ажлаа хийхэд саад болдог зүйлсийг давтамжаар жагсаахад ажлын ачаалал, цаг тулсан ажил, цалин урамшуулал нь ажлаа хийхэд саад болдог голлох хүчин зүйл болж байна.
3. Түгшүүрийн түвшинг бусад хүчин зүйлстэй харьцуулан хамаарлын шинжилгээ хийхэд нөхцөл байдлын түгшүүр нь ажлын ачаалал, хамт ажиллагсадтайгаа таарамж муу байдал, ажилчдын дунд хэрүүл хов их, сургалт мэдээллийн хангалтгүй байдал зэрэгтэй эерэг хамааралтай байна. Үүнээс дүгнэхэд дээрх хүчин зүйлс ажлын байрны стресс үүсгэхэд нөлөөлж буй голлох шалтгаан болж байна.

4. Бие хүний түгшүүр нь ажлын ачаалал, хамт ажиллагсадтай таарамж муу, ажилчид хэрүүл хов их зэргүүдтэй эерэг хамааралтай байна. Үүнээс дүгнэхэд бие хүний түгшүүрийн түвшин өндөр хүмүүс дээрх хүчин зүйлсээс болж стресст өртөх хандлагатай байна.
5. Судалгааны дээрх үр дүнгүүдээс харахад 25-44 насны эрэгтэйчүүдийн стресс хөдөлмөр эрхлэлттэй хамааралтай байна. Уг судалгаагаар эрэгтэйчүүдийн стрессийг ажил хөдөлмөр эрхлэлттэй нь судлах зорилго тавьсан бөгөөд цаашид уг судалгааг эрэгтэйчүүдийн стрессийн онцлогийг бие хүний зан төлөвийн онцлог шинжээр нь харьцуулан судлах, эмэгтэй хүмүүсийн стресстэй харьцуулан судлах зэргээр стресс үүсгэгч хүчин зүйлсийг илрүүлэхэд үр дүнтэй юм.

НОМ ЗҮЙ

1. Монгол өрх сэтгэл зүйн хүрээлэн. (2019). Эрчүүд ба хөвгүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх гарын авлага. УБ
2. Сэтгэц хэмжилзүйн үндэсний хүрээлэн. (2020). Ажил дээрх стрессийг даван туулах сэтгэлзүй. УБ
3. Үндэсний статистикийн хороо. (2020). Суурь судалгааны тайлан. УБ
4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. (2015). Хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой байдлын судалгаа. УБ
5. Kendra Cherry. (2021). Нийгмийн солилцооны онол
6. Селье Г. (2015). Стресс. УБ
7. Нарантуяа Н. (1999). Стрессийн тухай ойлголт. УБ
8. Номин Б. (2020). Unen.mn: Ажилтнууд нь стрессгүй, урам зоригтой байвал байгууллагын ажлын бүтээмж өндөр байна. (Ярилцлага). УБ
9. Амгалантуул, Н (2020). Ажилгүй болсон Япончууд амиа хорлох нь ихэсжээ нийтлэл. УБ



СЭТГЭЛ ХӨДЛӨЛИЙН ОЮУН УХААНЫГ ХӨГЖҮҮЛЭХЭД СЭТГЭЛ ЗАСЛЫГ АШИГЛАСАН ҮР ДҮН

Магистр П.Сүнжидмаа

(ОУУБИС. ХНУС)

sunjidmaa.p@ulaanbaatar.edu.mn

Түлхүүр үг: Сэтгэл хөдлөлийн оюун ухааныг хөгжүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө, залуу насныхны сэтгэл зүйн хөгжил

Keyword: Emotional Intelligence Development, Psychological Training, Psychological Development of Youth

Summary

Emotional intelligence, as a factor contributing to successful professional activity and interpersonal relationships, has recently attracted much attention from society. The ability to recognize and acknowledge one's own feelings, as well as those of others, the ability to express them appropriately, and manage emotions to achieve goals constitute the concept of emotional intelligence. People with a high level of emotional intelligence are able to use their abilities more effectively and build harmonious lives. During young age, personality development takes place, marking the transition from childhood to adulthood and often an increased emotional separation from parents. Intimate and personal communication becomes both an important age-related need and a leading activity, and it is impossible without understanding one's own feelings and those of others.

A practical analysis shows that young people often lack sufficient skills to manage their emotional states, which can lead to challenges such as aggression, deviant behavior, and social isolation. Exploring this topic can contribute to identifying and developing effective methods for fostering emotional intelligence, tailored to the age-specific characteristics of young adults. The research problem can be formulated as follows: "What psychological and training methods are effective for developing emotional intelligence in young adults?"

УДИРТГАЛ

Сэтгэл хөдлөлийн оюун ухаан (цаашид “СХОУ” гэх) нь хувь хүний сэтгэл зүй болон бусадтай харилцах чадварт чухал нөлөө үзүүлдэг. Өөрөөр хэлбэл хүн өөрийн сэтгэл хөдлөлийг таньж мэдэх, гадаад илрэлийг хянах, бусдын сэтгэл хөдлөлийг ойлгох, харилцаанд үр дүнтэй ашиглах чадварыг СХОУ гэж тодорхойлдог. Сэтгэл хөдлөлийн оюун ухаан нь анхлан 1990-ээд оны үед Жон Мэйер, Питер Саловей нарын судалгааны үр дүнд хөгжиж эхэлсэн байдаг. Тэдний судалгаагаар СХОУ нь хувь хүний сэтгэл зүйн амьдрал, нийгмийн харилцааны чухал хэсэг болохыг баталсан (Mayer & Salovey, 1997) бөгөөд энэхүү ойлголт нь Даниел Гоулманы (1995) судалгаагаар улам өргөжин тэлж, СХОУ нь хувь хүний амьдралд IQ буюу оюун ухааны чадамжаас илүү өндөр ач холбогдолтой болохыг нотолсон байдаг.

СЭТГЭЛ ХӨДЛӨЛИЙН ОЮУН УХААН

Орчин үеийн нийгэмд хувь хүнд зөвхөн мэдлэг, чадвартай байх нь хангалтгүй ба бусадтай харилцах, өөрийгөө зөвөөр илэрхийлэх, стрессийг даван туулах зэрэг чадваруудыг эзэмших нь чухал болсон. 1995 онд хийсэн Гоулман нарын судалгаанаас харахад СХОУ нь хувь хүний амьдралын янз бүрийн хүрээнд амжилт гаргах үндсэн хүчин зүйлсийн нэг болж байгаа бөгөөд харилцааны ур чадвар, өөртөө итгэх итгэл, өөрийн үнэ цэнийг ойлгоход эергээр нөлөөлдөг (Goleman, 1995) гэж нотолсон байдаг. Мөн СХОУ өндөртэй хүмүүс нь сэтгэл зүйн эрүүл мэндийн хувьд тогтвортой, стрессийг зохицуулах чадвар сайтай байдаг тул энэ нь хувь хүний урт хугацааны амжилтад чухал үүрэг гүйцэтгэдэг байна.


Сэтгэл хөдлөлийн оюун ухааныг тайлбарлах хэд хэдэн онолууд байдаг.

Судлаач Жон Майер, Петр Саловей нар СХОУ-г дөрвөн үндсэн чадварт хуваан үздэг. Тэдгээрт:

1. Сэтгэл хөдлөлөө таниж мэдрэх,
2. Сэтгэл хөдлөлөө ашиглах,
3. Сэтгэл хөдлөлөө ойлгох,
4. Сэтгэл хөдлөлөө хянах явдал юм.

Тэдний үзэж буйгаар СХОУ нь өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийг таньж, ойлгож, удирдаж сурах замаар хөгждөг бөгөөд энэ нь хувь хүний зан үйлийн хөгжилд чухал нөлөө үзүүлдэг (Mayer & Salovey, 1997) гэж үзсэн байдаг.

Хүснэгт 1. Майер-Саловей-Карузогийн сэтгэл хөдлөлийн оюун ухааны загвар



Гоулманы загвар нь өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, сэтгэл хөдлөлөө удирдах, өөрийгөө сэдэлжүүлэх, бусадтай харилцаа холбоо тогтоох, сэтгэлээ хуваалцах гэсэн таван бүрэлдэхүүнтэй (Goleman, 1995). Тэдгээрт СХОУ-г илүү өргөн хүрээтэй ойлгож, хувь хүний харилцаа, ажил амьдралд үр дүнтэйгээр хэрэглэх боломжтой гэж онцолдог. Харин Оросын сэтгэл зүйч Люсина Д.В-ийн тодорхойлсноор СХОУ нь өөрийн дотоод сэтгэл хөдлөлийг таних болон удирдахаас гадна бусдын сэтгэл хөдлөлийг ойлгох, удирдах гэсэн бүтэцтэй.

Хүснэгт 2. Д. В. Люсинагийн сэтгэл хөдлөлийн оюун ухааны загвар

	Хүн хоорондын СХОУ	Дотоод СХОУ
Сэтгэл хөдлөлөө ойлгох	Бусдын сэтгэл хөдлөлийг ойлгох	Өөрийн сэтгэл хөдлөлийг ойлгох
Сэтгэл хөдлөлөө удирдах	Бусдын сэтгэл хөдлөлийг удирдах	Өөрийн сэтгэл хөдлөлийг удирдах

Эдгээр хоёр хэлбэр нь өөр өөр танин мэдэхүйн үйл явц болон ур чадварыг шаарддаг боловч хоорондоо уялдаа холбоотой байх ёстой гэж үздэг.

ЗАЛУУ НАСАН ДАХЬ СХОУ-Ы ОНЦЛОГ

Залуу нас (18-25 нас) бол хувь хүний сэтгэл зүйн хөгжлийн хамгийн эрчимтэй үе бөгөөд энэ хугацаанд бие махбодын өсөлт, сэтгэл хөдлөлийн өөрчлөлт, нийгмийн харилцааны ур чадварууд хурдтай хөгждөг. Энэ үед залуучуудын сэтгэл хөдлөлийн оюун ухааны (СХОУ) хөгжлийг дэмжих нь тэдний амьдралын чанар, ирээдүйн амжилтад онцгой нөлөөтэй байдаг (Goleman, 1995). СХОУ нь залуучуудад өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийг ойлгож, түүнийгээ удирдах, бусадтай харилцах, харилцаагаа үр дүнтэй зохицуулахад тусалдаг чухал чадвар юм (Mayer & Salovey, 1997). Энэ үеийн онцлог бол оюун ухаан, зан төлөвийн төлөвшилтэй зэрэгцэн

хувь хүн харилцааны ур чадвараа хөгжүүлж эхэлдэг явдал юм. Залуу насны эхэн үед өсвөр наснаас бие хүн болж төлөвшин дотно, хувийн харилцаа холбоо нь голлох, чухал хэрэгцээ болж хувирдаг ба энэ нь өөрийн болон бусдын мэдрэмжийг ойлгохгүйгээр бүрэн хэрэгжүүлэх боломжгүй. Оюутан залуусын хувьд СХОУ нь нийгмийн харилцааны ур чадварын суурь болж, тэднийг бусадтай эерэг харилцаа тогтоож, бэрхшээлтэй нөхцөлд өөрийгөө зөв илэрхийлэхэд тусалдаг (Brackett, Rivers, & Salovey, 2011). Энэ үе шатанд бусдын сэтгэл хөдлөлийг ойлгох чадвар болох “эмпати” нь маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Судалгаанаас үзэхэд бусдын сэтгэл хөдлөлийг ойлгох чадвар өндөртэй өсвөр насныхан илүү амжилттай, өөртөө итгэлтэй, сэтгэл зүйн хувьд эрүүл байх магадлалтай байдаг (Denham et al., 2009). Залуу насанд СХОУ нь ажил, мэргэжлийн харилцаанд болон боловсрол эзэмшихэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Жишээ нь, сэтгэл хөдлөлөө удирдах чадвар сайтай хүмүүс ажлын байран дахь стрессийг даван туулах, бусадтай үр дүнтэй хамтран ажиллах чадвартай байдаг нь батлагдсан (Zeidner, Matthews, & Roberts, 2004). СХОУ өндөртэй оюутнууд амьдралдаа илүү тогтвортой, сэтгэл хангалуун байж, стресстэй нөхцөл байдалд сөрөг хариу үйлдэл үзүүлдэггүй онцлогтой байдаг (Goleman, 1995)

СХОУ-ЫГ ХӨГЖҮҮЛЭХЭД СЭТГЭЛ ЗҮЙН ЗАСЛЫГ АШИГЛАХ

Сэтгэл зүйн зөвлөгөө гэдэг нь хувь хүний оюун санааны хөгжил, сэтгэл хөдлөл, дотоод ур чадварыг сайжруулахад чиглэсэн сургалт, дасгалуудын нэгдэл юм. Энэхүү арга нь хүн өөрийгөө илүү сайн ойлгож, мэдрэх, сэтгэл хөдлөлөө удирдах, бусадтай харилцах ур чадвараа нэмэгдүүлэхэд тусалдаг. Брэккет нарын судлаачид СХОУ-г зөвхөн төрөлхийн бус, тодорхой сургалт, арга техникүүдийн тусламжтайгаар хөгжүүлж болох чадвар гэж тодорхойлдог. Судалгаанаас үзэхэд СХОУ нь дасгал сургуулилт, өөрийгөө ухамсарлахуй, бясалгал зэрэг аргын тусламжтай нэмэгдэх боломжтой гэж үздэг (Brackett et al., 2011). Багаар ажиллах, харилцааны чадвар олгох сургалт, бусдыг ойлгох чадвар хөгжүүлэх дасгалууд нь энэ чадварыг хөгжүүлэх үр дүнтэй арга зам болдог. СХОУ-г хөгжүүлэхэд бүлгийн болон ганцаарчилсан зөвлөгөө нь сэтгэл хөдлөлөө илүү ухамсартай ойлгож, хянахад чиглэсэн дасгал, техникүүдийг ашиглахад тулгуурладаг (Zeidner et al., 2004). Саловей нарын судалгаанд өгүүлснээр СХОУ нь өөрчлөгдөж, дасан зохицох чадвартай буюу сургалт, дадлагаар нэмэгдэх боломжтой хувьсах чадвар юм (Salovey, 2006). Энэ нь хувь хүний амьдралын нөхцөл, сэтгэл зүйн дэмжлэгээс хамааран сайжирдаг. Сэтгэл зүйн засал нь оролцогчдын дунд харилцаа тогтоож,



сэтгэл хөдлөлөө нээлттэй илэрхийлэх, бусдын туршлагаас суралцах орчныг бүрдүүлдэг. Энэ нь оролцогчдод сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, хянах, бусдын сэтгэл хөдлөлийг ойлгох чадварыг нэмэгдүүлдэг бөгөөд СХОУ-ыг хөгжүүлэх үр дүнтэй арга юм (Vachkov, 1999). Өөрөөр хэлбэл оролцогчид сэтгэл хөдлөлөө хэрхэн зөв илэрхийлэх, хянах аргуудыг сурч авдаг бөгөөд энэ нь тэдэнд стресс, дарамттай үедээ тайван, хариуцлагатай хандах дадал болдог. Түүнчлэн сэтгэл зүйн бүлгийн ярилцлага нь “эмпати” буюу бусдын сэтгэл хөдлөлийг мэдрэх, ойлгох чадварыг хөгжүүлдэг. Бусдын сэтгэл хөдлөлийг ойлгох чадвар сайтай хүмүүс бусадтай үр дүнтэй харилцаж, зөрчилдөөнөөс зайлсхийж, нийгмийн орчинд илүү амжилттай оролцдог (Goleman, 1995). Өсвөр болон залуу насанд сэтгэл хөдлөлөө хянах чадваргүйгээс үүдэн зөрчилдөөн, стресст өртөх эрсдэл өндөр байдаг тул бүлгийн зөвлөгөө нь тэдэнд хэрэгтэй арга зүйг эзэмшүүлдэг (Zeidner et al., 2004). Тиймээс СХОУ-г хөгжүүлэхэд бүлгийн засал зохион байгуулах нь өсвөр болон залуу насныхны хувьд онцгой ач холбогдолтой байгаа нь энэхүү судалгааны үндэслэл болсон.

СУДАЛГААНЫ АРГА, ТҮҮВЭР

Энэхүү судалгаанд сэтгэл хөдлөлийн оюун ухааныг хөгжүүлэхэд чиглэсэн нөлөөллийг үнэлэх зорилгоор туршилтын, хяналтын хоёр бүлэгт нийт 36 оюутан оролцсон ба дундаж нас нь 19 байсан. Туршилтын ажлыг хийхийн тулд 19 оюутантай туршилтын бүлэг, 17 оюутнаас бүрдсэн хяналтын гэсэн хоёр бүлгийг тодорхойлсон. Туршилтын бүлэг нь сэтгэл хөдлөлийн оюун ухааныг хөгжүүлэхэд чиглэсэн сэтгэл засалд хамрагдсан бол хяналтын бүлэг ямар нэгэн нэмэлт сургалтад оролцоогүй. Тодорхойлолт, хяналтын үе шатанд туршилтын болон хяналтын бүлгийн оролцогчид сэтгэл заслын өмнө болон дараа нь ижил хугацааны интервалаар буюу 2023 оны 10 сар, 2024 оны 2-р сард оношлогдсон.

СУДАЛГААНЫ АРГА

Туршилтыг явуулахад сонгосон арга нь сэтгэл хөдлөлийн оюун ухааныг хэмжихэд зориулагдсан сэтгэлзүйн оношилгооны арга болох Д.В.Люсиний “Сэтгэл хөдлөлийн оюун ухааны тест” (EmIn) байсан. Зохиогчийн боловсруулсан тест нь сэтгэл хөдлөлийн оюун ухааныг өөрийнхөө болон бусдын сэтгэл хөдлөлийг ойлгож, түүнийг удирдах чадвар гэж тайлбарлахад үндэслэсэн болно.

Сургалтын шатанд 2023 оны 10-р сараас 2024 оны 2-р сар хүртэл үргэлжилсэн

цуврал сургалт, бүлгийн засал нь долоо хоногт нэг удаа 90 минутаар хичээллэсэн. Сэтгэл заслын уулзалтад нь сэтгэл хөдлөлийн ур чадварыг хөгжүүлэх, өөрийгөө бодитоор үнэлэх, харилцааны ур чадварыг хөгжүүлэх, эзэмшихэд чиглэгдсэн байв. Заслын туршид “Миний зан чанар”, “Харилцаа холбоо”, “Миний сэтгэл хөдлөл, мэдрэмж”, “Стрессийг даван туулах зэрэг” янз бүрийн сэдвээр нийт 18 хичээл, бүлгийн засал явагдсан. Сургалтын бүрэн төлөвлөгөө, хөтөлбөрийг Хавсралт 1-т оруулсан.

Судалгааг дөрвөн үе шаттайгаар явуулсан.

1. Бэлтгэл үе шат: Сэтгэл хөдлөлийн оюун ухааныг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах;
2. Тодорхойлох үе шат: Туршилтын болон хяналтын бүлгийн оюутнуудын анхан шатны оношилгоо;
3. Сургалтын үе: Туршилтын бүлэгт боловсруулсан хөтөлбөрийн дагуу сэтгэл зүйн заслыг явуулах;
4. Хяналтын үе шат: Туршилтын болон хяналтын бүлгийн сэтгэл хөдлөлийн оюун ухааны үзүүлэлтүүдийг дахин хэмжих, үр дүнг боловсруулах.


Судалгааны үр дүн:

Туршилтын болон хяналтын бүлгийн эхний түвшин:

Судалгааны эхэн үед туршилтын болон хяналтын бүлгийн оролцогчдын сэтгэл хөдлөлийн оюун ухааны түвшинд статистикийн хувьд мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаагүй. Туршилтын бүлгийн эхний онооны дундаж нь 80.5 ($SD = 5.3$), хяналтын бүлгийнх нь 79.8 ($SD = 6.0$) байв.

Сэтгэл зүйн засалд хамрагдахын өмнөх туршилтын болон хяналтын бүлгийнхний сэтгэл хөдлөлийн оюун ухааны түвшинд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа байгаа эсэхийг илрүүлэхийн тулд Манн-Уитнигийн шалгуурыг ашигласан. Шинжилгээний явцад бүх үзүүлэлтийн ач холбогдлын түвшин $p > 0.05$ байгаа нь хоёр бүлгийн хооронд статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаа илрээгүй болохыг харуулж байна.

График 1. Заслын өмнөх туршилтын болон хяналтын бүлгийн тестийн үр дүн



Засал эхлэхээс өмнө дараах онцлогууд ажиглагдаж байна:

- Өөрийн сэтгэл хөдлөлийг ойлгох болон удирдах чадвар нь бусдын сэтгэл хөдлөлийг ойлгох, чадвараас илүү өндөр байна. Үүнийг ихэнх харилцаа цахим хэрэгсэл ашиглан явагддаг учир залуу насныханд бодит амьдрал дээр бусдын сэтгэл хөдлөлийг ойлгож, удирдах нь хүндрэлтэй байдагтай холбон таамагласан.
- Өөрийнхөө сэтгэл хөдлөлийг удирдах, хянах чадвар өндөр түвшинд байгаа нь сургуулийн болон ажлын орчинд өөрийгөө хянах шаардлагаас үүдэлтэй байж болно гэж судалгааны эхэнд таамагласан.

Сэтгэл зүйн заслын дараах СХОУ-ий түвшин:

Бүлгийн заслыг зохион байгуулсны дараа оролцогчдын сэтгэл хөдлөлийн оюун ухааны түвшинг дахин хэмжсэн. Туршилтын бүлгийн дундаж оноо мэдэгдэхүйц өсч, 90,2 (SD = 4.7) болж, өөрийн сэтгэл хөдлөлийн таньж мэдэх, өөрийгөө хянах, бусдын сэтгэл хөдлөлийг ойлгох чадвар илүү хөгжсөнийг харуулж байна. Харин хяналтын бүлгийн дундаж оноо 81,2 (SD = 5.9) болж, анхны хэмжилттэй харьцуулахад бага зэрэг өссөн боловч статистикийн хувьд ач холбогдолгүй байна.

Top of FormBottom of Form


Хүснэгт 3. Заслын өмнөх болон дараах Wilcoxon T-тестийн үр дүн

Үзүүлэлт	Бүлэг	Засалд хамрагдахаас өмнөх дундаж утга (SD)	Засалд хамрагдсаны дараах дундаж утга (SD)	P утга
Бусдын сэтгэл хөдлөлийг ойлгох	Туршилтын бүлэг	24.7 (6.2)	30.3 (5.7)	< 0.01
	Хяналтын бүлэг	25.1 (6.0)	25.4 (5.8)	0.28
Бусдын сэтгэл хөдлөлийг удирдах	Туршилтын бүлэг	23.2 (4.8)	29.0 (4.6)	< 0.01
	Хяналтын бүлэг	22.9 (4.7)	23.3 (4.9)	0.30
Өөрийн сэтгэл хөдлөлийг ойлгох	Туршилтын бүлэг	29.4 (5.6)	34.0 (5.2)	< 0.01
	Хяналтын бүлэг	28.9 (5.5)	29.3 (5.4)	0.41
Өөрийн сэтгэл хөдлөлийг удирдах	Туршилтын бүлэг	27.5 (5.4)	33.1 (4.9)	< 0.01
	Хяналтын бүлэг	26.8 (5.1)	27.2 (5.0)	0.34
Ерөнхий СХОУ-ы түвшин	Туршилтын бүлэг	80.5 (5.3)	90.2 (4.7)	0.003
	Хяналтын бүлэг	79.8 (6.0)	81.2 (5.9)	0.12

Туршилтын болон хяналтын бүлгийн үр дүнгийн харьцуулалт

SPSS программд хоёр бүлгийн ялгааг шалгах зорилгоор хийсэн Манн-Уитнигийн U-критерийн шинжилгээгээр туршилтын болон хяналтын бүлгийн дараах үр дүнгийн ялгаа нь статистикийн хувьд мэдэгдэхүйц байсан ($U = 103.5$, $p < 0.03$). Үр дүнгээс харахад сэтгэл зүйн засал нь оролцогчдын сэтгэл хөдлөлийн оюун ухааныг сайжруулахад эерэг нөлөөтэй болохыг харуулж байна.

График 2. Заслын дараах туршилтын болон хяналтын бүлгийн тестийн үр дүн





ДҮГНЭЛТ

Сэтгэл зүйн заслын явцад туршилтын бүлгийн оролцогчдын СХОУ-ын ерөнхий түвшин мэдэгдэхүйц өссөн бол хяналтын бүлэгт бараг өөрчлөлт гараагүй. Хяналтын бүлгийн хувьд судалгааны эхэн ба төгсгөл үе шатны хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа илрээгүй хэдий ч үзүүлэлтүүдийн хувьд өсөлт гарсан. Эдгээр нь залуу насанд сэтгэл хөдлөл болон өөрийгөө эргэцүүлэх хөгжлийн идэвхтэй үедээ байдаг тул сэтгэл хөдлөлийг ойлгох, удирдах чадвар нь шинэ амьдралын туршлага хуримтлуулахын хэрээр, мөн хувь хүн болж хөгжихийн хэрээр аажмаар сайжирч болзошгүй. Түүнчлэн хяналтын бүлгийн оролцогчдод сэтгэл хөдлөлийн оюун ухааныг хөгжүүлэх нөхцөл, үйл явдал тохиолдсон байж болох юм. Жишээлбэл, эцэг эх, найз нөхөдтэйгөө харилцах, нийгмийн янз бүрийн үйл ажиллагаа, сургалтын төслүүдэд оролцох зэрэг нь сэтгэл хөдлөлөө таньж мэдэх, зохицуулах ур чадварыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж болно. Судалгааны үр дүнгээс харахад тусгайлсан сургалтгүйгээр ч залуу насныхан өсөлт хөгжил, амьдралын туршлагын тусламжтай энэхүү ур чадварыг аажмаар нэмэгдүүлж болох ч, сэтгэл хөдлөлийн оюун ухааны түвшин, бүрэлдэхүүн хэсгүүдийг тусгай сэтгэл зүйн заслаар үр дүнтэй хөгжүүлэх боломжтой байна.

Туршилтын бүлгийн нийт сэтгэл хөдлөлийн оюун ухааны түвшин сэтгэл зүйн заслын дараа, судалгааны эхэн үеийнхээс өссөн байна. Оролцогчдын өөрийн сэтгэл хөдлөлийг таньж, түүний илрэлийг хянах чадвар нэмэгдсэн ба сэтгэл зүйн засал нь залуучуудын сэтгэл хөдлөлийн оюун ухааны түвшнийг нэмэгдүүлэхэд үр дүнтэй арга болох нь батлагдлаа. Сэтгэл зүйн засал нь оролцогчдын сэтгэл хөдлөлөө танин мэдэх, бусдын сэтгэл хөдлөлийг хүлээн зөвшөөрөх, удирдах чадварыг нэмэгдүүлсэн үр дүнтэй байв. Тиймээс сэтгэл зүйн засал нь өсвөр болон залуу үеийнхний СХОУ-г хөгжүүлэхэд үр дүнтэй аргачлал байж болох бөгөөд сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, бусдын сэтгэл хөдлөлийг хүндэтгэх зэрэг чадваруудыг нэмэгдүүлснээр нийгмийн харилцаанд эерэг нөлөө үзүүлэх боломжтой гэж үзсэн.

Судалгааны үр дүнд сэтгэл зүйн засал нь өөрийн сэтгэл хөдлөлийг удирдах, бусадтай харилцах, бусдыг ойлгох чадварыг хөгжүүлэх зэрэгт эерэг нөлөөтэй нь батлагдсан тул боловсролын болон сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх байгууллагууд энэ төрлийн сургалтыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

1. Brackett, M. A., Rivers, S. E., & Salovey, P. (2011). *Emotional intelligence: Implications for personal, social, academic, and workplace success*. Social and Personality Psychology Compass, 5(1), 88-103.
2. Denham, S. A., Bassett, H. H., Mincic, M., Kalb, S., Way, E., Wyatt, T., & Segal, Y. (2009). "Social-emotional learning profiles of preschoolers' early school success: A person-centered approach". Learning and Individual Differences, 19(2), 229-238.
3. Goleman, D. (1995). *Emotional Intelligence: Why It Can Matter More Than IQ*. New York: Bantam Books.
4. Mayer, J. D., & Salovey, P. (1997). *What is emotional intelligence? In P. Salovey & D. Sluyter (Eds.), Emotional development and emotional intelligence: Educational implications* (pp. 3-31). New York: Basic Books.
5. Zeidner, M., Matthews, G., & Roberts, R. D. (2004). *Emotional intelligence in the workplace: A critical review*. Applied Psychology, 53(3), 371-399.
6. Вачков, И. В. (1999). *Групповая работа с подростками*. Москва: Смысл.
7. Люсин, Д. В. (2004). *Склонность к эмпатии как компонент эмоционального интеллекта*. Москва: Издательство Московского университета.

ГҮН УХААН

И СЫН ХҮН

Үхлийн тухай Монгол Солонгос хэлний эерүүлэлд гарч буй соёлын онцлогийг харьцуулсан судалгаа (солонгос хэлээр)

‘죽음’에 대한 한국과 몽골 완곡어법에 나타난 문화적 특성 비교

서론

연구목적

한국어나 몽골어에는 듣기에 거북하고 거친 표현이나 부담이 되는 말들을 좀 더 친근하고 부드러운 말로 표현하는 완곡어법이 많이 활용된다. 사람들에게 유행하는 병이나 금기와 관련된 표현들, 그리고 죽음과 같은 표현들이 그 대표적인 예라 할 수 있다. 본 연구에서는 한국어와 몽골어에서 ‘죽음’에 대한 완곡어법을 소재에 따라 분류하고 고찰함으로써 두 언어의 완곡어법에 나타난 문화적 특성들을 비교, 분석하고자 한다.

연구목표

‘죽음’에 대한 한국과 몽골 완곡어법들을 비교, 고찰하기 위해 연구자는 다음과 같은 세 가지 질문에 대해 답하고자 한다.

1. ‘죽음’에 대한 한국 완곡어법에 나타난 문화적 특성은 무엇인가?
2. ‘죽음’에 대한 몽골 완곡어법에 나타난 문화적 특성은 무엇인가?
3. ‘죽음’에 대한 두 나라 완곡어법의 문화적 유사점과 차이점은 무엇인가?

연구방법

연구자는 연구목적에 따른 정보를 얻고 그 특성을 파악하기 위해 문헌을 통한 비교, 고찰을 주 연구 방법으로 채택했다. 먼저 “죽다”에 대한 완곡어법을 조사, 분석하기 위해 ‘국립국어원 표준국어대사전’과 ‘몽골어대사전(Монгол хэлний их тайлбар толь)’에서 해당 정보들을 추출했으며, 이 정보들을 기초로 “죽다”에 대한 완곡어법을 소재별로 분류하고 두 언어의 표현들을 서로 비교, 고찰함으로써 언어문화적 특성들을 파악하고자 했다.

선행연구논문 고찰

한국과 몽골의 완곡어법을 비교한 논문으로는 성비락(2003)의 “한.몽 언어 문화적 특성 비교 연구 - 언어사고방식을 중심으로”가 있다. 성비락은 한국어와 몽골어 화자들의 사고와 언어간의 상관성을 색채어, 상징어, 완곡어와 금기어를 중심으로 고찰하면서 두 언어의 완곡어에 대해 비교, 고찰했으나 서너 가지 주제를 함께 다룬 논문의 특성상 죽음에 대한 완곡어법을 깊이 분석하지는 못했다. 김기선(2013)은 “몽골비사에 나타나는 중세 몽골유목민의 완곡어법 연구 - 성, 인명, 배변, 죽음에 관한 어휘를 중심으로”에서 몽골 비사에 나타난 죽음에 대한 어휘를 분석하면서 농경문화가 공간성을 중심으



로 하는 상하위계적 질서를 강조하는 반면, 유목문화는 시간성을 바탕으로 한 구성원간의 위상적 균형을 강조한다고 주장했다. 죽음에 관한 문화적 특성 연구에 대해서 김억조(2019)는 “‘죽음’을 나타내는 완곡어의 인지언어학적 해석”에서 죽음에 대한 완곡어법은 주로 이승에서 저승으로 이동하거나 여행, 잠, 그리고 신체의 일부 기능이 멈추는 것으로서 비유나 환유로 표현된다는 것을 강조했다.

본론

1. ‘완곡어법’에 대한 정의

완곡어법(euphemism)이란 단어는 그리스어 ‘euphēmismos’라는 말에서 유래했으며 그리스어 eu(좋은)와 phēmē(말하다)의 합성어이다. 그 뜻은 ‘좋게 말하다’이다. 사전적 정의를 보면 <국립국어원 표준대사전(2019)>에서는 완곡어법을 “듣는 사람의 감정이 상하지 않도록 모나지 않고 부드러운 말을 쓰는 표현법”이라고 정의했다. <캠브리지 영어사전(Cambridge dictionary)>에서는 “불쾌하거나 공격적인 말을 피하기 위해 사용하는 단어나 어구”를 뜻한다고 했으며, <브리태니커 백과사전(Encyclopædia Britannica)>도 “거북하거나 공격적인 말이나 표현을 대신해 사용하는 부드럽고 간접적인 말이나 어구”라고 정의했다. 이 말을 정의하면 완곡어법은 ‘듣는 사람의 기분이 상하거나 거북하게 느낄 수 있는 용어 대신 보다 중립적이거나 부드러운 말로 우회적으로 돌려서 표현하는 방법’을 말한다.

완곡어법에 대한 학자들의 정의를 보면, 임지룡(1992)은 “어느 문화권이나 금기어가 있기 마련인데, 특히 죽음, 질병, 성에 관해서는 직설적인 표현을 피하고 완곡어법을 사용하여 두려움이나 어색함을 누그러뜨린다”고 했다. 홍성호(2000)는 “완곡어법이란 어떤 용어가 충격적이거나 좋지 않게 보일 때, 그것을 다른 단어나 우회적 표현으로 대신하는 표현 방식”이라고 정의했다. 윤희주(2007:193)는 “완곡어법이란 말하기 꺼려지는 표현의 대안이며 이는 체면손실을 피하는 데 사용되는 것”이라고 했다. 심재기(2011:272)는 금기어와 연관하여 완곡어를 설명하면서 “금기어가 일반적인 사람들에게 사용하기 부적절한 말이라면 이런 말을 부드럽게 돌려서 표현하는 말”을 완곡어법이라고 했다. 몽골 학자 데.자야바타르(Д.Заяабаатар)는 완곡어(ээрүүлэл)를 “인간관계의 올바른 형태로서 듣는 사람에게 불쾌감을 주거나 적절하지 않은 거친 말을 부드러운 말로 바꾸어 표현하는 말”이라고 정의했다(Д.Заяабаатар 2022:115).

학자들의 말을 정리해볼 때 완곡어법은 상대방이 듣기 좋게 우회적으로 표현하는 수사법이라 하겠다. 완곡어법은 일반적으로 금기된 행동 또는 금기된 주제를 대체하는 표현법으로 민감하거나 금기된 주제에 대하여 이야기할 수 있도록 해 주고, 화자 또는 청자가 모욕을 당하지 않게 해 준다. 종교에서 말하는 ‘터부(taboo)’나 죽음과 같은 금기로 여기는 주제나 민감하고

자극적인 화제를 주제로 할 때 듣는 사람이나 이와 관계된 사람은 민감하게 느낄 수 있고, 또 모욕감을 느낄 수도 있다. 이때 비유나 환유와 같은 완곡어법으로 우회적으로 표현하면 본래의 의미를 함축하면서도 부드러운 대화를 진행할 수 있고 원만한 대인관계도 유지할 수 있는 장점이 있다.

2. 죽음에 대한 완곡어법과 문화와의 상관성

사람의 사고와 문화는 언어로 표현되는 것이기 때문에 완곡어법을 고찰하면 해당 언어의 문화적 다양성과 특성, 그리고 그 변화를 파악할 수 있다. 인간은 자신이 사용하는 언어에 의해 주변을 인지하므로 언어가 인간, 문화, 세계관과 상호 영향을 주고 받게 한다. 죽음에 대한 완곡어법도 인간의 사고와 정신, 그리고 세계관을 드러내는 거울과 같은 역할을 한다. 따라서 본 연구에서는 한국과 몽골 두 나라의 죽음에 대한 완곡어법이 문화와 어떤 관련이 있는지를 밝히고자 한다.

‘죽음’은 신분이나 지위 고하를 막론하고 모든 사람들이 피해갈 수 없는 두려운 대상이었다. ‘죽음’은 한 사람을 현세로부터 영원히 멀어지게 함과 아울러 가족이나 친지, 그리고 친구들로부터도 이별하게 하는 큰 고통과 상처를 입힌다. 그래서 사람들은 의사소통 과정에서 죽음이라는 단어를 사용하기를 꺼려했고 죽음이라는 말을 직접적으로 사용하는 것은 불길한 행위로 간주했다. 특히 금기어가 발달한 한국이나 몽골에서는 예로부터 죽음이라는 단어를 금기어로 여겼고 죽음을 표현할 때는 가치중립적이거나 부드러운 말로 우회적으로 표현하는 완곡어법이 자주 사용되어 왔다.

종교적인 신앙이나 관념도 두 나라의 완곡어법에 영향을 미쳤다. 원시 시대의 사람들은 이해하기 어려운 자연현상이나 인간의 죽음과 같은 현상을 귀신이나 신령에 의한 현상으로 이해했다. 또 죽음을 인간의 신체와 독립되어 존재하는 영혼의 작용으로 이해하였다. 그래서 사람의 죽음은 육체의 사라짐에 불과하며, 영혼은 그 영향을 받지 않고 본래 존재했던 세계로 회귀하거나 새로운 세계로 떠나는 것으로 여겼다. 이러한 두 나라의 종교 관념은 죽음에 대한 완곡어법에 영향을 미쳤다.

한국과 몽골에 공통적으로 큰 영향을 미친 전통민간신앙으로는 샤머니즘과 불교가 있다. 두 종교의 내세관은 죽음에 대한 완곡어법에 깊은 영향을 미쳤다. 한국어에 ‘저승에 가다’, ‘황천길로 가다’, ‘신선이 되다’라는 말은 이런 민간신앙과 종교사상을 반영하고 있으며, 몽골에도 ‘저 세상으로 가다(Нөгөө ертөнцөд очих)’, ‘극락에 가다(Бурхны оронд явах, Диваажинд очих)’, ‘저승 사자에게 가다(Эрлэгт очих)’와 같은 전통민간신앙과 불교사상을 반영한 완곡어법이 존재한다.

두 나라의 장례풍습을 비롯한 민속 또한 죽음에 관한 완곡어법에 영향을 미쳤다. 한국의 경우, 농경문화를 위주로 한 민족적인 전통으로 인해 토장이주를 이루는 반면, 몽골의 경우 유목과 불교문화를 중심으로 한 암석장이나 매장, 그리고 티베트불교가 들어 온 16세기 이후에는 화장, 조장 등도 유행했다. 한국에서 죽음을 ‘눈에 흙이 들어가다’나 ‘귀토(흙으로 돌아가다)’로



표현하는 반면 몽골에서는 ‘바위 집으로 가다(Хадан гэртээ очих)’나 ‘돌을 베개로 하다(Чулуу дэрлэх)’와 같은 암석장의 현상을 완곡어법으로 표현한다.

3. 죽음에 대한 한국의 완곡어법과 그 특성

언어마다 죽음에 대한 완곡어법이 있다. 동양에서는 한국, 중국, 몽골 세 나라에 특히 완곡 어법이 많이 존재한다. 연구자가 두 나라의 언어사전과 관련 자료들을 조사한 바에 의하면 한국어에는 170여개, 몽골어에는 150여개의 죽음에 대한 완곡어가 있다.

죽음에 대한 한국 완곡어법

한국어에는 죽음에 대한 완곡어법이 많다. 이것은 원래 한국 어휘가 풍부한 것과 관련이 있을 수 있지만 죽음에 대한 한국인의 사고와 문화가 반영된 것이라고 이해할 수도 있다. 유교 사상과 문화의 영향으로 한국인들은 죽음에 대해서 언급할 때 상대방을 배려하여 직접적인 표현보다 예들러 말하는 완곡어법을 선호했다. 또 죽음에 대해서 표현할 때도 돌아가신 분의 나이, 사회적 신분이나 지위를 감안해 존경과 겸양의 마음을 표현함과 함께 그에 맞는 적절한 완곡어법을 사용했다.


죽음에 대한 한국 완곡어법들을 언어사전에 나타난 소재별로 분류하면 다음과 같다.

번호	분류	완곡어법
1	수명	운명하다, 절명하다, 생을 다하다, 생을 마감하다, 생을 마치다, 명을 다하다, 유명을 달리하다, 졸하다, 작고하다, 천수를 다하다, 비명에 죽다, 비명횡사, 생죽음 (13)
2	세상	세상을 뜨다, 세상을 떠나다, 세상을 등지다, 세상과 이별하다, 세상을 하직하다, 별세, 기세, 하세, 사거, 서거, 이승을 떠나다, 영별, 영결, 영격, 영결중천 (15)
3	하늘	귀천, 소천, 하늘 나라로 가다, 승하하다 (4)
4	숨(호흡)	숨지다, 숨을 거두다, 숨을 넘기다, 숨이 끊기다, 숨이 꺼지다, 숨이 끊어지다, 숨이 멎다, 목숨을 잃다, 목숨을 거두다, 목숨을 버리다, 고동을 멈추다, 심장이 멈추다 (11)
5	종교	저승에 가다, 황천길로 가다, 입적, 원적, 입멸, 귀적, 적멸, 멸도, 열반, 해탈, 안학서거, 좌화, 좌탈입망, 폐, 천화, 소천, 선종, 안식, 등선, 반진, 귀서, 인기, 승화, 조천, 화거, 환원 (26)
6	흙	흙으로 돌아가다(귀토) (2)
7	저 세상	저승에 가다, 저 세상으로 가다, 황천으로 가다, 삼도천을 건너다, 북망산에 가다, 천당에 가다, 타계하다, 깨 팔러 가다, 요단강을 건너다, 구천에 가다, 고택골로 가다, 하늘 나라로 가다. 신선이 되다, 유명을 달리하다, 멀리 떠나다,

		장서 (16)
8	가축(동물)	무지개 다리를 건너다, 폐사하다, 고사하다, 용궁 가다 (4)
9	‘잠들다’	잠들다, 영면하다, 눈을 감다, 고이 잠들다, 영원히 잠들다, 장면 (6)
10	‘~이 되다’	고인이 되다, 신선이 되다, 저 세상 사람이 되다, 불귀의 객이 되다, (물) 귀신이 되다, 작고하다 (6)
11	아이, 청년	급사, 급서, 요절, 요망, 단명, 참척, 절식, 하늘의 별이 되다 (8)
12	눈	눈에 흠이 들어가다, 눈을 감다, 눈자위가 꺼지다 (3)
13	왕, 귀족	붕어, 승하, 서세, 서거, 사거, 타계, 기세, 하세, 별세 (9)
14	관	관에 들어가다, 골로 가다, 칠성관을 지다 (3)
15	죽음의 상황 관련	산화, 순교, 순국, 순직, 전사, 전몰, 전망, 쓰러지다, 순장, 순사, 순도, 순절, 취의, 사별, 견배, 급단적 선택, 자진, 졸사, 횡사, 변사, 생죽음, 병사, 병폐, 병몰, 병졸, 압사, 동사, 옥사, 즉사, 아사, 익사, 추락사, 질식사, 객사, 노사, 옥쇄, 단현, 상, 임종 (39)
16	문자만 남음	불록, 하서, 거세, 과서, 사세, 전서, 이세, 여세장사, 연구, 신고, 상명, 망고, 우난, 이난, 우해, 폐명, 운락, 등선, 등하, 빈천, 상빈, 선어, 승천, 안가, 용어, 조락, 척방 천봉, 흥거, 흥서, 흥어 (31)
17	기타	밥 숟가락 놓다, 돌아가다, 돼지다, 목이 날아가다, 개죽음을 당하다, 싸늘해지다, 죽음을 맞이하다 (7)

이것을 그래프로 만들면 다음과 같다.

그림 2. 죽음 관련 한국어 완곡어법 빈도수



죽음에 대한 한국 완곡어법의 문화적 특성

한국의 죽음에 관한 완곡어법을 분류해서 살펴보면 첫째로 ‘저 세상’, 이승의 ‘세상’, ‘수명’, ‘숨’과 같은 소재들의 사용 빈도가 높다는 것을 알 수 있다. ‘저승에 가다’, ‘황천으로 가다’, ‘북망산에 가다’, ‘천당에 가다’, ‘타계하다’, ‘하늘 나라로 가다’ 등과 같이 죽음을 한 곳에서 다른 곳으로 옮겨가는 것으로 표현하는 말이 많은데 이 표현은 종교와 신앙에 따라 달라지는 특성이 있다. 한국의 전통신앙인 샤머니즘(무교)에서 사후세계를 어떻게 인식하였는지에 대해서는 분명하지 않다. 사후 세계를 낙원과 지옥으로 구분하여 인식한 것은 다른 고등 종교와 접촉할 수 있었던 비교적 후대에 이루어졌다. 사



후 세계에 대한 샤머니즘의 원형적인 이해는 막연한 공간적 개념으로서 제시되고 있는 저승이라고 여겨지는 곳이다. 그렇지만 이 저승에 대한 막연한 이해가 다른 종교와의 습합이 이루어지면서 더 발전적이고 구체적인 처소의 개념으로 진행되었는데 그것이 불교나 도교에서 사용되던 ‘극락’, ‘서방정토’, ‘무릉도원’이다(김태곤, 1982, 201-211).

둘째로 죽음과 관련하여 자주 사용되던 완곡 표현은 수명과 관련된 표현이다. ‘생을 다하다’, ‘생을 마치다’, ‘명을 다하다’, ‘유명을 달리하다’, ‘천수를 다하다’, ‘비명에 죽다’ 등이다. 한국의 경우 인간은 삼신에 의해 어린아이가 태어나게 되면 일곱 살까지는 칠성신이, 그리고 그 이후부터는 죽음에 이르기까지 제석신이 인간의 수명을 관장한다고 믿는다. 칠성신은 본래 도교적인 신이며 제석신은 불교에서 33천의 하늘을 맡은 불교의 기능신인데 모두 샤머니즘에 의해 수용된 신이다. 샤머니즘에서는 사람마다 일정한 목숨의 길이가 정해져 있다고 믿는데 이를 ‘천수’라고 한다. 그리고 사람의 이상적인 죽음은 인생의 모든 통과의를 다 거치고 자식을 낳아두고 나이 들어 자식들 앞에서 죽는 것이다. 천수를 다하지 못한 죽음을 ‘비명횡사’라고 하는데 이는 고통을 행하는 중요한 대상이 된다. 수명과 관련된 한국의 완곡어법은 인간의 죽음이 신의 뜻에 달려 있다는 숙명적인 성격을 띠고 있음을 보여준다.

셋째로 한국은 삼국시대부터 율령을 비롯한 관료체제와 불교 사상, 문화면에서 중국의 영향을 많이 받았고 그로 인해 중국 관료제의 영향으로 신분과 지위에 따른 죽음 관련 완곡어법들이 발달했으며 조선 시대에는 성리학에 따른 유교의 영향으로 연령에 따른 높임을 나타내는 존칭어들이 다양하게 발달했다는 것이다. 왕의 죽음은 마치 산이 무너진 것처럼 나라의 제일 큰 비통함을 나타내는 ‘붕(崩)’이라는 단어를 사용했으며, 세자를 비롯한 왕족의 죽음에는 비슷한 뜻을 가진 ‘홍(薨)’이라는 단어를 사용했다. 그래서 왕이 죽으면 ‘붕어’, ‘승하’라고 했으며, 세자를 비롯한 왕족들의 죽음은 ‘홍서’, ‘홍어’라 했다. 반면 신하나 일반인이 죽으면 ‘졸’이나 ‘망’, ‘사’를 사용했다.

넷째로 한국의 완곡어법에는 높고 낮음이 있어서 ‘사망(死亡)하다’가 가장 일반적이고 보편적인 표현이라면, ‘별세(別世)하다’, ‘영면(永眠)하다’나 ‘작고(作故)하다’, ‘타계(他界)하다’는 나이나 신분이 높거나 사회적 존경을 받는 사람에게 존칭어로 사용한다. 그리고 ‘서거(逝去)하다’는 대통령이나 국무총리와 같은 최고위직 인사의 죽음에만 사용한 가장 높은 존칭 표현이다. ‘영면하다’는 ‘영원히 잠들다’는 말이며, ‘작고하다’는 현재뿐만 아니라 ‘우리 아버지는 3년 전에 작고하셨다’와 같이 이미 돌아가신 분에게도 사용하는 말이다. 오늘날에는 ‘서거하다’라는 말을 사용한다. ‘타계하다’는 ‘이 세상을 떠나 다른 세상으로 갔다’는 것을 뜻하는데 ‘서거(逝去)하다’라는 말을 사용할 정도의 지위가 높은 분이 아니더라도 사회에 공헌한 잘 알려진 사람에게 사용한다는 면에서 ‘별세하다’와는 차이가 있다. ‘별세하다’는 ‘세상을 떠나 이별하는 것’을 나타내며 나이 많은 어른들의 죽음을 표현하는 완곡어법이

다(이갑남, 2017:140). 한편 죽음을 대신하는 급이 낮은 완곡어법으로 ‘가다’라는 말이 있는데 이는 죽음을 비하하여 사용하는 말이다. 그래서 “돌아가(시)다”를 사용하는 것이 더 친근하면서도 존칭 표현이 된다. 반면 “골로 가다”¹, “웨지다”라는 표현은 사용하기에 부적절하고 상대방을 비하하는 말이라 하겠다. 어른이 죽으면 ‘돌아가(시)다’라고 말하며, 때로는 ‘긋기다’라는 순수한 우리말을 사용하기도 한다. ‘돌아가다’라는 말의 뜻은 분명하게 밝혀진 것은 아직까지 없지만 세 가지 면에서 살펴볼 수 있다. 먼저는 사전적 정의로 ‘숨이 끊어져 생명을 잃은 상태가 된 것’을 뜻한다는 것이다. 또 하나는 ‘먼저 온 것으로 다시 돌아간다’는 뜻인데 이것은 자연에서 와서 자연으로 돌아간다는 것을 의미할 수 있고, 불교의 윤회 사상처럼 또 다른 세상으로 돌아간다는 것을 의미한다. 마지막으로 어원을 ‘토(土)로 가다’로 보는 것으로 원래의 집 즉, 태어나기 전의 고향인 흙으로 되돌아간다는 의미한다는 것이다. 이를 정리해보면 ‘돌아가시다’는 말에는 자연에서 와서 자연으로 돌아간다는 한국인의 전통 신앙이 숨겨져 있음을 보게 된다.

다섯째로 죽음에 대한 한국 완곡어법들은 한자와 우리 말의 합성어로 되어있는 형태가 많은 것이 특징이다. 앞에서 살펴 본 ‘별세(別世)하다’, ‘영면(永眠)하다’나 ‘작고(作故)하다’, ‘타계(他界)하다’, ‘서거(逝去)하다’와 같은 한자와의 합성어가 많다. 이것은 죽음에 대한 완곡어법이 중국의 영향을 받아 한자어를 수용한 것과 그 한자어가 자연스럽게 한국에 토착화된 것임을 보여준다.

여섯째로 한국어에는 ‘죽음의 상황’과 관련한 다양한 완곡어법이 존재한다. 연구자가 조사에 의하면 40개에 가까운 가장 많은 완곡어법이 ‘죽음의 상황’과 관련된 표현이었다. 군인이 죽으면 꿈이 많은 젊은이가 그 뜻을 피우지 못하고 죽는 것을 마치 꽃잎이 그 꽃망울을 피우지 못하고 떨어져 죽는 것과 같다고 해서 ‘산화’라고 말한다. 어떤 사람이 자신의 신앙이나 종교를 위해 봉사하다가 죽으면 ‘순교’, 조국을 지키기 위해 힘쓰다가 죽으면 ‘순국’, 공무 중에 죽으면 ‘순직’, 정의와 마땅히 해야 할 일을 이루기 위해 사망한 경우에는 ‘순도’, 절개를 지키기 위해 죽으면 ‘순절’, 군인이 전쟁 중에 싸우다가 죽으면 ‘전사’, ‘전몰’, ‘전망’ 이라고 표현한다. 한편 아내가 죽으면 현악기의 줄이 끊어진 것과 같다고 하여 ‘단현’이라고 한다. 가축의 경우에는 ‘죽다’, ‘폐사하다’라는 단어를 많이 사용한다. 하지만 집에서 기르는 개나 고양이와 같은 애완동물이 죽었을 경우에는 ‘무지개 다리를 건너다’, 물고기 종류는 ‘용궁 가다’라고 표현하는데 이는 좋은 곳으로 가기를 염원

¹ “골로 가다” 라는 말의 뜻에는 대체적으로 세 가지 설이 있다.

- ① 가장 많이 지지하는 설은 ‘골’이 과거 서울의 매장지였던 서울시 은평구 신사동에 해당하는 마을의 옛 이름인 ‘고택골’을 가리키며 골은 고택골의 준말이라는 설이다.
- ② ‘골’은 ‘곡’이라는 말에서 나왔으며 이것은 골짜기나 산기슭을 뜻한다는 말이다.
- ③ ‘골’은 ‘널’이나 ‘관’을 뜻하며, 따라서 ‘골로 간다’는 말은 ‘관으로 들어간다’는 것을 의미한다는 설이다.



하는 사람의 소망이 담겨 있음을 알 수 있다. 젊은 나이에 갑작스런 죽음을 맞을 때는 ‘급사(急死)’, 이에 대한 존칭어는 ‘급서(急逝)’라고 표현한다. 요망(夭亡), 요절(夭折)도 주로 젊은 사람이 갑작스럽게 죽었을 때 사용하는 완곡어법이다. 요(夭)나 절(折)은 주로 갑작스런 죽음을 나타낸다. 또 젊은 사람이 조부모나 부모보다 먼저 죽는 경우에는 ‘참척(慘慼)’이라고 말하는데, 이는 수명을 다 누리지 못하고 죽은 경우로 불효라고 여기기에 ‘악상(惡喪)’이라고도 한다.

일곱째로 한국어에는 종교와 관련한 다양한 완곡어법들이 많다. 불교에서는 죽음을 ‘열반(涅槃)’, ‘적멸(寂滅)’, ‘입적(入寂)’, ‘귀적(歸寂)’, ‘입멸(入滅)’ 등으로 표현한다. ‘열반’은 산스크리트어(Sanskrit) ‘니르바나(Nirvana)’의 음차어로서 일체의 번뇌에서 벗어나 완벽한 깨달음의 경지에 들어간다는 뜻이 있으며 석가모니를 비롯한 고승의 죽음을 가리킬 때 사용한다. 적멸도 바람이 불을 끄듯이, 지혜로 번뇌의 불꽃을 소멸하여 모든 번뇌가 사라진 상태를 말한다. 입적과 귀적은 승려의 죽음을 완곡하게 표현하는 말로서 열반에 들어감을 의미한다. 입멸은 번뇌와 육체가 함께 소멸된 평온한 상태를 의미한다. 천주교에서는 세례를 받은 후 큰 죄를 짓지 않고 죽은 신자의 죽음을 선종이라 한다. 이는 착하게 살고 복되게 삶을 마친다는 ‘선생복종(善生福終)’이란 말의 줄임말이다. 개신교에서는 ‘하늘에 불려가다’, ‘하나님의 부름을 받다’라는 의미의 ‘소천(所天)’을 많이 사용하며, 천도교에서는 ‘본래의 자리로 돌아가다’라는 뜻의 ‘환원(還元)’을, 도교에서는 ‘진리로 돌아간다’는 뜻의 ‘반진(反眞)’, ‘신선이 되라’라는 의미의 ‘등선(登仙)’, ‘사람의 몸에 날개가 돌아 하늘로 날아가 신선이 된다’는 의미의 ‘우화(羽化)’, 귀천과 같은 의미의 ‘귀서(歸西)’, ‘숨을 거두다’는 의미의 인기(咽氣), ‘다른 것으로 변하여 간다’는 의미의 ‘화거(化去)’를, 정교회에서는 평안을 나타내는 ‘안식’을, 그리고 대종교에서는 도가 높은 사람의 죽음을 가리켜 ‘하늘로 되돌아가다’라는 의미의 ‘조천(朝天)’이라는 완곡어법을 사용한다.

이처럼 죽음에 대한 한국 완곡어법에는 죽은 자의 신분이나 지위, 연령에 따라 그 용어가 다양하며, 존칭어의 발달에 따라 사회적 지위나 연령에 따른 완곡어법에도 그 낮고 높음이 존재한다. 또 죽음의 상황과 종교에 따른 다양한 완곡어법들이 존재한다.

4. 죽음에 대한 몽골의 완곡어법과 그 특성

몽골어에도 완곡어법이 많다. 이것은 빌정이나 재앙과 같은 두려움이나 위험한 현상에 대해 직접적으로 말하는 것을 꺼려하는 금기어와 함께 이를 완곡하게 표현하는 완곡어법이 발달한 데서 기인한다. 대표적인 예로 신성한 동물로 여기는 늑대나 전염병과 같은 금기어를 예들려 부드럽게 표현하는 완곡어법을 들 수 있다.

죽음에 대한 몽골 완곡어법

몽골어에는 죽음이나 종교적 신앙과 관련하여 일부 단어들을 사용하기를

꺼려하고 이를 완곡하게 표현하는 단어들이 많다. 몽골어에 나타난 죽음 관련 완곡어법을 주제에 따라 분류하면 다음과 같다.


번호	분류	완곡어법
1	수명(Хүний настай холбоотой)	Нас барах, Нас нөгчих, Нас нөхцөх, Нас эцэслэх, Насан эцэс болох, Нас элэгдэх, Нас дүүрэх, Насан хутга олох, Насны тоо гүйцэх, Насны нар гарах, Нас өөд болох, Амь нас нь юүтэх, Насны хэмжээ болох, Насан зүг болох, Хоногийн тоо гүйцэх, Хоногийн тоо дуусах, Ус уух хоногийн тоо гүйцэх, Амьд явах хоногийн тоо гүйцэх (18)
2	세상(Орчлон, хорвоо)	Орчлонгоос буцах, Орчлонгоос одох, Орчлонгоос тэвчих, Орчлонгоос салах, Орчлонгоос халин одох, Хорвоогоос хэлтрэх, Хорвоогоос халих, Хорвоогоос буцах, Хорвоо дуусгах, Хорвоо өнгөрөх, Хорвоо нөгчих (11)
3	하늘(Тэнгэр)	Тэнгэрт одох, Тэнгэрт дэвших, Тэнгэр болох, Тэнгэр харах, Тэнгэрт залрах, Тэнгэрт халих, Тэнгэрт морилох, Тэнгэрт шингэх, Есөн тэнгэрт гарах, Хан тэнгэрийн оронд залрах (10)
4	숨(Амьсгал)	Амьсгалын/Амьсгааны/ тоо гүйцэх, Амьсгал татах, Амьсгал/Амь/ хураах, Амьсгал тасрах, Амьсгал зогсох, Амьсгал тавих (8)
5	종교(Шашин)	Төрөл арилжих, Төрөл хаягдах, Нирваан дүр үзүүлэх, Төөргөө хайх, Жанч халах, Шарил тайлах, Шамбалын оронд очих, Бурхны оронд явах, Нөгөө тивд очих, Мөнхийн орондоо явах, Диваажинд очих, Диваажинд залрах, Үнэний газарт очих, Эрлэгт очих, Эрлэгт явах, Эрлэгт залрах, Эрлэг аваачих (17)
6	‘~되다’(Болох)	Бурхан болох, Өөд болох, Тэнгэр болох, Үгүй болох, Биш болох, Таалал болох, Нирваан болох, Зөв эс болох, Бүрлээч болох, Нэг тийшээ болох, Зовлого болох, Зулын гол болох, Эцэс болох, Хохимой толгой болох, Мордох болох, Насны хэмжээ болох, Насан зүг болох, Нүднээс далд болох, Загасны хоол болох, Хон хэрээний идэш болох (20)
7	шороо(Шороо)	Шороо бургих, Шороонд орох, Шороо пурпийх, Хүйтэн шороо дэрлэх, Гүзээ шороодох (5)
8	저 세상(Нөгөө ертөнц)	Нөгөө ертөнцөд очих, Нөгөө ертөнцөд шингэх, Амгалангийн оронд явах, Мөнхийн орондоо явах, Диваажинд очих, Диваажинд залрах, Үнэний газарт очих, Бурхны оронд явах, Нөгөө тивд очих, Эрлэгт очих, Эрлэгт явах, Эрлэгт залрах, Эрлэг аваачих (13)
9	동물(Мал амьтан)	Мажийх, Цэглэх, Хорогдох, Юүдэх, Хиарах (5)
10	‘잡자다’	Нэг мөсөн унтах, Сэрэхгүйгээр унтах, Үүрд унтах, Мөнх



	(Унтах)	нойрсох, Үүрд нойрсох (5)
11	‘돌아가다’ (Халих)	Ертөнцөөс халих, Орчлонгоос халих, Хорвоогоос халих, Нартаас халих, Тэнгэрт халих, Сүнс нь халих, Сүүдрээс халих, Алтан дэхийгээс халих (8)
12	‘보다’, ‘보이다’ (Үзэх, үзүүлэх)	Мөнх бусыг үзэх, Ертөнцийн мөнх бусыг үзүүлэх, Орчлонгийн мөнх бусыг үзүүлэх, Ертөнцийн мөнх бусын хувирлыг үзүүлэх (4)
13	유아, 청년, 노인 (Хүүхэд, залуу, хөгшин хүн)	Алдах\хүүхэд\, Гээх\хүүхэд\, Эндэх\хүүхэд\, Чад хийх\залуус\, Сажлах\хөгшдийн тухай\, Сажилж орхих (6)
14	산의 양지 (Энгэр)	Энгэр газарт гарах, Энгэр гэртээ залрах, Энгэрт гарах, Энгэр газарт залрах, Энгэр газар дэрлэх, Энгэр газрын дуудлага (6)
15	그늘(Сүүдэр)	Сүүдрээ дэрлэх, Сүүдрээс халих, Сүүдрээ дарж унах, Сүүдэр ташаарах, Сүлд гэгээн бие сүүдэр болж одох (5)
16	신체(몸) (Бие)	Бие барах, Бие нурах, Бие эцэслэх (3)
17	바위, 관 (Чулуу хад, авс)	Хадан гэртээ харих, Хадан гэртээ очих, Чулуу дэрлэх, Үнэний чулуу дэрлэх, Хад түших, Авсанд орох (6)
18	‘가다’ (Явах)	Бүр мөсөн явах, Хол явах, Уртын аянд явах, Буцаж ирэхгүйгээр явах (4)
19	기타 (Бусад)	Өнгөрөх, Амьдралаа дуусгах, Мөнхийн амирлангуйгаа олох, Үүд далдлах, Талд хаягдах, Таван ухаан нь тархах, Егүүтэх, Талийх, Үлтэх, Таалал барих, Сүнс нь тонилох, Далд орох (12)

Илгээг графикт харуулбал дараах байдал гарна.

Грэм2. Зүрхсн гэрлэн зүрхсн мөнгөл гэрлэнгэрлэн биндус



죽음에 대한 몽골 완곡어법과 문화적 특성

첫째로 몽골 사람들은 사람이 죽으면 보통 “нас барах, нас нөгчих(돌아가시다), насан хутга олох(천수를 다하다), насны тоо гүйцэх(수명을 다하다)” 등과 같이 ‘사람의 수명’과 관련한 완곡어법을 많이 사용한다. 이 완곡어법은 사람의 수명이 하늘이 정한 운명과 연관이 있다는 몽골의 문화와 사고를 반영한다.

몽골인들은 인간을 자연의 일부로 보며 동, 식물이나 산, 바위와 같은 무생물, 또 기로서 존재하는 자연의 배후에는 보이지 않는 힘이 존재하며 이것은 인간의 정신적, 물질적 삶에 유기적으로 연결되어 있다는 우주적 자연관을 가지고 있다. 또 몽골의 전통적 민간신앙인 샤머니즘의 인간관을 보면 인간의 생사화복이나 흥망성쇠는 인간 스스로의 노력에 의해 좌우되기 보다는 신령의 뜻에 달려 있다는 운명적인 인간관을 피력한다. 샤머니즘에서 인간은 신에 대해 의존적일 수밖에 없는 나약한 존재이다. 이런 관점에서 죽음은 하늘에서 정해준 한 사람의 운명의 시간이 다했음을 나타낸다.

둘째로 죽음에 대한 몽골어에는 사람의 수명 외에 ‘орчлон, хорвоогоос одох(세상을 떠나다)’, ‘Орчлонгоос буцах(세상에서 돌아가다)’, ‘Хорвоо өнгөрөх(세상을 뜨다)’, ‘Хорвоо дуусгах(세상을 끝마치다)’, ‘Хорвоо нөгчих(세상을 하직하다)’와 같은 세상과 관련한 완곡어법들이 많다.

몽골 사람들이 ‘세상을 떠나는 것’으로 죽음을 표현한 것은 죽음이 사람을 한 장소에서 다른 장소로 옮겨가게 하는 현상으로 이해하고 있음을 보여준다. 전통적으로 몽골인들은 인간을 육체와 영혼의 이원적 결합체로 보며, 육체는 일정한 기간에 이르면 사멸하나 영혼은 영원하며 살아있는 사람과 동일한 인격을 갖는다고 여긴다. 몽골 사람들은 영혼을 공중을 자유롭게 떠다니며 시간이나 공간의 제약을 받지 않고 타계로 여행하는 것으로 생각했으며 이러한 사고가 완곡어법에 표현되었음을 알 수 있다.

셋째로 죽음에 대한 몽골어에는 ‘Тэнгэрт одох(하늘로 떠나다)’, ‘Тэнгэрт дэвших(하늘로 올라가다)’, ‘Тэнгэрт халих(하늘로 돌아가다)’, ‘Тэнгэр болох(하늘이 되다)’와 같은 하늘과 관련한 완곡어법들도 적지 않다. 이것을 하늘을 숭배하는 몽골민간신앙과 사람이 죽으면 보르향이 되어 위로 올라간다는 몽골인들의 전통적 신념과 관련이 있다. 몽골에서 사람이 죽을 때 ‘Бурхан болсон(보르향이 되었다)’, ‘Өөд болсон(높이 오르게 되었다)’ 라고 말하는 것은 사람의 죽음을 하늘과 관련하여 사용하는 대표적인 예이다. 이안나는 몽골 사회에 왕권이 강화되면서 하늘숭배 사상과 함께 인간의 영혼도 죽으면 하늘로 올라가는 영혼의 관념이 강해지게 되었다고 말한다(이안나, 2010, 97).

죽음에 대한 몽골 완곡어법의 네 번째 특징으로는 “үгүй болох, биш болох(없어지다)”, ‘таалал болох(마지막이 되다)’, ‘нирваан болох(열반이 되다)’, ‘Мордох болох(말을 타고 떠나게 되다)’, ‘Насны хэмжээ болох(수명을 다하다)’, ‘Нүднээс далд болох(눈에서 보이지 않게 되다)’와 같이 “болох(~이 되다)”와 관련된 완곡어법이 많다는 것이다. 이것은 죽음을 “어떤 변화된 상태로의 변화”로 이해하는 몽골 사람들의 사고를 보여준다. 고대 몽골인들은



사람이 죽으면 어딘가로 가는 것이라고 생각했다. 고대 몽골에서 순장을 할 때 주인의 말을 부장품으로 넣은 것은 주인이 다른 세상으로 이동할 때 그 말을 타고 가기에 말이 주인에게 봉사한다고 여겼기 때문이다. 순장 문화는 인간의 사후에 영혼이 이 땅에서처럼 계속 삶을 영위해 간다는 세계관적 특성을 보여준다(이안나, 2010, 92-94).

다섯째로 종교와 관련해서는 불교와 연관된 완곡어법이 많다. 앞에서 살펴본 것처럼 “Төрөл арилжих(업에 따라 윤회하다)”, “Төрөл хаягдах(업을 지우다), Нирваан дүр үзүүлэх(열반하다), Төөргөө хайх(자기 명을 찾다), Шарил тайлах(육체를 벗다)” 등과 같은 불교 세계관과 관련된 완곡어법이 많다. 16세기 말부터 티베트불교는 몽골 전 영역에 걸쳐서 그 영향을 확대하였으며 현재까지 몽골의 주된 종교로 자리매김을 하고 있다. 몽골의 장례를 비롯한 주요 의례들은 티베트불교 형태로 바뀌었는데 종교적 영향력으로 인해서 죽음 관련 언어 또한 불교 형태로 정착된 것이다.

여섯째로 죽음 관련 몽골 완곡어법 가운데 몽골에 두드러지는 특징 가운데 하나는 암석(바위)장과 관련된 것이다. Хадан гэртээ харих(바위 집으로 돌아간다), Хадан гэртээ очих(바위 집으로 가다), Чулуу дэрлэх(돌을 베다), Үнэний чулуу дэрлэх(진리의 돌을 베다), Хад түших(바위에 의지하다) 등의 완곡어법은 고대 몽골에 행해졌던 암석장의 문화가 죽음 관련 완곡어법으로 정착된 것으로 보인다. 죽음이 가까운 사람이 자신의 삶을 얘기할 때 자주 쓰는 몽골의 유명한 속담 중의 하나가 “Ханан гэрээсээ холдож, Хадан гэртээ очих(계르 집에서 떠나서 바위 집에 가다)”이다. 이 속담에는 바위(암석)장의 완곡어법을 잘 보여준다.

일곱째로 몽골 사람들의 죽음 관련 완곡어법 중의 독특한 부분은 죽음을 인생이 영원하지 않음을 보여준다고 표현한다는 것이다. ‘Мөнх бусыг үзэх(영원하지 않음을 보다)’, Ертөнцийн мөнх бусыг үзүүлэх’, Орчлонгийн мөнх бусыг үзүүлэх, Ертөнцийн мөнх бусын хувирлыг үзүүлэх(이 세상이 영원하지 않음을 보이다) 등이 그 예이다.

여덟째로 몽골에는 죽은 사람을 햇빛이 비치는 산의 양지에 묻는 풍습과 연관된 완곡어법이 많다. ‘Энгэрт гарах, Энгэр газарт гарах(양지바른 곳으로 가다)’, 그 높임말인 ‘Энгэр газарт залрах(양지바른 곳으로 가시다)’, ‘Энгэр гэртээ залрах(양지바른 집으로 가시다)’, Энгэр газар дэрлэх(양지바른 곳에 묻히다)’, ‘Энгэр газрын дуудлага(양지로 부름받다)’ 등의 표현이 그 예이다.

아홉째로 죽음을 그늘이나 그림자, 나이에 비유하여 표현하는 것도 죽음 관련 몽골 완곡어법의 특징이다. 그 예로 ‘Сүүдрээ дэрлэх(그늘에 묻히다)’, ‘Сүүдрээс халих(그림자가 있는 세상에서 떠나다)’, ‘Сүүдрээ дарж унах(나이가 다 되어 떠나다)’, ‘Сүлд гэгээн бие сүүдэр болж одох(위풍당당하던 몸이 그림자 되어 떠나다)’ 등이 있다.

열째로 몽골비사를 보면 죽음과 관련된 완곡어법이 신분이나 지위에 따라 다르게 나타나는데 칭기즈칸의 경우 ‘Тэнгэрт халих(승하하다)’, 테무친의 아버지 예수게이, 테무친의 아들 주치와 같은 왕족이나 귀족들은 ‘Нас

нөгчих(운명하다)', 테무친의 조상이나 샤먼의 죽음은 'Үгүй болох(돌아가시다)', 일반인들이나 군인들은 'Үхэх(죽다, 사망하다)'를 사용했다(김 Ги Сонь, 2013). 이것은 중세 몽골제국시대에도 신분이나 지위 고하에 따라 구별된 완곡어를 사용했음을 보여준다. 오늘날에도 신분이나 지위가 높은 사람에게는 'Таалал төгсөх(서거하다)', 'Ертөнцийн мөнх бус үзүүлэх(세상의 덧없음을 보이다)', 'Тэнгэрт дэвших(타계하다)' 등과 같은 한국의 높임말에 해당하는 완곡어법을 사용한다. 그리고 유목문화인 몽골에는 'Мажийх, цэглэх, хорогдох, чад хийх'와 같은 가축이나 짐승의 죽음과 관련된 여러 완곡어법들이 있는 것도 그 특징이다.

5. 죽음에 대한 한국과 몽골 완곡어법의 문화적 특성 비교

죽음에 관한 두 언어의 완곡어법을 고찰하면 두 문화의 독특성, 그리고 유사점과 차이점을 알 수 있다. 먼저 한국과 몽골의 죽음 관련 완곡어법에는 다양하고 많은 유사점을 발견할 수 있다.

유사점

두 나라의 죽음에 대한 완곡어법을 보면 유사한 부분이 많은데 이것은 두 나라의 언어적 사고와 문화가 유사함을 보여준다.

가) 수명과 관련해서 '생을 마치다(Амьдралаа дуусгах)', '생을 다하다(Нас дүүрэх)', '수명이 다하다(Насан эцэс болох)', '수명을 다하다(Насны тоо гүйцэх)', '천수를 다하다(Насны тоо гүйцэх)'라는 표현이 유사한다. 이것은 두 문화가 인간의 운명이 하늘이나 신령의 뜻에 달려있다는 숙명적 인간관을 가지고 있음을 보여준다.

나) 숨과 관련해서는 '숨을 거두다(Амьсгал хураах)', '숨이 끊기다(Амьсгал тасрах)', '숨이 멎다(Амьсгал зогсох)'등이 유사한 표현이다. 저 세상과 관련해서는 '저승에 가다(Нөгөө ертөнцөд очих)', '극락에 가다(Диваанжинд очих)', '하늘나라로 가다(Бурхны оронд явах)' 등이 있다.

다) 세상과 관련해서는 '세상을 뜨다(Хорвоо өнгөрөх)', '세상과 이별하다(Орчлонгоос салах)', '세상을 떠나다(Орчлонгоос одох)', '세상을 하직하다(Орчлонгоос халин одох)', '이승을 떠나다(Хорвоогоос хэлтрэх)' 등이 비슷하다. 이것은 두 나라가 인간의 죽음이 그대로 끝이 아니며 인간의 영혼은 이 세상에서 저 세상으로 옮겨간다는 내세관을 가지고 있음을 보여준다.

라) '~이 되다'와 관련해서는 '작고하다(Бүрлээч болох)', '고인이 되다(Талийгаач болох)', '신선이 되다(Тэнгэр болох)', '물 귀신이 되다(Загасны хоол болох)', '저 세상 사람이 되다(Нэг тийшээ болох)' 등이 비슷한 표현이다. 이는 죽음이 실제 인간의 삶에 본질적 변화를 가져다 준다는 것을 보여준다.

마) '잠자다'는 '영원히 잠들다(Мөнх унтах)', '영면하다(Мөнх нойрсох, Үүрд нойрсох)', '눈을 감다(Нүд аних)'라는 표현이 유사하다. 이것은 두 나라가 모두 죽음을 '잠을



자는 것'이라는 형상학적 인식을 하고 있음을 보여준다.

바) 높임을 뜻하는 완곡어법으로는 관련해서는 '별세하다', '서거하다'(Таалал болох, Таалал төгсөх)' 등이 있으며 그 외에 '영별'(Сажлах, Сажилж орхих), '불귀의 객이 되다(Буцаж ирэхгүйгээр явах)' 등의 표현이 유사하다. 두 나라는 다양성에 있어서는 차이가 있지만 신분과 사회적 지위에 따른 고유한 완곡어법을 가지고 있다. 그리고 죽음을 산 자와 이승과의 영원한 분리라는 비슷한 사고를 가지고 있음을 보여준다.

사) 한국과 몽골에 공통적으로 큰 영향을 미친 종교는 불교와 샤머니즘이다. 한국의 '저승에 가다', '황천길로 가다', '신선이 되다'라는 완곡어법은 불교와 도교 사상을 반영하고 있으며, 몽골의 '업보에 따라 윤회하다(Төрөл арилжих, Төрөл хаягдах)', '열반하다(Нирваан дүр үзүүлэх)', '육체의 번뇌를 벗다(Шарил тайлах)', '저승 사자에게 가다(Эрлэгт очих)' 등의 완곡어법은 불교 사상을 반영한다. '열반하다(Нирваан болох)', '열반의 경지에 오르다(Нирваан дүр үзүүлэх)', '극락에 가다(Диваажинд залрах)' 등의 불교적 완곡어법을 공유하는 것이 그 사례라 하겠다.

차이점

두 나라의 죽음에 관한 완곡어법에는 여러 차이점도 존재한다. 이것은 생활양식과 문화의 차이에 따른 언어 표현의 차이에서 오는 것이라 할 수 있다.

1) 몽골의 경우 불교 관련 표현이나 바위나 돌과 관련된 표현, 그리고 가축이나 동물 관련 완곡어법들이 상대적으로 많은 편이다.

가) 불교 관련 표현이 많다. Төрөл арилжих, Төрөл хаягдах, Төөргөө хайх, Жанч халах, Шарил тайлах 등과 같은 다양한 표현이 있다.

나) 바위, 돌과 관련된 완곡어법이 많다. Хадан гэртээ харих, Хадан гэртээ очих, Чулуу дэрлэх, Хад түших, Шороо бургих, Шороонд орох, Шороо пурпийх, Шороо хөдлөх 등이 있다.

다) 세상이 영원하지 않음을 보이다라는 표현이 있다. 'Мөнх бусыг үзэх', 'Ертөнцийн мөнх бусыг үзүүлэх', 'Орчлонгийн мөнх бусыг үзүүлэх', 'Ертөнцийн мөнх бусын хувирлыг үзүүлэх' 등이 그 예이다.

라) 산의 양지 바른 곳에 묻는 장례 풍습과 연관된 완곡어법이 많다. 'Энгэрт гарах, Энгэр газарт гарах, 'Энгэр газарт залрах', 'Энгэр гэртээ залрах' 등이다.

2) 한국의 경우는 완곡어법에 있어서 다음과 같은 몇 가지 특성이 있다.

가) 관료적 사회, 유교적 영향에 따라 죽은 사람의 신분이나 사회적 지위, 그리고 연령에 따라 다양한 존칭 표현들이 존재한다. 예) 죽다, 사망하다 -> 돌아가시다, 별세하다 -> 타계하다 -> 서거하다

나) 종교에 따라 각각 다른 다양한 완곡어법이 있다. 예) 불교(열반, 입적),

기독교(소천), 천주교(선종), 동방정교(안식), 도교(반진, 등선) 등.

다) 중국의 영향과 한자어의 유입에 따른 한자어와 우리말의 합성어 표현이 많다. 예) 별세하다, 타계하다, 서거하다, 타계하다, 운명하다, 순직하다, 임종하다 등

라) 죽음의 상황에 따른 다양한 표현이 있다. 예) 산화, 순교, 순국, 순직, 순절, 순도, 전사, 전몰, 전망, 요절 등.

마) 국왕 중심의 왕권사회의 영향으로 왕이나 왕족, 귀족의 죽음에 관한 다양한 완곡어법이 있었으며 현재는 사용하지 않는 표현들이 많다. 예) 붕, 붕어, 승하, 용어, 천봉, 홍거, 홍서, 홍어 등.

결론

‘죽음’에 대한 한국과 몽골, 두 나라의 완곡어법들을 사전을 중심으로 비교, 고찰했다. ‘죽음’에 대한 몽골 완곡어법에 나타난 문화적 특성은 사람의 죽음은 하늘이 정한 숙명에 따라 이루어진다는 자연적 세계관, 숙명적 인생관을 가지고 있다는 것과 죽음이 사람을 한 장소에서 다른 장소로 옮겨가게 하는 현상으로 이해하고 있음을 고찰했다. 또 몽골 사람들은 죽은 사람의 영혼이 하늘로 올라간다는 전통적 신앙을 가지고 있음과 오랜 역사 속에서 불교적 내세관이 완곡어법 속에 스며있음을 살펴보았다. 특별히 바위(암석)장과 관련된 완곡어법이나 인간의 유한함을 나타내는 완곡어법 등을 자연에 순응하며 살아가는 것이 인간의 운명이라는 자연적 우주관을 보여준다.

‘죽음’에 대한 한국 완곡어법에 나타난 문화적 특성을 보면 사람마다 ‘천수’라는 정해진 삶의 년 수가 있음을 인식하며 운명적 인생관을 가지고 살았으며, 중국 관료제와 유교 사상의 영향으로 신분과 지위에 따른 아주 다양한 완곡어법들이 발달했음을 알 수 있다. 또 완곡어법에 높고 낮음이라는 다양한 계층어와 존칭 표현이 있음도 살펴보았다. 그리고 어떠한 상황에서 죽음을 맞이했느냐에 따라서 다양한 완곡어법이 있는데 이것은 죽음을 예의와 공손함으로 대하고자 하는 한국인의 전통적 가치관과 연관됨을 살펴보았다.

두 나라는 불교와 샤머니즘이라는 공통적 신앙체계에 따른 유사한 완곡어법들이 존재하며, ‘숨이 끊기다’, ‘수명을 다 하다’, ‘이승을 떠나다’, ‘저 세상으로 가다’, ‘영원히 잠들다’ 등 유사한 완곡어법이 존재함과 아울러 장례의 차이, 문화적 차이에 따른 차이점도 다양함을 고찰했다.

앞으로 두 나라의 죽음에 관해 금기어와 완곡어와의 상관성, 완곡어법에 나타난 상징 비교 등과 같은 더 폭 넓은 연구들이 더 활발히 이루어지기를 기대한다.



참고문헌

- Заяабаатар Д. (2022), Монгол хэл судлалийн үгийг сан, тжга зүй, Х боть, Дүгэржавын Б. (2006), Монгол хэлний үгийн сангийн утга зүй. УБ.
 Арьяасүрэн Ч. (2000), Монгол ёс заншлын их тайлбар толь.УБ: ЭРДЭМ.
 Монгол хэлний их тайлбар толь, <http://www.mongoltoli.mn/>
 국립국어원 표준국어대사전, <https://stdict.korean.go.kr/main/main.do>
 김기선 (2013), "몽골비사에 나타나는 중세 몽골유목민의 완곡어법 연구-성, 인명, 배변,
 죽음에 관한 어휘를 중심으로-" 동아시아고대학회(30) : 391-415.
 김태곤(1982), 한국 무속도록, 서울: 집문당.
 이안나(2010), 몽골의 민간신앙 연구. 서울: 한국문화사.
 이안나 (2007), "금기를 통해 본 몽골의 민속: 생활 예법과 의례를 중심으로"
 중앙대학교 한국문화유산연구소(12).
 성비락 (2003), “한·몽 언어문화적 특성 비교 연구: 언어사고 방식을 중심으로”, 서울대학교 국어교육연구소 국어교육연구, Vol.12, pp. 351-384.
 김억조 (2019), “‘죽음’을 나타내는 완곡어의 인지언어학적 해석”, 한민족어문학 83권 pp.79-102.
 이갑남 (2017), “중한 금기어와 완곡 표현 대조 연구: 죽음과 질병 관련 어휘를 중심으로” 동아인문학 Vol.41, pp.125-153 .
 채춘옥 (2014), “한국어와 중국어에서 사용되는 죽음에 관한 완곡어의 대조 분석”, 사회언어학22, 한국사회언어학회, pp.255-279.

Хураангуй

Монгол солонгосын үгийн санд хатуу ширүүн үг, илэрхийллийн зөөлөн дүйцэхүйц үгс нь ярилцагчтай харилцах найрсаг уур амьсгалыг хадгалах зорилгоор эерүүлэлийг өргөн хүрээтэй хэрэглэдэг. Түүний нэг жишээ бол үхлийн тухай илэрхийлэл юм. Судлаач миний бие Монгол солонгосын үхлийн тухай эерүүлэх ёсыг харьцуулж судалснаар хоёр улсын хэл соёлын өвөрмөц талуудыг нээн илрүүлэхийг зорилоо.

Үхлийн тухай Монголын эерүүлэх үг хэллэгийн онцлог Монголчууд ер нь хүн үхсэнийг “нас барах, нас нөгчих, насан хутга олох, насны тоо гүйцэх” гэх мэт хүний амь настай холбож их хэрэглэдэг. Энэ үг хэллэг хүний насыг тэнгэрээс заяадаг, тогтоодог гэсэн Монголчуудын соёл сэтгэлгээг агуулж байна. Орчлон, хорвоогоос одох, тэнгэр болох гэх мэт орчлон, тэнгэртэй холбоотой эерүүлэл олон байдаг. Орчлон, хорвоогоос одох нь үхлийг нэг газраас өөр газарт хөдлөх гэж ойлгодгийг харуулдаг. “Тэнгэртэй холбож байдаг нь тэнгэрийг шүтдэг болон нас барсан хүнийг бурхан болж өөдөө гардаг гэж Моголчуудын итгэдэгтэй холбоотой юм. Мөн орчлонгийн хувьд энэ ертөнц буюу нарт хорвоо, цаадах ертөнц буюу харанхуй орон, эсвэл хойд төрөл байна гэсэн Монголын ертөнцийг үзэх үзлийг харуудаг юм. “Болох”-той холбоотой үг хэллэг олон байдаг. Энэ нь

үхлийг “ямар нэгэн өөрчлөлтөд орох” үйлдэл гэж ойлгодог Монголчуудын соёл сэтгэлгээг харуулж байгаа юм. Шашны хувьд буддын шашинтай холбоотой эерүүлэх үг хэллэг харьцангуй олон байдаг.

Үхлийн тухай Солонгосын эерүүлэх үг хэллэгийн онцлог үхлийн тухай илэрхийлэлд нэр төр, эрхэм чанар, түвшин байдаг юм. Үхсэн хүний нийгэмд эзлэх байр сууриас хамааран олон янзаар нэрлэдэг байжээ. Найруулгын зэрэг дэв буюу хэрэглээний хувьд “사망하다” гэдэг нь доод зэрэгтэй, “별세하다”, “타계하다” гэдэг нь дунд найруулгын түвшнийх юм. “서거하다” нь найруулгын хамгийн дээд түвшин юм. Солонгост үхлийн тухай хятад тэмдэгт болон уугуул үгсийн нийлбэр үг хэллэг олон байдаг. Мөн Солонгос хэлэнд нөхцөл байдлаас шалтгаалан үхлийн тухай үг хэллэг нь өөр өөр байдаг. Шашин бүр үхлийн тухай тусгай нэр томьёо хэрэглэдэг.

ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕС, МЕНЕЖМЕНТ

М.ДОВУУЧ

Өрийг хувьцаагаар солих шийдвэр, түүний нөлөө

Б.ТҮВШИНБАЯР

Онлайн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний
онол арга зүйн асуудалд

ӨРИЙГ ХУВЬЦААГААР СОЛИХ ШИЙДВЭР, ТҮҮНИЙ НӨЛӨӨ

Доктор (Ph.D), дэд профессор М.Довууч
(ОУУБИС. ЭЗБС)

dovuuch.m@ulaanbaatar.edu.mn

Хураангуй

Өрийг хувьцаагаар солих шийдвэр нь хувьцаат компанийн зүгээс гаргах боломжтой шийдвэрийн нэг төрөл юм. Өрийг хувьцаагаар солих нь хувьцаат компанийн нэмэлт хувьцаа гаргахын нэгэн онцлогтой шийдвэрт тооцогддог.

Энэхүү шийдвэрийг хувьцаат компаниуд тэр болгон гаргаад байдаггүй бөгөөд өр төлбөрийн хэмжээ нэмэгдэж, бизнесийн хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх болсон үед тодорхой хэлцэл хийх замаар хэрэгжүүлэх боломжтой байдаг. Компанийн өр төлбөрийг барагдуулсан дүнгээр нэмэлт хувьцаа гаргаж, компанийн хувьцааны тоог нэмэгдүүлэх замаар өрийг чөлөөлөх нэг хувилбар юм.

Түлхүүр үг: Өрийг хувьцаагаар солих, хувьцаа эзэмшигчдийн эрх, нэмэлт хувьцаа, нэмж төлөгдсөн капитал

ӨРИЙГ ХУВЬЦААГААР СОЛИХ ШИЙДВЭРИЙН ТУХАЙ

“Өрийг хувьцаагаар солих” гэдэг нь компанийн өрийг төлсөн дүнгээр тухайн хувь нийлүүлэгч талд компанийн хувьцааг эзэмшүүлэх явдлыг хэлнэ. Өөрөөр хэлбэл компанийн нэрийн өмнөөс зээлдүүлэгчид өр төлбөрийг төлж, түүний оронд компанийн нэмэлт хувьцаанаас эзэмших арга хэлбэр юм.

Хэрвээ тус шийдвэрийг хэрэгжүүлэхээр бол нэмэлт хувьцаа гаргаж, компанийн өрийг төлсөн хувь нийлүүлэгчдэд нэмэлтээр гаргасан хувьцаагаа эзэмшүүлэх шаардлагатай болдог.

Компанийн хувьцаанаас бусад үнэт цаас болон өрийг хувьцаагаар сольж болох бөгөөд үүнийг өрийг хувьцаагаар солих гэнэ.¹

Өрийг хувьцаагаар солих шийдвэр гаргахад хувь нийлүүлсэн хөрөнгийн

¹ Компанийн тухай хуулийн 25-р зүйлд өрийг хувьцаагаар солих ойлголтыг тусгаж өгсөн байдаг. Гэвч нарийн зохицуулалтыг тусгаж өгөөгүй.



хэмжээ буюу хувьцаат капитал нэмэгдэж, компанийн өр төлбөр буурдаг. Харин компанийн баланс дахь нийт хөрөнгө ба нийт эх үүсвэрийн хэмжээнд өөрчлөлт гарахгүй. Тодруулж хэлбэл балансын эх үүсвэр талд өр төлбөр буурч, тэр хэмжээгээр хувьцааны үнийн дүн нэмэгдэх тул өөрчлөлт орохгүй гэсэн үг.

Компанийн өрийг хувьцаагаар солих шийдвэр гаргах үндэслэл нь:

- 1) Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах
- 2) Компанийг өр төлбөрөөс чөлөөлөх
- 3) Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах

Өрийг хувьцаагаар солих шийдвэр гаргахдаа компанийн удирдлага хувьцаа авах зээлдүүлэгч, харилцагчийн зөвшөөрлийг авсан байх шаардлагатай болдог. Өөрөөр хэлбэр өрийг төлж барагдуулаад, түүний оронд хувьцаа эзэмших боломжтой этгээдтэй урьдчилан тохиролцох буюу хэлцэл хийсэн байх ёстой.

Өрийг хувьцаагаар солих шийдвэрийн давуу тал

Өрийг хувьцаагаар солих шийдвэр нь хувьцаат компанийн удирдлага болон хувьцаа эзэмшигчдэд олон давуу талыг олгодог төдийгүй хувь нийлүүлэгчдэд хувьцаанд хөрөнгө оруулалт хийх боломжийг давхар олгодог онцлогтой.

Өрийг хувьцаагаар солих шийдвэр гаргах нь хэд хэдэн давуу талтай. Үүнд:

- 1) Хувьцаат компани өр төлбөрөөс чөлөөлөгдөж, дампуурах эрсдэлгүй болно;
- 2) Компанийн санхүүгийн байдал, балансын үзүүлэлтүүд сайжирна;
- 3) Хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хамгаалагдана;
- 4) Хувьцааны тоо ширхэг нэмэгдэж, хөрвөх чадвар сайжирна;
- 5) Одоогийн хувьцаа эзэмшигчдэд нэмж гаргасан хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдаж авах эрх хадгалагдана;
- 6) Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нэмэгдэж, өрийн хэмжээ буурч, компанийн капиталын бүтэц сайжрах боломжтой;
- 7) Хувь нийлүүлэгчдэд хувьцаанд нэмэлт хөрөнгө оруулалт хийх боломжийг олгоно;
- 8) Тус шийдвэрийг гаргах тохиолдолд одоогийн хувьцаа эзэмшигчдэд компанийг хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрх үүснэ.

Өрийг хувьцаагаар солих шийдвэр гаргах нь хэд хэдэн сул талтай. Үүнд:

- 1) Хувьцааны тоо ширхэг нэмэгдэж, цаашид нэгж хувьцааны ашиг багасна;
- 2) Ногдол ашгийн өгөөж буурна;

- 3) Хувьцааны зах зээлийн үнэ буурна;
- 4) Ногдол ашиг төлөх магадлал буурна;
- 5) Хувьцааны төвлөрөл нэмэгдэх боломж бүрдэнэ.

Өрийг хувьцаагаар солих шийдвэр гаргах нь ерөнхийдөө давуу талтай, ашиг тус ихтэй шийдвэр болдог. Сул талуудын хувьд хувьцааны тоо ширхэг нэмэгдэхтэй холбоотой гарч ирдэг хэдий боловч дунд болон урт хугацаанд эдгээр сул талыг арилгах бүрэн боломжтой юм.

Өрийг хувьцаагаар солих шийдвэр гаргах ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа өр төлбөрийн девет, энгийн хувьцаа дансны кредитэд тус тус бичилт хийж, зөрүү дүнг нэмж төлөгдсөн капитал дансанд бүртгэх ёстой. Үндсэн бичилт нь:

Өр төлбөрийн данс	хх
Энгийн хувьцаа	хх


Өрийг хувьцаагаар солих шийдвэрийн хэрэгжилтийн судалгаа

Өрийг хувьцаагаар солих шийдвэр гаргахтай холбоотой хуулийн зохицуулалтыг компанийн тухай хуулийн 25-р зүйлд дараах байдлаар тусгасан байдаг.

- ✓ Зээлдүүлэгч болон бусад харилцагчтай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол компанийн өрийг хувьцаагаар солиход хувьцаа авах тухайн зээлдүүлэгчид, харилцагчийн зөвшөөрлийг авсан байна. /25.2/
- ✓ Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь компанийн өрийг хувьцаагаар солих тухай төсөл боловсруулан хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлүүлнэ. /25.3/
- ✓ Өрийг хувьцаагаар солих тухай төсөлд хувьцаагаар солих өр, гаргах хувьцааны хэмжээ, үнэ, зорилго, хэрэгжүүлэх нөхцөл, журам, компанийн дүрэмд оруулах өөрчлөлт зэргийг зааж өгсөн байна. /25.4/
- ✓ Хувьцаа, түүнийг худалдан авах эрхийн бичиг буюу хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэдгээрийн хөрвөх нөхцлийн дагуу хөрвүүлэхийг компанийн өрийг хувьцаагаар сольсонд тооцохгүй. /25.5/
- ✓ Компанийн өрийг хувьцаагаар солихоор нэмж гаргасан хувьцааг хувьцаа эзэмшигч тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхтэй. /25.6/

Өрийг хувьцаагаар солих шийдвэр гаргаж хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь тодорхой үе шаттай байдаг.

Зураг 1. Өрийг хувьцаагаар солих шийдвэрийг хэрэгжүүлэх үе шатууд



Өрийг хувьцаагаар солих шийдвэр гаргахын тулд юуны өмнө хувьцаа худалдаж авах эзэлдүүлэгч, харилцагч, хөрөнгө оруулагчтай харилцан тохиролцсон байх ёстой. Энэ нь тус шийдвэрийг гаргах урьдач нөхцөл болох юм. Хэрвээ компанийн зээлийг төлж барагдуулах замаар нэмэлт хувьцаа эзэмших тохиролцоо, хэлцэл хийж чадвал өрийг хувьцаагаар солих төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд албан ёсоор танилцуулж, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гаргана. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлт гаргана. Өрийг хувьцаагаар солих шийдвэр гаргах хүсэлтийг үндэслэн эрх бүхий зохицуулагч байгууллагуудаас бүртгэлийг баталгаажуулж, үнэт цаасны бүртгэлийн өөрчлөлтийг шинэчлэн бүртгэнэ. Үүний дараа “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” хязгаарлагдмал хариуцлагатай компани үнэт цаасыг бүртгэснээр хувьцааны хоёрдогч арилжааг эхлүүлэх боломжтой болно. Үнэт цаасны бүртгэлийг баталгаажуулсны дараа компанийн дүрэмд албан ёсоор өөрчлөлт оруулснаар өрийг хувьцаагаар солих шийдвэр хэрэгжиж дуусах юм.

“Монгол шилтгээн” ХК нь 2.5 тэрбум төгрөгийн өрийг энгийн хувьцаанд хөрвүүлэх шийдвэр гаргасан. Тус шийдвэрийг гаргаснаар хувьцааны нэрлэсэн үнийг балансын үнээр тооцож 290 төгрөг байхаар тогтоох бөгөөд энгийн хувьцааны тоо 8620690 ширхэгээр нэмэгдэж, хувьцааны үнийн дүн 18.620.690 болно гэсэн үг. Энэхүү шийдвэрийг хэрэгжүүлсний үр дүнд тус компани 2.5 тэрбум төгрөгийн өр төлбөрөөс чөлөөлөгдөж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хамгаалагдсан гэсэн үг.²

² 2.5 тэрбум төгрөг бол багагүй мөнгө бөгөөд тус хувьцаат компанийн хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж эхэлсэн тул хувь нийлүүлэгчдийн зүгээс тус шийдвэрийг гаргахад хүрсэн. Өөрөөр хэлбэл хувьцаат компанийн оршин тогтнох, тогтвортой үйл ажиллагаа явуулах, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийн үүднээс уг шийдэлд хүрсэн хэмээн тайлбарласан.

Хүснэгт 1. Өрийг хувьцаагаар солих шийдвэр

/Монгол шилтгээн ХК/

Үзүүлэлт	Үнэт цаасны одоогийн бүртгэл	Үнэт цаасны бүртгэлд орох өөрчлөлт
Үнэт цаасны нэр	“Монгол шилтгээн” ХК	“Монгол шилтгээн” ХК
Санхүүгийн хэрэгслийн нэр	Хувьцаа	Хувьцаа
Хувьцааны төрөл	Энгийн	Энгийн
Үнэт цаасны үсгэн код	MSH /517/	MSH /517/
Үнэт цаасны хэлбэр	Биет бус	Биет бус
Үнэт цаасны тоо, ширхэг	10.000.000	18.620.690
Олон нийтийн эзэмшил	10.000.000	18.620.690
	100%	100%
Үнэт цаасны нэрлэсэн үнэ	290 төгрөг	290 төгрөг
Үнэт цаасны үнийн дүн	2.900.000.000 төгрөг	5.400.000.100 төгрөг

Эх сурвалж: “Монгол шилтгээн” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын материал (2023)

“Монгол шилтгээн” ХК-ийн үнэт цаасны үнийн дүнд өөрчлөлт орж, хувьцаат капитал нэмэгдэж байгаа боловч, тэр хэрээр баланс дахь өр төлбөр буурах замаар балансын нийт хөрөнгийн дүнд өөрчлөлт орохгүй юм. Тус компанийн хувьд өрийг хувьцаагаар солих шийдвэртэй холбоотой ажил гүйлгээг дараах байдлаар бүртгэлд тусгах ёстой.

Өр төлбөрийн данс	2.500.000.000₮
Нэмж төлөгдсөн капитал	100₮
Энгийн хувьцаа	2.500.000.100₮

ДҮГНЭЛТ

Компани зээлдүүлэгчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон үед өрийг хувьцаагаар сольж, өр төлбөрөөс чөлөөлөгдөж болдог. Энэ тохиолдолд компани өр төлбөрөөс чөлөөлөгдөх бөгөөд компанийн өрийг төлсөн этгээд нь нэмж гаргасан хувьцааны эзэмшигч болно гэсэн үг. Өрийг хувьцаагаар солих шийдвэр гаргах нь компанийн одоогийн болон ирээдүйн шинэ хөрөнгө оруулагчдад хувьцаанд хөрөнгө оруулалт хийх боломжийг олгодог.

Компанийн өрийг хувьцаагаар сольж байгаа этгээд буюу хөрөнгө оруулагч



нь компанийн хувьцааг зах зээлийн үнээс харьцангуй бага буюу дансны үнээр худалдаж авах боломжтой. Учир нь өр төлбөрийн хэмжээ нэмэгдэж, түүнийг барагдуулахад хүндрэлтэй болсон тохиолдолд өөрийн хувьцааг санал болгож, зээлдүүлэгч эсвэл хөрөнгө оруулагчидтай хэлцэл хийхэд хүргэдэг.

Энэхүү шийдвэр гаргах алхам нь юуны өмнө компанийн одоогийн үйл ажиллагааг хэвийн явуулах, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хангах, хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

Өрийг хувьцаагаар солих шийдвэрийн давуу болон сул талуудыг харьцуулан дүгнэж үзвэл давуу тал нь хамаагүй олон байх бөгөөд сул тал гэвэл нэгж хувьцааны ашиг, ногдол ашгийн өгөөж, хувьцааны зах зээлийн үнэ буурах гэсэн ашигт ажиллагаатай холбоотой үзүүлэлтүүд буурах боловч баланс дахь санхүүгийн үзүүлэлтүүд сайжирч, цаашид ашигт ажиллагааны түвшингээ нэмэгдүүлэх бүрэн боломжтой байдаг.

Ашигт ажиллагааны түвшин буурч байгаа нь хувьцааны тоо ширхэг нэмэгдсэнтэй шууд холбоотой бөгөөд компанийн өнөөгийн хэвийн үйл ажиллагааг хангаж, санхүүгийн хүндрэлээс гэтэлгэж өгдөг нь уг шийдвэрийн туйлын давуу тал юм.

Өр төлбөрийн хэмжээ нэмэгдэж, компанийн тогтвортой үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх болсон үед энэхүү шийдвэрийг гаргаж хэрэгжүүлэх нь хувьцаат компанийн үйл ажиллагааг дэмжих, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангах, хөрөнгө оруулагчдад нэмэлт хувьцаанд хөрөнгө оруулалт хийх боломжуудыг нэгэн зэрэг олгох сайн шийдвэр болдог.

НОМ ЗҮЙ

1. Компанийн тухай хууль, шинэчилсэн найруулга 2011 он
2. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, шинэчилсэн найруулга 2013 он
3. Монгол шилтгээн хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан хурлын материал 2023 он
4. www.mse.mn

ОНЛАЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОНОЛ АРГА ЗҮЙН АСУУДАЛД

Магистр Б.Түвшинбаяр

(ОУБИС. ЭЗБС)

tuvshinbayar.b@ulaanbaatar.edu.mn

Хураангуй

21-р зуун гарсаар хүн төрөлхтний түүхэн дэх нэгэн том хөгжлийн үе шат болох цахим зуун буюу дижитал технологи эрчимтэй хөгжиж байна. Өнөө цагт аль ч салбарын байгууллага цаг үетэйгээ хөл нийлүүлж өөрсдийн цаг зав болон үйл ажиллагаагаа өргөжүүлэн хөнгөвчлөхийн тулд мэдээллийн систем, дижитал технологийн үсрэнгүй хөгжлийг ашигладаг болж. Технологийн энэхүү хөгжил нь хүмүүний ердийн хэрэглээнд хувьсгал авчрахаас гадна бизнес хийх уламжлалт арга зүй, тогтолцоо, загварт ч онцгой өөрчлөлтүүд авчрах болжээ. Өөрөөр хэлбэл технологи гэдэг зүйл тоглоомын дүрмийг өөрчлөх боломжийг олгох болсон. Технологийн эрчтэй хөгжлийн үр дүнд хүн бүхэн харилцаа холбоотой болохоос гадна хүн машин, бүр цаашлаад машин хоорондоо холбогдох болж мэдээллийн асар том давлагаа үүсгэх болов.

Манай улсад аялал жуулчлалын салбарын онлайн үйлчилгээ 2010 онд нэвтэрч 2016 оноос хойш аялал жуулчлалын байгууллагуудын онлайн үйлчилгээний хэлбэр ихээхэн шинэчлэгдэн өөрчлөгдөж байгаа бөгөөд Монголын аялал жуулчлалын байгууллагууд онлайн үйлчилгээг нэвтрүүлснээр өөрсдийн хэрэглэгч нараа хэрхэн татах, хадгалан авч үлдэх вэ? гэсэн томоохон асуудалтай тулгарч байна. Дэлхийн хүмүүс орлогынхоо дийлэнх хэсгийг амралт, зугаа цэнгээнд зарцуулж байгаагаар аялал жуулчлал нь дэлхийн үндэсний нийт бүтээгдэхүүний 3%, нийт экспортын үйлдвэрлэлийн 8 орчим хувийг хангаж байгаа. Нөгөөтээгүүр утаагүй, цэвэр үйлдвэрлэлийн зэрэгцээ олон улсын харилцааг дэмжигч эдийн засгийн салбар, нийгэм соёлын харилцан нэвтрэлцэх гүүр болохынхоо хувьд жил ирэх тусам тогтвортой өссөөр байна.

Аялал жуулчлалын салбар нь эрт эдүгээ цагт хүн төрөлхтөн шинэ газар нутаг нээж эхэлсэн цагаас үүссэн гэдэг боловч онол арга зүйн хувьд бусад салбар шинжлэх ухааны хувьд 20-р зуунаас эхлэлтэй хэмээн эх сурвалжууд үздэг. Хэдий онол арга зүйн хувьд залуу хөгжиж буй салбар боловч орчин үеийн техник



технологитой нийлэн шинэ салбар чиглэл, онол арга зүй үүсэн болоход хялбар дөхөм болж байна.

Энэхүү судалгааны ажлаар онлайн орчинд бий болж буй аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний онол арга зүйг тодруулан их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт ашиглахыг зорилоо.

Түлхүүр үг

Аялал жуулчлал, онлайн аялал жуулчлал, OTA /online travel agency/, GDS /global distribution system/

ОНЛАЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ОНОЛ, АРГА ЗҮЙН ҮНДЭС

Интернэт, мэдээллийн технологи нь хүн төрөлхтний түүхэнд хамгийн чухал, зайлшгүй шаардлагатай шинэлэг зүйл болж ирсээр байна. Интернэт нь орчин үеийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн олон шинж чанарыг интерактив /олон талт, эргэх холбоо/ зарчмаар өөртөө агуулж байдаг. Тиймээс энэ нь зөвхөн хувь хүмүүсийн бие биетэйгээ бизнесээ хийх арга барилыг шинэчлээд зогсохгүй нийгэмд ямар ач холбогдолтой болохыг илэрхийлж байдаг. Одоогийн байдлаар дэлхий даяарх хэрэглэгчид, бизнесмэнүүд, ажилтнууд зэрэг олон сая хүмүүс ажил хийх, суралцах, харилцах, зугаа цэнгэл, амралт, дэлгүүр хэсэх зэрэгт интернетийг ашиглаж байна. Интернэт бий болсноос хойш аяллын төлөвлөлт /аяллын мэдээлэл хайх, захиалах/ хийх нь хүмүүсийн интернет ашиглах гол шалтгаануудын нэг байсаар байна.

Аялал жуулчлалын салбар нь бараа материалын тээвэрлэлтийг түших асуудал бага байдгаараа онцлогтой бөгөөд цахим буюу онлайн худалдаа их илүү бие даасан байдаг. Энэ нь аялал жуулчлалын салбарын онлайн худалдаа нь үндэсний үйлдвэрлэлт болон мэдээлэл технологи хоёрыг хослуулсан төлөөлөл бүхий салбар болгож чадаж байгаа юм. Санхүү, программ хангамж, хэвлэл мэдээлэлтэй зэрэгцэн онлайн худалдаа үйлчилгээний 4 гол салбарын нэг болж байна.

Онлайн худалдааны зах зээлд давуу эрх олж авахын тулд аялал жуулчлалын салбар бусад салбарын нэгэн адил жуулчдад зориулсан төрөл бүрийн мэдээллээр хангах зорилгоор интернэтэд өөрийн вэбсайтыг бий болгосон. Өмнө нь жуулчид өөрсдийн туршлага болон танил талынхаа санаа бодлоос аяллын шийдвэр гаргахдаа их тусгадаг байсан бол сүүлийн үед интернэтээр дамжуулан шийдвэр гаргах хандлага ажиглагдаж байна. Энэ талаас харахад хэрэглэгчид өмнөх шигээ нэг мэдээлэлд найдах бус янз бүрийн сувгийг ашиглан мэдээлэл олж авахыг эрмэлздэг болсон. Өөрөөр хэлбэл, одоогийн хэрэглэгчид онлайн болон уламжлалтаар төрөл

бүрийн сувгийг ашиглан мэдээлэл цуглуулж аяллын төлөвлөлт, шийдвэр гаргадаг гэсэн үг Аялал хийхээр төлөвлөж буй хүмүүст хаашаа явж байгаа, аялалд юу хийх хэрэгтэй, юу хийхийг хүсэж байгаа, хаана үлдэх, хэрхэн аялах зэрэг бусад хүчин зүйлсийн талаар мэдээлэл авах боломжтой эх сурвалж хэрэгтэй. Онлайн аялал жуулчлалын салбар нь аялагчдад ийм боломжийг олгодог. Онлайн аялал жуулчлалын салбарын эрэлт хэрэгцээ нь эдийн засгийн байдлаас хамаардаг нийтлэг хэрэглэгчдийн орлогоос үүдэлтэй байдаг.


Аялал жуулчлалын зах зээл нь сая сая худалдан авагч болон худалдагч хамтран аялал жуулчлалын үйлчилгээг солилцдог бизнесийн талбар юм.

Худалдан авагчдын аялал жуулчлалтай холбоотой үйлчилгээг эрэлхийлдэг хэрэгслүүд нь олон улсын түгээлтийн систем (GDS - Global distribution system) болон интернэт түгээлтийн системүүд (IDS – Internet distribution system) байдаг. Эдгээр системүүд нь худалдан авагчдыг үйлчилгээ үзүүлэгчидтэй холбож, захиалгаа богино хугацаанд, бага хүчин чармайлтаар хийх боломжийг олгодог интернэт дэлгүүр болсон. Онлайн болон интернэт бий болсноос хойш аялал жуулчлалын салбар онлайн мэдээллийн хэрэгслээр хөгжиж эхэлсэн бөгөөд үйлчлүүлэгчдэд илүү ээлтэй болж байна. Интернэт, мэдээлэл, харилцаа холбооны технологийн хувьсгал нь онлайн хэвлэл мэдээллийн хэрэгслийг аялал жуулчлалын салшгүй хэсэг болгож байгаа бөгөөд жуулчдад аялал жуулчлалын тоглогчдын санал болгож буй интернэт программ, системүүдээр дамжуулан аяллын төлөвлөгөөгөө өөрчлөх боломжийг олгодог. Интернэт нь худалдан авагч болон худалдагч бүлгийг аялал жуулчлалын төвлөрсөн зах зээлд нэгтгэснээр аялал жуулчлалын борлуулалтын хамгийн тохиромжтой суваг болсон.

Онлайн аялал жуулчлал гэдэг нь аялал жуулчлалын салбарт мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглахыг хэлнэ. Үүнд интернэт, кабелийн телевиз гэх мэт онлайн сувгуудаар дамжуулан аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах, худалдах, сурталчлах, мэдээлэл түгээх үйл ажиллагаа орно. Онлайн аялал жуулчлалыг бие даасан үйл явц, систем гэж ойлгож болохгүй учир нь энэ нь мэдээллийн технологи, харилцаа холбооны системээр дамжуулан онлайн горимыг хэрэглэгчдэд шууд болон шууд бусаар хүргэх олон тооны оролцогчид, тоглогчдоос бүрддэг.


Global Distribution System (GDS) нь аялал жуулчлалын салбарын тархи гэж хэлж болно. Уг систем агаарын тээврийн компаниуд, зочид буудал, машин түрээслэгчид, аялал жуулчлалын агентлагууд зэрэг компаниудыг одоо цагийн мэдээллээр хангадаг компьютержсон сүлжээний систем. Жишээлбэл, аялал жуулчлалын агентлаг GDS-ийг ашиглан үйлчлүүлэгчдийнхээ өмнөөс зочид буудлын өрөөнүүд, нислэгийн суудал, машин зэргийг захиалах, түрээслэх боломжтой.

Зураг 1 GDS-ийн хөгжлийн түвшин

Эх сурвалж: [researchgate.net](https://www.researchgate.net)

1950 онд интернэт бий болоогүй үед аяллын агентлагууд нислэг бүрийг гараар бичин захиалдаг байв. Энэ нь нэг үгээр хэлбэл ажилтан бүрийн ажлын ачааллыг нэмэгдүүлэхээс гадна хэрэглэгч болон бусад мэдээллийг бүрэн гүйцэт дамжуулахад асуудал үүсдэг байсан байна. Харин интернэт бий болсон цагаас эхлэн олон улсын хуваарилалтын систем (GDS) нь 1960-аад оны сүүлээр АНУ-ын хэд хэдэн агаарын тээврийн компаниудын хэрэгжүүлсэн анхны компьютерт суурилсан захиалгын системээс үүссэн. Энэ үеэс аялал жуулчлалын салбарт Online Travel Agency буюу онлайн аялал жуулчлалын байгууллага гэх мэдээллийн технологид суурилсан аялал жуулчлалын шинэ чиглэл үүсэх эхлэл нь тавигдсан. 1976 он хүртэл GDS системийг аялал жуулчлалын агентлагуудад суурилуулаагүй байсан бөгөөд агентууд алсын зайнаас нэвтрэх терминалуудыг ашиглан системд шууд захиалга хийх, захиалгаа өөрчлөх боломжийг олгодог байсан байна. Харин 1990 оны дунд үеэс аяллын тур оператор, агентууд GDS-ээс санаа авч аяллын багц бүтээгдэхүүн үйлчилгээг интернэтээр дамжуулан хэрэглэгчдэд санал болохуйц онлайн аялал жуулчлалыг бий болгосон.

Зураг 2 GDS-ийн процессийн зураглал



20-р зууны сүүлээр, аялал жуулчлалын онлайн худалдаа үйлчилгээ нь анхны алхам хийсэн үе гэж үздэг. Хэдийгээр тухайн үеийн аялал жуулчлалын онлайн худалдааны үйлчилгээ эрхэлдэг веб сайт нь 2000 гаруй байсан ч аялал жуулчлалын салбарын онлайн системчлэх урсгалын түүхэн хөгжлийн үйл явц болж энэ нь цаашдаа дэлхий даяар хөгжих болно гэдэгт эргэлзэшгүй асуудал байсан юм. Хөгжлийн түвшингээр харахад барууны хөгжиж буй улсууд энэхүү салбарт дэлхийд тэргүүлж байна.

Хүснэгт 1 GDS-ийн зах зээлд эзлэх хувь 2015 (Бүс нутгаар)

GDS	Зах зээлд эзлэх хувь
Дэлхийн зах зээл	
Amadeus	40.7%
Sabre	36.6%
Travelport	22.6%
Хойд Америкийн зах зээл	
Amadeus	20.1%
Sabre	54.5%
Travelport	25.4%



Латин Америкийн зах зээл	
Amadeus	39.4%
Sabre	54.6%
Travelport	6.0%
Европ, Ойрхи Дорнод, Африк (ЕМЕА)-ийн зах зээл	
Amadeus	62.6%
Sabre	15.3%
Travelport	22.1%
Ази Номхон далайн бүс нутаг (APAC)	
Amadeus	36%
Sabre	39.1%
Travelport	24.9%

Эх сурвалж: researchgate.net

GDS-үүд дэлхийн онлайн аялал жуулчлалын гол цөм буюу зам гэж хэлж болно. Уг системүүдээр ихэвчлэн олон улс болон орон нутгийн нислэгийн одоо цагийн мэдээллээр хангаж билет захиалга хийгддэг бөгөөд олон улсын аялал жуулчлалын ихэнх орлогыг бүрдүүлж өгдөг. Уг системүүд нь тухайн бүс нутаг болон орон нутгийн онцлогоос шалтгаалан зах зээлийг эзлэх хувь хэмжээ өөр өөр байна.

Одоогоор судлаачид аялал жуулчлалын онлайн худалдаа үйлчилгээний талаар нэгдсэн тодорхойлолт гаргаагүй байгаа. Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын хэвлэл мэдээллүүд тодорхойлохдоо “Аялал жуулчлалын онлайн худалдаа үйлчилгээ нь орчин үеийн мэдээлэл технологийн аргаар аялал жуулчлалын салбарын дотоод болон гадаадтай холбох холболт холбоог бий болгосон ба аялал жуулчлалын байгууллага болон нийлүүлэгч байгууллагын хоорондын, аялал жуулчлалын байгууллага болон жуулчид хоорондын гэсэн харилцаа тогтоох мөн худалдан авалтын байгууллагын дотоод үйл явцыг сайжруулан, мэдээлэл болон мэдлэгийг хамтран хуваалцахыг хэлж байна” гэж дүгнэжээ.

Энэхүү салбар нь худалдан авалтын сэтгэл зүй, хэрэглэгчийн мэдээлэл зүй, мэдээлэл технологи, компьютерын сүлжээний технологи гэх мэт салбарын мэргэжлийн мэдлэгийг багцлан агуулсан байдаг. Интернэт ба аялал жуулчлалын үнэ цэнийг тодотгож өсгөсөн байдаг. Мөн хамрах хүрээ нь өргөн, цаг хугацаа, орон зайны хязгааргүй, хэрэглэгчидтэй шууд харилцах ба үйл ажиллагаа явуулахад өртөг бага зарцуулдаг гэсэн давуу онцлог талууд байдаг. Аялал жуулчлалын онлайн үйлчилгээ нь аялал жуулчлалын байгууллага интернэтээр дамжуулах аргаар өөрийн тусгай веб сайтыг байгуулж аялагч болон үйлчлүүлэгчдэд аяллын тухай үйлчилгээ

хүргэх үйл явдлыг хэлнэ. Ерөнхийд нь аялал жуулчлалын байгууллага нь зөвхөн аялал жуулчлалтай холбогдох мэдээлэл түгээхээс гадна мөн өөрийн аялалтай холбоотой төрөл бүрийн аяллын маршрут хүргэдэг, тийм учраас үйлчлүүлэгч нь аялал жуулчлалын веб сайт хуудаснаас өөрт хамгийн тохиромжтой гэсэн аяллын маршрут сонгон олж чадах ба түүнээс тухайн бүтээгдэхүүн үйлчилгээг худалдан авалт хийх эсэхийг шийднэ¹.

Онлайн үйлчилгээ болон веб сайт нь мэдээллийг түргэн шуурхай болон шинэчлэгдэхэд хурдан гэсэн онцлог талтай. Байгууллагууд өөрийн аялал жуулчлалын үйл ажиллагаа бүхий онлайн үйлчилгээнд төрөл бүрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг түргэн шуурхай хэрэглэгчдэд хүргэж болдог. Энэ нь хэрэглэгчийн аялалтай холбоотой урьдчилсан төлөвлөлт хийхэд илүү түлхэц болж чаддаг².

Орчин үе интернэт үйлчилгээний түгээмэл тархсан нөхцөл байдлаас хамааран аялал жуулчлалын веб сайт нь аялал жуулчлалын байгууллагын уламжлалт үйл ажиллагаа болон интернэтийн тохилог байдлыг давхар агуулсан байдаг. Аялагчид интернэт веб сайтаар дамжуулан хэрэглэгчдэд цаг тухайд нь аялалтай холбоотой мэдээллээр хангах, шинэ үеийн аялал жуулчлалын үйлчилгээ авах гэх мэт мэдээлэл дамжуулах чухал шугам болж хөгжиж байна. Онлайн болон тоон технологийн аялал жуулчлал нь тасралтгүй хөгжлийн үед байгаа ба дэлхийн аялал жуулчлалын онлайн худалдаа нь 5-н жил тасралтгүй дунджаар 3.5 дахин хурдтайгаар хөгжиж байна. Энэхүү хөгжил өндөр хөгжилтэй бүхий Европ, Америк орнуудад анзаарагдаж байна. Одоогийн байдлаар аялал жуулчлалын онлайн худалдааны үйлчилгээ нь 2 төрөлд ангилагдаж байна. Үүнд:

1. Мэдээллээр хангах
2. Онлайн борлуулалтын үйлчилгээ гэсэн ерөнхий хоёр хэсэгт хамаарч байна.

Хэдийгээр аялал жуулчлалын веб нь жуулчдын шийдвэрт нөлөөлөх нөлөөлөл нь тийм ч их биш ч сүүлийн 5 жилийн байдлаар аялагч, жуулчдын сонголтод нөлөөлөх байдал нь 18%-иар өссөн байна. Аялагчид аялал жуулчлалын вебийн хамгийн их нөлөөлөл үзүүлдэг үзүүлтүүдийн талаар судалгаа явуулсан үр дүнгээр аялал жуулчлалын веб нь аялагчийн сонголт хийхэд нөлөөлж буй хамгийн эхний хүчин зүйл нь аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг байгууллагын вебийн нэр хүнд байсан. Дараа нь аяллын онцлог болж байсан. Байгууллага нь өөрсдийн аялалд хамрагдаж буй аялагчдыг судалж, түүнд хамгийн тохиромжтой аялал

¹ Yang, & Jun, 2009; Heung, 2008; Ruiqi, & Adrian, 2009

² Chang, 2009 ; Kvist & Klefsjo, 2006



зохион байгуулах нь зүйтэй. Нөгөө талаар аялал жуулчлалын вебийн мэдээлэл шинэчлэлт нь хурдан, хэрэглэгчидтэй харилцах байдал нь идэвхтэй байх нь илүү их хандалттай болж чадна. Харин хамгийн чухал гэж бодогдуулдаг үнийн шинж чанар нь энэхүү бүлэг хүмүүсийн шийдвэрт нээх их нөлөө үзүүлж чадахгүй байна. Энэ нь хэрэглэгчдийн аялал жуулчлалын бүтээгдэхүүний үнээс аяллын сэтгэл ханамж болох үнэ цэн рүү илүү их анхаарал тавьдаг болсон явдал юм.

Манай Монгол улсын томоохон зочид буудлууд tripadvisor, booking, expedia гэх онлайн аялал жуулчлал системд нэгдсэнээр Монголын уламжлалт аялал жуулчлалаас онлайн аялал жуулчлал руу шилжих эхний алхмаа хийж 2014 оноос Монголын тур оператор, агентууд өөрсдийн онлайн аялал жуулчлалыг платформыг хийж эхэлсэн байна.

ДҮГНЭЛТ

Монгол онлайн орчинд бий болж буй аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний онол арга зүйг тодруулан судлахад дараах дүгнэлтүүдийг гаргаж байна.

- Манай орны хувьд онлайн аялал жуулчлалын салбарын хөгжлийн эхлэл олон улсын хөгжлийн эхлэлээс 20 гаруй жилийн дараа эхэлсэн боловч хурдацтай хөгжих хандлагатай байна.
- Олон улсын хэрэглэгчдийн онлайн орчин дахь аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний өнөөгийн төлөв байдал болон цаашдын ирээдүйн чиг хандлагыг судлан авч үзвэл онлайн аялал жуулчлал цаашид эрчимтэй хөгжих боломжтой.
- Онлайн аялал жуулчлалыг зөвхөн захиалга хийх хэмээн ойлгож болохгүй бөгөөд хэрэглэгч болон ханган нийлүүлэгчдэд одоо цагийн мэдээлийг өгдөг.
- Онлайн орчин дахь аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг зөвхөн онгоцны тийз болон зочид буудал захиалгаар үзүүлэхээс гадна аялал жуулчлалын бусад бүх төрлийн мэдээлэл багтдаг байна.

Сүүлийн жилүүдэд техник технологи эрчимтэй хөгжиж интернэтэд суурилсан систем, дрограм хангамжууд ихээхэн бий болж аливаа салбарын өрсөлдөх чадварт эерэг болон сөргөөр нөлөөлж байна. Гэсэн хэдий ч бизнесийн байгууллагууд өрсөлдөх чадвараа сайжруулахын тулд тухайн хөгжиж буй шинэ технологид бууж өгөх бус өөрийн салбар чиглэлдээ уусган оруулж цоо шинэ үйл ажиллагааны чиглэлийг бий болгон хөгжих хандлага ажиглагдаж байна.

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээрх эх сурвалжууд:

1. Цэцгээ,Б., Киселева,И.А., Тихомиров,Н.П., Тихомиров,Т.М. (2019). Аялал жуулчлалын хөгжлийн шинэчлэлийн асуудал. Улаанбаатар
2. Гүргэмжав,Э., (2014). Аялал жуулчлалын маркетинг. Улаанбаатар: Монгол Улсын Их Сургууль хэвлэх үйлдвэр.
3. Булгамаа,Г., (2013). Олон улсын аялал жуулчлал. Улаанбаатар:
4. Баасаннамжий,Б., (2017) Аялал жуулчлалын маркетингийн онолын үндэс. Улаанбаатар

Гадаад хэл дээрх эх сурвалжууд:

1. Heung Vincent., (2008) Effects of tour leader's service quality on agency's reputation and customers' word-of-mouth. Journal of Vacation Marketing
2. Zhilin Yang., Minjoon Jun., (2009) Consumer Perception of E-Service Quality: From Internet Purchaser and Non-Purchaser Perspectives
3. Dippelreiter,B., Grün,C., Dittenbach,M., Pesenhofer,A,. (2008) Online Tourism Communities on the Path to Web 2.0: An Evaluation. Vienna, Austria: Vienna University of Technology
4. Pierre,J,B., Zheng,X., Pauline,J., (2019) Tourism Information Technology (3rd edition). Wallington, UK
5. Hong-Youl,H., Janda,S., (2015) The Evolution of Expectations of and Attitudes Toward Online Travel Agencies Over Time. Seoul, South Korea: Dongguk University
6. Mayr,T., ANDREAS H., (2009) Acceptance of Online vs. Traditional Travel Agencies
7. Angeloni,S., Rossi,C., (2020) Online search engines and online travel agencies: A Comparative Approach
8. Hsin Chang., Su Wen Chen., (2008) The impact of online store environment cues on purchase intention: Trust and perceived risk as a mediator. Online Information Review
9. Anna Karin Jonsson Kvist., Bengt Klefsjo (2006) Which service quality dimensions are important in inbound tourism? : A case study in a peripheral location
10. Zhou Ruiqi., Pritchard Adrian (2009) Using servqual to measure the service quality of travel agents in Guangzhou, South China. Journal of Service Research

**Цахим эх сурвалжууд:**

1. www.1212.mn
2. www.researchgate.net
3. www.wttc.org
4. www.wikipedia.com
5. www.researchandmarkets.com
6. www.travelinsights.withgoogle.com
7. www.hospitalitynet.org

АНАГААХ УХААН

Ц.ОЮУНДАРЬ

Хөхний хорт хавдартай, хими эмчилгээ хийлгэж буй
эмэгтэйчүүдийн амьдралын чанар



ХӨХНИЙ ХОРТ ХАВДАРТАЙ, ХИМИ ЭМЧИЛГЭЭ ХИЙЛГЭЖ БУЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН АМЬДРАЛЫН ЧАНАР

Доктор, дэд профессор Ц.Оюундарь
(ОУУБИС, Сувилахуйн сургууль)
oyundari.ts@ulaanbaatar.edu.mn

Хураангуй:

Үндэслэл: Хөхний хорт хавдар нь тусгай хими эмчилгээ шаарддаг бөгөөд эмэгтэйчүүдийн амьдралын чанарт сөргөөр нөлөөлдөг. Хими эмчилгээ нь хорт хавдартай өвчтөнүүдийн амьдралын чанарт сөргөөр нөлөөлж байгаа хэдий ч хорт хавдрын эсийг устгаж, үсэрхийллийн эрсдлийг бууруулдаг юм. Иймээс хөхний хорт хавдартай, хими эмчилгээ хийлгэж буй эмэгтэйчүүдийн эрүүл мэндтэй холбоотой амьдралын чанарыг судлах шаардлагатай боллоо.

Судалгааны зорилго: Хөхний хорт хавдартай, хими эмчилгээ хийлгэж буй эмэгтэйчүүдийн амьдралын чанарыг тодорхойлоход оршино.

Арга, аргачлал: Судалгааг гүйцэтгэхдээ нэг агшингийн судалгааны аргыг ашиглалаа. Судалгаанд оролцогчдоос хэсгийг SF-36 (Short form 36), Бразил улсын Тиеzzi, Мария Фернанда Барбирато нарын (2020) олон хэмжээст асуулгаар судалгааг гүйцэтгэсэн. Энэхүү судалгаанд хөхний хорт хавдартай, хими эмчилгээ хийлгэсэн 93 эмэгтэйчүүдийг хамруулав. Амьдралын чанарын (SF-36) оноо нь 0-100 хооронд хэлбэлздэг бөгөөд 0-50 нь муу, <51-80 дунд, <81 дээш сайн гэж үнэлсэн болно.

Үр дүн: Судалгаанд оролцогч эмэгтэйчүүдийн амьдралын чанар ерөнхий эрүүл мэнд, үйл ажиллагааны хязгаарлалт, сэтгэцийн эрүүл мэнд, бие махбодийн өвдөлт “Дунд”, нийгмийн үйл ажиллагаа, амьдрах чадвар, эрч хүч, сэтгэл хөдлөлийн үүрэг “Муу” байгааг 36-зүйлийн богино маягт (Short form-36) судалгааны үр дүн харууллаа.

Дүгнэлт: Тусламжийн сувилахуйн бүлгүүдийг байгуулж, эмчилгээ, сувилгааны менежментийн талаар боловсрол олгох, дэмжих тусламж үйлчилгээ нь энэ хүн амын амьдралын чанарыг сайжруулах боломжтой гэж үзэж байна.

Түлхүүр үг: амьдралын чанар, богино хэлбэр, эмэгтэйчүүд.

Quality of Life in Women With Breast Cancer Undergoing Chemotherapy”

Ts.Oyundari, Ph.D, Associate Professor.

IUU School of Nursing

oyundari.ts@ulaanbaatar.edu.mn

Abstract.

Background: Although chemotherapy affects the quality of life of cancer patients, it kills cancer cells and reduces the risk of metastases. Therefore, there is a need to determine the health-related quality of life of the women with breast cancer undergoing chemotherapy, which is the basis of this study.

Aim: To determine quality of life of women with breast cancer undergoing chemotherapy.

Methods: This research was a cross-sectional study. 93 womens receiving day chemotherapy at the National Cancer Center were included in the survey.

The Medical Outcomes Study SF-36 was used to assess QOL. It is a multidimensional questionnaire composed of 36 items covering 8 scales or components: physical functioning, physical role functioning, bodily pain, general health, vitality, social functioning, emotional role functioning, and mental health. The SF-36 quality of life score ranges from 0 to 100, with 50 or less indicating poor quality of life, 51 to 80 as moderate, and 81 and above as good.

Results: The study Regarding quality of life the scores were as follows: general health 65 (Good), functional limitations 53 (medium), physical health 50 (medium), mental health 57 (medium), power and social action 49 (poor), and emotional role 37 (poor).

Conclusion: According to this research, women who have breast cancer and are undergoing chemical therapies need to implement a policy aimed at improving their quality of life.

Keywords: Quality of life. Short form, Womens,



УДИРТГАЛ

Хөхний хорт хавдар нь хөхний эдэд үүсдэг ноцтой хавдар юм. Хөхний хорт хавдар нь амь насанд заналхийлдэг, мастэктоми гэх мэт мэс заслын үйл ажиллагааны үр дүнд биеийн дүр төрхийн асуудалд хүргэдэг, анхан шатны эмчилгээ нь нарийн төвөгтэй эмнэлэгт ойр ойрхон ирдэг, эмнэлэгт хүлээх хугацаа урт, хими эмчилгээ, туяа эмчилгээ нь санхүүгийн хувьд нөлөөлдөг, ажиллах, хүүхэд асрах, чөлөөт цаг, өдөр тутмын амьдрал зэрэг нийгмийн үйл ажиллагаа тасалдсан нь өвчтөний сэтгэл зүйд нөлөөлөн амьдралын чанарыг буурахад хүргэдэг. (Тиеззи, Мария Фернанда, Мата нар Бразил 2020). Хими эмчилгээ нь хорт хавдартай өвчтөнүүдийн амьдралын чанарт сөргөөр нөлөөлж байгаа хэдий ч хорт хавдрын эсийг устгаж, үсэрхийллийн эрсдлийг бууруулдаг юм. Амьдралын чанарыг үнэлэх нь илүү сайн тусламж үйлчилгээ үзүүлэхэд ихээхэн ач тустай хорт хавдартай өвчтөнүүдийн хамгийн чухал арга хэмжээний нэг юм. Хөхний хорт хавдартай өвчтөнүүдийн эсэн мэнд үлдэх хугацааг нэмэгдүүлнэ. (Жамила Юсофф, Аниза Исмаил нар Малайз. 2022). Монгол улсын хувьд хөхний хорт хавдар нийт хорт хавдрын тохиолдлоор 6-р байранд, эмэгтэйчүүдийн хорт хавдрын тохиолдлын 4-р байрыг эзэлж байгаа төдийгүй үйлчлүүлэгчид өвчний гурав, дөрөвдүгээр түвшиндээ ирж оношлуулан, тусламж үйлчилгээ авах нь жилээс жилд нэмэгдэж байна. Улаанбаатар хотод хөхний хорт хавдрын шинэ тохиолдол 100.000 хүн амд 8.3 байгаа нь улсын дунджаас 4-өөр илүү үзүүлэлттэй байна. (Хавдар судлалын үндэсний төв 2021). Иймээс хөхний хорт хавдартай, хими эмчилгээ хийлгэж буй эмэгтэйчүүдийн эрүүл мэндтэй холбоотой амьдралын чанарыг үнэлэх зорилго болсон юм.

Судалгааны арга зүй: Судалгааг гүйцэтгэхдээ нэг агшингийн судалгааны аргыг ашиглалаа. Хавдар судлалын үндэсний төвийн өдрийн хими эмчилгээнд үйлчлүүлж байсан эмэгтэйчүүдийг эх олонлогийн төлөөлөл болгон 95% магадлалаар интервалыг 0.05-аар тооцож нийт 109 оролцогчийг хамруулахаар тооцсон. Судалгааны түүврийг тодорхойлохдоо Япон улсын эрдэмтэн судлаач Taro Yamane-ын боловсруулсан томъёог ашиглан хийлээ.

$$n = \frac{N}{1 + N(e)^2}$$

Хэрэглэгдэхүүн: Судалгаанд оролцогчдоос амьдралын чанарыг тодорхойлох хэсгийг SF-36 (Short form 36), Бразил улсын Тиеззи, Мария Фернанда Барбирато нарын (2020) олон хэмжээст асуулгаар судалгааг авлаа. Асуумж нь дараахь бүтэцтэй. Нийгэм хүн ам зүйн хэсэг-10 асуулга. (нас, боловсрол, ам бүлийн тоо,

гэр бүлийн байдал, хөдөлмөр эрхлэлтийн байдал, амьдардаг дүүрэг, гэр бүлийн сарын орлого, хими эмчилгээ хийлгэж байгаа давтамж, хорт хавдрын эмнэл зүйн үе шат, эмчилгээ) судлаач өөрөө зохиосон болно. SF-36 нь (Short form 36) 8 хэмжүүр буюу бүрэлдэхүүн хэсгүүдийг багтаасан 36 зүйлээс бүрдсэн олон хэмжээст асуулгаас бүрдэнэ. Ерөнхий эрүүл мэнд- 2 асуулга, биеийн үйл ажиллагаа, -10 асуулга, биеийн өвдөлт -4 асуулга, сэтгэцийн эрүүл мэнд-3 асуулга, нийгмийн үйл ажиллагаа-4 асуулга, амьдрах чадвар -9, үүрэг сэтгэл хөдлөл- 3 асуулга, үйл ажиллагааны хязгаарлалт- 4 асуулгаас бүрдсэн олон хэмжээст асуулга юм. SF-36 нь хувь хүний эрүүл мэндийн байдлын талаарх ойлголтыг авч үздэг бөгөөд эцсийн оноо нь 0-100 хооронд хэлбэлздэг, 0 нь эрүүл мэндийн хамгийн муу, 100 нь эрүүл мэндийн хамгийн сайн оноо юм. Амьдралын чанарын оноо нь <50 нь муу, <50-90 дунд, <90 –ээс сайн хэмээн үнэлж тодорхойлов.

Мэдээлэл цуглуулах: Судалгаанд Хавдар Судлалын Үндэсний Төвийн өдрийн хими эмчилгээнд үйлчлүүлж байсан 109 эмэгтэйг сонгосон. 16 эмэгтэйг хассан. (9 нь асуумжийг дутуу бөглөсөн, 7 нь татгалзсан.) Судалгаанд нийт 93 эмэгтэй оролцов.

Судалгааны ажлын ёс зүй: Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдээс ОУУБИС-ийн Сувилахуйн ёсзүйн хорооны 2023 оны 12-р сарын 01-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан таниулах зөвшөөрөл, ХСҮТ-ийн зөвлөлийн зөвшөөрлийн хуудсаар зөвшөөрөл авч судалгаанд хамруулсан. (IRB№36).

Мэдээллийн дүн шинжилгээ хийх: Судалгааны үр дүн, өгөгдлийн шинжилгээ хийн мэдээлэл боловсруулахад SPSS-23.0 (Statistical Package for the Social Sciences) программыг ашиглан боловсруулалт хийлээ. Судалгааны үр дүнгийн нарийвчлалын хэмжүүр дундаж, хүчин зүйлийн ялгааг Р утга 0.05-аас бага тохиолдолд статистикийн үнэн магадлалтай гэж тооцов. SF-36-ийн бүрэлдэхүүн хэсэг бүрийн дундаж утга ба стандарт хазайлт, Р утгыг дескриптив шинжилгээ, бүлгүүдийн хооронд нийгэм хүн ам зүйн шинж чанар, амьдралын чанарыг харьцуулан хоёр үл хамаарсан түүврийн Т шалгуур хувьсагчийн шинжилгээгээр тодорхойлж харуулсан болно. Асуумжийн найдвартай, хүчинтэй байдлыг Cronbach-ийн α утга 8-аар баталгаажуулсан.

Судалгааны үр дүн: Судалгаанд оролцогчдын дундаж наслалт 49 ± 0.22 , дийлэнх нь 50-59 насны (35.3%) байлаа. 51.6 хувь нь дээд боловсролтой, 67 хувь гэрлэсэн, хими эмчилгээ 4-ээс удаа хийлгэсэн 74 хувь, хөхний хорт хавдрын эмнэл зүйн

2-р шат (50.5%) оноштой эмэгтэйчүүд хамрагдсан.



Хөхний хорт хавдартай, хими эмчилгээ хийлгэж буй эмэгтэйчүүдийн амьдралын чанарын үр дүн: Хөхний хорт хавдартай, хими эмчилгээ хийлгэж буй эмэгтэйчүүдийн амьдралын чанарыг үнэлэхэд SF-36 (Short form 36) ерөнхий эрүүл мэнд, биеийн үйл ажиллагаа, биеийн өвдөлт, нийгмийн үйл ажиллагаа, амьдрах чадвар, сэтгэцийн эрүүл мэнд зэрэг 8 хэмжүүр буюу бүрэлдэхүүн хэсгүүдийн олон хэмжээст асуулгад шинжилгээ хийж харуулсан болно.

Ерөнхий эрүүл мэндийн судалгааны дүн: Ерөнхий эрүүл мэнд (5 зүйл), эрүүл мэндийн талаарх ерөнхий ойлголтыг хэмждэг, түүний дотор одоогийн эрүүл мэнд, бие бялдрын хүч чадал, эрүүл харагдах байдлыг хэмждэг. Нэг жилийн өмнөхтэй харьцуулахад одоо эрүүл мэндээ ерөнхийд нь юу гэж дүгнэх вэ?- одоо нэг жилийн өмнөхөөс хамаагүй дээр, одоо нэг жилийн өмнөхөөс арай дээрдсэн, өмнөхтэйгөө ижил, нэг жилийн өмнөхөөс арай дордсон, жилийн өмнөхөөс бүр дордсон гэсэн үзүүлэлтээр 2 зүйлд судалгаа хийхэд дараах байдлаар дүгнэжээ. Хүснэгт 1,2-т үзүүлэв.

Хүснэгт 1

Ерөнхий эрүүл мэндийн судалгааны дүн

Үзүүлэлт		Давтамж (%)	Дундаж $\pm$ СХ
Ерөнхий эрүүл мэнд:	Онцгой сайн	1 (0.2)	4.562 $\pm$ 0.724
	Маш сайн	3 (2.2)	
	Сайн	33 (34.4)	
	Боломжийн	62 (63.4)	
	Муу	1 (0.2)	
	P=0.01		

Судалгаанд оролцогчид дийлэнх нь ерөнхий эрүүл мэндийн байдлаа боломжийн (63.4%) байгаа үзсэн байна.

Нэг жилийн өмнөхтэй харьцуулсан эрүүл мэндийн судалгааны дүн

Хүснэгт 2

Үзүүлэлт	Давтамж %	Дундаж $\pm$ СХ
одоо нэг жилийн өмнөхөөс хамаагүй дээр	14 (16.1)	3.456 $\pm$ 0.753
одоо нэг жилийн өмнөхөөс арай дээрдсэн	26 (28)	
өмнөхтэйгөө ижил	28 (30.1)	
нэг жилийн өмнөхөөс арай дордсон	21 (23.7)	
жилийн өмнөхөөс бүр дордсон	2 (2.2)	

Судалгаанд оролцогч эмэгтэйчүүдийн ихэнх нь эрүүл мэндээ өмнөхтэйгээ ижил (30.1%) , одоо нэг жилийн өмнөхөөс арай дээрдсэн (28%) гэж илэрхийлсэн байв.

Биеийн үйл ажиллагаа судалгааны дүн: Биеийн үйл ажиллагаа (10 зүйл) нь усанд орох, хувцаслах гэх мэт бага зэргийн бие махбодийн үйл ажиллагаа, дэлгүүрээс хүнсний бараа өргөх, зөөх зэрэг илүү их ачаалал шаардсан үйлдлүүд, шатаар авирах, эсвэл өгөгдсөн зайд алхах зэрэг өдөрт хийгдсэн үйлдлийн төрөл, тоо хэмжээгээр бие махбодийн асуудлаас шалтгаалсан эрүүл мэндийн хязгаарлалтыг хэмждэг. Биеийн үйл ажиллагааг хязгаарлаж байгаа, тийм бол хэр зэрэг хязгаарладаг байдалд судалгаа хийж тодорхойлон хүснэгт 3-д харуулав.

Хүснэгт 3

Биеийн үйл ажиллагаа судалгааны дүн			
		n	%
Гүйх, хүнд зүйл өргөх, хүнд хүчир спортоор хичээллэх гэх мэт эрч хүчтэй үйл ажиллагаанууд:	бага зэрэг хязгаарлагдмал	43	46.2
	маш их хязгаарлагдмал	28	30.1
	огт хязгаарлагдмал биш	22	23.7
Ширээ хөдөлгөх, тоос сорогч түлхэх, боулинг тоглох гэх зэрэг үйл ажиллагаанууд:	бага зэрэг хязгаарлагдмал	45	48.4
	маш их хязгаарлагдмал	11	11.8
	огт хязгаарлагдмал биш	37	39.8
Хүнс өргөх эсвэл зөөх:	бага зэрэг хязгаарлагдмал	65	69.9
	маш их хязгаарлагдмал	7	7.5
	огт хязгаарлагдмал биш	21	22.6
Шатаар нэгээс дээш давхар өгсөх:	бага зэрэг хязгаарлагдмал	39	41.9
	маш их хязгаарлагдмал	9	9.7
	огт хязгаарлагдмал биш	45	48.4
Шатаар нэг давхар өгсөх:	бага зэрэг хязгаарлагдмал	27	29.0
	маш их хязгаарлагдмал	10	10.8
	огт хязгаарлагдмал биш	56	60.2
Бохирч суух, өвдөг сөгдөх, бөхийх:	бага зэрэг хязгаарлагдмал	30	32.3
	маш их хязгаарлагдмал	14	15.1
	огт хязгаарлагдмал биш	49	52.7
Нэг километр гаруй алхах:	бага зэрэг хязгаарлагдмал	29	31.2
	маш их хязгаарлагдмал	16	17.2
	огт хязгаарлагдмал биш	48	51.6
Хэд хэдэн буудал газар алхах:	бага зэрэг хязгаарлагдмал	44	47.3
	маш их хязгаарлагдмал	22	23.7
	огт хязгаарлагдмал биш	27	29.0



Нэг буудал газар алхах:	бага зэрэг хязгаарлагдмал	28	30.1
	маш их хязгаарлагдмал	12	12.9
	огт хязгаарлагдмал биш	53	57.0
Усанд орох эсвэл хувцаслах:	бага зэрэг хязгаарлагдмал	32	34.4
	маш их хязгаарлагдмал	7	7.5
	огт хязгаарлагдмал биш	54	58.1
нийт		93	100.0
SD±M	53.60+0.896.	оноо 50-75 дунд. *P=0.05	

Судалгаанд оролцогч эмэгтэйчүүдийн дийлэнх нь хязгаарлагдаж байгаа үйл ажиллагаануудаа - гүйх, хүнд зүйл өргөх, хүнд хүчир спортоор хичээллэх гэх мэт эрч хүчтэй үйл ажиллагаанууд (46%), ширээ хөдөлгөх, тоос сорогч түлхэх, боулинг тоглох гэх зэрэг үйл ажиллагаанууд (48.4%), хүнс өргөх эсвэл зөөх (70%), шатаар нэгээс дээш давхар өгсөх (41.9%), хэд хэдэн буудал газар алхах хөдөлгөөн үйл ажиллагаанд (47.3%), усанд орох эсвэл хувцаслах (34.4%) зэрэг хөдөлгөөнд бага зэрэг хязгаарлагдмал байдаг, шатаар нэг давхарт өгсөх нь (60.2%) огт хязгаарлагдмал биш, гүйх, хүнд зүйл өргөх, хүнд хүчир спортоор хичээллэх гэх мэт эрч хүчтэй үйл ажиллагаануудад маш их хязгаарлагдмал (30.1%) байлаа. Үйл ажиллагааны хязгаарлалт нь онооны дунджаар $CX \pm 53.60 + 0.896$. оноо 50-75 дунд гэж тодорхойлогдов. $P=0.05$

Амьдралын чанар- Биеийн өвдөлт судалгааны дүн: (3 зүйл), гэрийн ажил, гэрээсээ гадуур ажиллах үед өвдөлтийг хэмждэг; Сүүлийн 4 долоо хоногийн хугацаанд таны эрүүл мэндээс шалтгаалж ажил болон бусад өдөр тутмын үйл ажиллагаанд дараах асуудлууд тулгарсан уу? - ажил болон бусад үйл ажиллагаанд зарцуулах цагаа багасгасан, хүссэнээсээ бага амжилт гаргасан, ажил болон бусад үйл ажиллагаа хязгаарлагдмал байсан, ажил эсвэл бусад үйл ажиллагааг гүйцэтгэхэд бэрхшээлтэй байсан (нэмэлт хүчин чармайлт шаардсан) тийм, үгүй асуулт үзүүлэлтээр шинжилж хүснэгт 4-д харуулав.

Хүснэгт 4

Биеийн өвдөлт судалгааны дүн

Үзүүлэлт	Давтамж %		Дундаж ± СХ
	Тийм	үгүй	
Ажил болон бусад үйл ажиллагаанд зарцуулах цагаа багасгасан	64. 68.8%	29. 31.2%	3.51±0.452
хүссэнээсээ бага амжилт гаргасан	63. 67.7%	30. 32.3%	1.96±0.562

ажил болон бусад үйл ажиллагаа хязгаарлагдмал байсан	60. 64.5%	33. 35.5%	2.29±0.869
Ажил эсвэл бусад үйл ажиллагааг гүйцэтгэхэд бэрхшээлтэй байсан (нэмэлт хүчин чармайлт шаардсан)	65. 69%	28. 30.1%	2.19±0.962
SD+M. 62.26+0.968.			
Оноо: Дунд 79-40			

Судалгаанд оролцогч эмэгтэйчүүдийн дийлэнх нь биеийн эрүүл мэндийн асуудлаа ажил эсвэл бусад үйл ажиллагааг гүйцэтгэхэд бэрхшээлтэй байсан (нэмэлт хүчин чармайлт шаардсан (69%), ажил болон бусад үйл ажиллагаанд зарцуулах цагаа багасгасан (31.2%) гэж үзсэн байна. Онооны дүнгээр Дунд 79-40 үзүүлэлттэй тодорхойлогдов.

Сэтгэцийн эрүүл мэндийн судалгааны дүн: Сэтгэцийн эрүүл мэнд (5 зүйл), энэ нь сэтгэлийн түгшүүр, сэтгэлийн хямрал, зан үйлийн болон сэтгэл хөдлөлийн хувьд хяналтаа алдах, сэтгэл зүйн сайн сайхан байдал зэрэг сэтгэцийн эрүүл мэндийг хэмждэг. Өнгөрсөн 4 долоо хоногийн хугацаанд сэтгэл санааны ямар нэг асуудал (сэтгэл гутрал, түгшүүр гэх мэт)-ын үр дүнд таны ажил, өдөр тутмын бусад үйл ажиллагаанд асуудал тулгарсан уу? ажил болон бусад үйл ажиллагаанд зарцуулах цагаа багасгасан, ажил дээрээ хүссэнээсээ бага амжилт гаргасан, ажил эсвэл бусад үйл ажиллагаа хязгаарлагдмал байсан тийм, үгүй асуулт үзүүлэлтээр шинжилж хүснэгт 5-д үзүүлэв.

Хүснэгт 5

Сэтгэцийн эрүүл мэндийн судалгааны дүн

Үзүүлэлт	Давтамж %		Дундаж ± СХ
	Тийм	Үгүй	
Ажил болон бусад үйл ажиллагаанд зарцуулах цагаа багасгасан	62. 66.7%	31. 33.3%	2.58±0.592
хүссэнээсээ бага амжилт гаргасан	64. 68.8%	29. 31.2%	2.37±0.624
Ажил эсвэл бусад үйлдлүүдийг ердийнх шиг анхааралтай хийгээгүй	54. 58.1%	39. 41.9	2.32±1.522
SD+M. 57.48+0.896. оноо. Дунд 79-40			

Сэтгэцийн эрүүл мэндийн шинжилгээний үр дүнгээс оролцогч эмэгтэйчүүд өнгөрсөн 4 долоо хоногийн хугацаанд хүссэнээсээ бага амжилт гаргасан(68.8%) гэж хариулжээ. Онооны дүнгээр Дунд 79-40 үзүүлэлттэй байна. SD+M. 57.48+0.896

Нийгмийн үйл ажиллагаа судалгааны дүн: Нийгмийн үйл ажиллагаа (2 зүйл), нийгмийн үйл ажиллагааны тоо хэмжээ, чанар, бие махбодийн болон сэтгэл санааны асуудлын нийгмийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөг хэмждэг. Таны



гэр бүл, найз нөхөд, хөршүүд эсвэл таньдаг хүмүүстэйгээ харилцах хэвийн үйл ажиллагаанд сэтгэл хөдлөлийн асуудал саад болсон уу?, сүүлийн 4 долоо хоногт таны бие хэр их өвдөж байсан бэ?, өнгөрсөн 4 долоо хоногт өвдөлт таны хэвийн ажилд (гэрээсээ гадуурх ажил, гэрийн ажил зэрэг) хэр зэрэг саад болсон бэ ? үзүүлэлтүүдийн ялгаатай байдлыг нэг чиглэлийн ANOVA аргаар шалгаж үр дүнг хүснэгт 6-д харууллаа.

Хүснэгт 6

Нийгмийн үйл ажиллагаа

Үзүүлэлт	Дундаж $\pm$ CX	F	Sig
Таны гэр бүл, найз нөхөд, хөршүүд эсвэл таньдаг хүмүүстэйгээ харилцах хэвийн үйл ажиллагаанд сэтгэл хөдлөлийн асуудал саад болсон уу ?	1.21 $\pm$ 0.902	8.266	0.000
Сүүлийн 4 долоо хоногт таны бие хэр их өвдөж байсан бэ ?	1.88 $\pm$ 0.997	1.252	0.888
Сүүлийн 4 долоо хоногт өвдөлт таны хэвийн ажилд (гэрээсээ гадуурх ажил, гэрийн ажил зэрэг) хэр зэрэг саад болсон бэ ?	1.74 $\pm$ 0.972	5.680	0.323
SD+M. 49.5+0.897			
Оноо. 50-100 муу P<0.05			

Нэг чиглэлийн ANOVA шинжилгээний дүнгээс үзвэл гэр бүл, найз нөхөд, хөршүүд эсвэл таньдаг хүмүүстэйгээ харилцах хэвийн үйл ажиллагаанд сэтгэл хөдлөлийн асуудал саад болсон үзүүлэлт нь статистикийн ач холбогдолтой байна. (F=8.266, P=0.000), харин сүүлийн 4 долоо хоногт бие их өвдсөн статистикийн ач холбогдолгүй байна. (F=1.252, P=0.888).

А.Ч- Амьдрах чадвар судалгааны дүн: Амьдрах чадвар (4 зүйл), эрч хүч, ядрах түвшинг хэмждэг. Сүүлийн 4 долоо хоног ямар мэдрэмж, ямар байдалтай байсан тухай Сэтгэл хангалуун байсан, маш их сандарч байсан, юу ч тайвшруулж чадахгүй болтлоо гутарсан, тайван амар амгаланг мэдэрсэн, маш их энерги эрч хүчтэй байсан, сэтгэлээр унаж цөхрөөд байсан, ядарсан мэт санагдсан, аз жаргалтай хүн байсан, ядарч туйлдсан үзүүлэлтээр судалж хүснэгт 7 -д үзүүлэв.

Хүснэгт 7

Амьдрах чадвар

Үзүүлэлт	Давтамж %	Дундаж $\pm$ CX
Сэтгэл хангалуун байсан	26 (28)	2.68 $\pm$ 1.002
Маш их сандарч байсан	27 (29)	2.75 $\pm$ 0.868

Юу ч тайвшруулж чадахгүй болтлоо гутарсан	33 (35.5)	2.61±1.198
Тайван амар амгаланг мэдэрсэн	33 (35.5)	3.19±0.947
Маш их энерги эрч хүчтэй байсан	36 (38.7)	2.43±0.914
Сэтгэлээр унаж цөхрөөд байсан	32 (34.4)	2.99±1.005
Ядарсан мэт санагдсан	49 (52.7)	2.01±0.952
Аз жаргалтай хүн байсан	35 (36.7)	2.68±0.520
Ядарч туйлдсан	39 (41.7)	2.75±0.984
SD+M. 36.85+0.975 Оноо: 25-49 муу.		
P<0.05		

Судалгаанд оролцогч эмэгтэйчүүд сүүлийн 4 долоо хоногт эрч хүч, сэтгэл хөдлөлийн байдлаа ихэнх нь ядарсан мэт санагдсан (52.7%), ядарч туйлдсан (41.7%) гэж хариулсан байв. Онооны дундаж үнэлгээ нь муу үзүүлэлттэй тодорхойлогдов. оноо: 25-49 муу, P<0.05.

Хөхний хорт хавдартай хими эмчилгээ хийлгэж буй эмэгтэйчүүдийн амьдралын чанарын үнэлгээ

Хүснэгт 8

Амьдралын чанар		Асуулгын тоо	Стандарт хазайлт	Их утга	Бага утга
1	Ерөнхий эрүүл мэнд	2	0.982	5	2
2	Биеийн үйл ажиллагаа	10	0.856	5	1
3	Биеийн өвдөлт	4	1.259	5	1
4	Сэтгэцийн эрүүл мэнд	3	1.368	5	1
5	Нийгмийн үйл ажиллагаа	3	1.528	5	1
6	Амьдрах чадвар	9	0.982	5	2
7	Үйл ажиллагааны хязгаарлалт	1	1.704	5	2
8	Үүрэг, сэтгэл хөдлөл	4	1.759	5	1
Нийт		36			

Судалгаанд оролцогч эмэгтэйчүүдийн амьдралын чанарыг 36-Зүйлийн богино маягт (Short form -36) олон хэмжээст асуулгаар шинжилж үзэхэд хамгийн их утгатай нь бүх 8 зүйл, хамгийн бага утгатай нь үйл ажиллагааны хязгаарлалт, биеийн өвдөлт, сэтгэцийн эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа, ерөнхий эрүүл мэнд байгааг судалгааны үр дүн харууллаа.



Хөхний хорт хавдартай хими эмчилгээ хийлгэж буй эмэгтэйчүүдийн амьдралын чанарын онооны үнэлгээний дүн

Хүснэгт 9

	SD+M	Хүрээ	Оноо	Үнэлэмж
Ерөнхий эрүүл мэнд	65.52+0.956	1,2 , 20, 22, 34-36	100-75	Сайн
			24-50	Дунд
			0-25	Муу
Биеийн үйл ажиллагаа	53.60+0.896	3-12.	0-49	Муу
			50-75	Дунд
			76-100	Сайн
Биеийн өвдөлт	62.26+0.968	13-19	100-80	Сайн
			79-40	Дунд
			39-0	Муу
Сэтгэцийн эрүүл мэнд	57.48+0.896	21, 23, 26-27, 30	100-80	Сайн
			79-40	Дунд
			39-0	Муу
Нийгмийн үйл ажиллагаа	49.5+0.897	32-33, 35	0-24	Сайн
			25-49	Дунд
			50-100	Муу
Амьдрах чадвар	36.85+0.975	24, 25, 28-31	0-24	Сайн
			25-49	Дунд
			50-100	Муу
Үйл ажиллагааны хязгаарлалт	56.48+0.896	22, 24, 31-36.	100-80	Сайн
			79-40	Дунд
			39-0	Муу
Үүрэг, сэтгэл хөдлөл	36.85+0.975	29-33	0-24	Сайн
			25-49	Дунд
			50-100	Муу

Амьдралын чанарыг дундаж оноогоор харьцуулан үнэлэж үзэхэд сайн үнэлэмжтэй нь ерөнхий эрүүл мэнд , нийгмийн үйл ажиллагаа, амьдрах чадвар, үүрэг сэтгэл хөдлөл нь муу үнэлэмжтэй байв.

Бид оролцогчдын нийгэм хүн ам зүйн шинж чанарыг үндэслэн боловсрол, хорт хавдрын эмнэлзүйн шат зэрэг үзүүлэлтээр амьдралын чанарын 36-Зүйлийн богино маягт (Short form 36) нь биеийн эрүүл мэнд, бие махбодийн үйл ажиллагаа, сэтгэл хөдлөлийн асуудлаас шалтгаалсан үйл ажиллагааны хязгаарлалт, нийгмийн үйл ажиллагаа, эрч хүч, бие махбодийн өвдөлт, сэтгэлийн эрүүл мэндийн асуудал, эрч хүч, сэтгэл хөдлөл эрүүл мэндийн хамаарлыг тодорхойлох зорилгоор хоёр үл хамаарсан түүврийн Т шалгуур хувьсагчийн шинжилгээ хийхийг хичээв.

Хөхний хорт хавдартай хими эмчилгээ хийлгэж буй эмэгтэйчүүдийн хүн ам зүй, амьдралын чанарын хоёр үл хамаарсан түүврийн Т шалгуур хувьсагчийн шинжилгээ

Хүснэгт 10

	n	Эрүүл мэнд	Биеийн үйл ажиллагаа	Өвдөлт	Сэтгэцийн эрүүл мэнд	Нийгмийн үйл ажиллагаа	Амьдрах чадвар
Боловсрол		SD+M	SD+M	SD+M	SD+M	SD+M	SD+M
бага	24	51.92±5.85	51.92±22.76	31.15±17.04		41.54±19.53	43.96±15.54
Бүрэн дунд	21	55.30±4.66	55.30±21.52	37.09±18.29	50.26±22.79	48.00±32.30	46.23±16.51
дээд	48	53.65±21.51	53.65±21.51		44.87±23.85	43.77±28.96	44.09±17.41
Р утга			0.05	0	0.03	0.05	0.02
эмнэлзүйн шат		SD+M	SD+M	SD+M	SD+M	SD+M	SD+M
0 шат	3	30.9±18.68	53.3±28.69	29.9±18.0	64.94±30.21		45.78±19.15
1 шат	14		53.65±21.51	32.66±17.01	44.87±23.85	43.77±28.96	40.79±16.64
2 шат	48	35.00±17.39	55.42±25.14	35.00±17.39	51.33±25.01	51.00±25.21	
3 шат	25	38.44±12.58	58.52±24.26		53.02±28.18	55.11±32.23	49.37±20.35
4 шат	8	36.58±81.88					
Р утга			0.05*	0.002	0.970	0.05	0.02

Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин ба эмнэлзүйн үе шатыг SF-36 олон хэмжээст асуулгатай харьцуулан үзэхэд статистикийн ач холбогдолтой байв. ($P<0.05$)

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Энэхүү судалгаагаар хөхний хорт хавдартай хими эмчилгээ хийлгэж буй эмэгтэйчүүдийн амьдралын чанарыг тодорхойлж судласан. Бидний судалгаанд хамрагдсан оролцогчдын дундаж нас 52.29 ± 11.64 буюу 30-75.0 жил байсан нь Грек улсын судлаачдын (Алагизы, Солтан Египет 2020) судалгаанд хамрагдсан оролцогчдын насны бүтэцтэй ойролцоо байна. Хөхний хорт хавдартай өвчтөнүүдийн амьдралын чанар бага байгааг олон судалгаагаар тогтоосон. Судлаачид гэр бүлийн байдал, орлого, нас, боловсролын байдал зэрэг эдгээр өвчтөнүүдийн амьдралын чанартай холбоотой хүчин зүйлсийг тодорхойлсон байдаг. Гэсэн хэдий ч



Монголд хөхний хорт хавдартай, хими эмчилгээ хийлгэж буй эмэгтэйчүүдийн амьдралын чанарыг тодорхойлох хүчин зүйлсийн хамаарлыг хомс судалсан байна. Амьдралын чанар нь хөхний хорт хавдартай өвчтөнүүдийн эмчилгээний үр дүнгийн хэмжүүрүүдийн нэг юм. Судалгаанд оролцогчдын бие махбодийн үйл ажиллагаа муу, сэтгэл хөдлөлийн асуудлаас болж үүрэг хязгаарлагдмал, нийгмийн үйл ажиллагаа сул гэж гарсан үр дүн (Анвар Е Ахмед, Абдулрахман, Алхарби, Моханнад Алсадхан, Алаа С Альмузайни. Саудын Араб. 2016.) судалгааны үр дүнтэй ойролцоо байна. Турк улсад 2017 онд хийгдсэн (Тиеззи, Мария Фернанда Барбирато да Мата МС; де Андраде, Журандир Морейра) судалгаагаар хөхний хорт хавдрын эмчилгээ хийлгэсэн эмэгтэйчүүдийн SF-36-ийн бүх салбарт, ялангуяа бие махбодийн үүрэг (62.5%), биеийн өвдөлт (45%), сэтгэл хөдлөлийн үүрэг (43.8%) зэрэгт оноо буурсан нь судалгааны үр дүнтэй ижил байв. Хими эмчилгээ хийлгэж буй эмэгтэйчүүдийн SF-36-ийн Физик үйл ажиллагааны домайны бага оноо нь гүйх, хүнд зүйл өргөх, шатаар авирах, өвдөг сөгдөх, хэд хэдэн блок алхах, усанд орох зэрэг өдөр тутмын үйл ажиллагаанд тэдний хязгаарлалт илэрсэн нь бидний судалгаатай ойролцоо байсан. Энэхүү судалгааны хязгаарлагдмал тал нь нэгдүгээрт амбулаториор өдөрөөр эмчлүүлж байсан эмэгтэйчүүдийн амьдралын чанарыг тодорхойлсон, хоёрдугаарт үйлчлүүлэгчдийн амьдралын чанарын эрсдэлт хүчин зүйлийг цогцоор судлаагүйд байж болох юм. Цаашид энэхүү судалгааг өргөжүүлэн хими эмчилгээ хийлгэж буй хөхний хорт хавдартай үйлчлүүлэгчдийн сэтгэл зүйн тусламжийг багаар үзүүлж туршилт судалгаагаар дагаж судлах, хамтран хийх, амьдралын чанарыг дээшлүүлэх нотолгоог бий болгох хэрэгцээ хавдрын сувилахуйн тусламж үйлчилгээнд шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Хөхний хорт хавдартай хими эмчилгээ хийлгэж буй эмэгтэйчүүдийн амьдралын чанар судалгаа шинжилгээ хийснээр дараах дүгнэлтийг хийж байна. Эдгээр нь:

- Хөхний хорт хавдартай хими эмчилгээ хийлгэж буй эмэгтэйчүүдийн биеийн үйл ажиллагаа, сэтгэцийн эрүүл мэнд дунд, амьдрах чадвар эрч хүч, сэтгэл хөдлөл нь муу байгааг SF-36 судалгааны үр дүн харууллаа.
- Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин ба эмнэлзүйн үе шатыг SF-36-тай харьцуулан үзэхэд статистикийн ач холбогдолтой байна. ($P < 0.01$)
- Судалгаанд оролцогчдын бие махбодийн үйл ажиллагаа, амьдрах чадварыг

сайжруулахад эрүүл мэндийн боловсролын арга хэмжээ, нөхөн сэргээлт зэрэг олон талт арга барил шаардлагатай байгааг харуулж байна.

- Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхэд сувилагч чухал үүрэг гүйцэтгэж чадна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Сувилагч нар хими эмчилгээний дараах биеийн байдлын талаар иж бүрэн мэдээлэл өгөх,
- Сувилагч нар өвчний талаар практик мэдээллээр хангах, эмэгтэйчүүдийн хэрэгцээг танин мэдэх, амьдралын хэв маягийг өөрчлөх талаар зөвлөгөө өгөх,
- Өвчтөний гэр бүлийнхэнд мэргэжилтний зөвлөгөө өгөх, шалтгааныг тайлбарлах,
- Өвчтөн, эмч хоёрын харилцаа холбоог хөнгөвчлөх.
- Хөхний хорт хавдартай хими эмчилгээ хийлгэж буй үйлчлүүлэгчдийн сэтгэл зүйн тусламжийг багаар үзүүлэх.
- Хавдрын сувилахуйн тусламжийг сайжруулах.

НОМ ЗҮЙ

- Mejía-Rojas, M. E., Contreras-Rengifo, A., & Hernández-Carrillo, M. [2020] Quality of life in women treated with chemotherapy for breast cancer in Cali, Colombia. *Bio-medica : revista del Instituto Nacional de Salud*, 40(2) 349–361.
- Aldaak, M., Suliman, H. M., Abd-Elgadir, E. E., & Abdoon, I. H. [2022] Impact of anticancer therapy on the quality of life of Sudanese patients with breast cancer at Khartoum oncology hospital. *BMC women's health*, 22(1), 448.
- Yusoff, J., Ismail, A., Abd Manaf, M. R. et al. [2022] Quality of life of women with breast cancer in a tertiary referral university hospital. *Health Qual Life Outcomes* 20.
- Та Ж, Лу Q. [2014] Хятад хэлээр ярьдаг хөхний хорт хавдраас амьд үлдсэн хүмүүсийн нийгмийн хязгаарлалт ба амьдралын чанар: зуучлалын загвар. *Qual Life Res*, 23(9):2577–2584.
- Лара ЛА, де Андраде ЖМ, Консоло ФД, Ромао АР. [2012] Эмэгтэйчүүдийн хорт хавдрыг эмчилсний дараах бэлгийн амьдралын сэтгэл хангалуун бус



байдал.Clin J Oncol Nurs.16:273–277.

- Патерсон КЛ, Ленгахер СА, Донован КА, Кип КЭ, Тофтхаген CS.[2016] Хөхний хорт хавдраас амьд үлдсэн залуу хүмүүсийн биеийн дүр төрх: системчилсэн тойм. Хорт хавдрын сувилагч .39(1):E39–E58.

